



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-31
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	

1.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	33-36
2.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	36-61
3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	62-64 81-83
4.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	65-75
5.“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	75
6.“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	76-80
7.Хуулийн төслийг эцэслэн батлах	83-84
8.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/	84-97
9.Хуулийн төслийг эцэслэн батлах	97-100
10.“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/	100-101
11.“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	101-103л

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 10-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 15 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Д.Өнөрболор, Ч.Ундрал, Н.Энхболд;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, Ж.Ганбаатар, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;

Хоцорсон: Ц.Анандбазар- 50 минут, С.Батболд- 1 цаг 59 минут, Х.Булгантуяа- 20 минут, Н.Ганибал- 13 минут, Г.Дамдинням- 3 цаг 09 минут, Б.Жавхлан- 2 цаг 30 минут, Ц.Мөнх-Оргил- 23 минут, Ц.Мөнхцэцэг- 26 минут, С.Одонтуяа- 11 минут, Д.Сарангэрэл- 11 минут, Ц.Туваан- 1 цаг 31 минут, Н.Учрал- 3 цаг 09 минут, Д.Цогтбаатар- 42 минут, Б.Энхбаяр- 18 минут, Ж.Эрдэнэбат- 38 минут;

Тасалсан: А.Адъяасүрэн, Г.Амартүвшин, Г.Ганболд, Ц.Сэргэлэн.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв.

Нэг.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хариулж, тайлбар хийв.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон” гэсний дараа “амаржсаны,” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Цэргийн алба хаагч эмэгтэйн энэ хуулийн 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэлийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр тооцох санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ш.Раднаасэд, Б.Баттөмөр, Ж.Чинбүрэн, Ц.Идэрбат, Н.Ганибал, Б.Бейсен, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Т.Аубакир, С.Одонтуяа нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 18

Бүгд: 49

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн нар хариулж, тайлар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 2 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 2 цагийн завсарлага өгөв./12:21/

Дөрөв. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Туваан, С.Батболд, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос гаргасан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороо дахин хийх талаар горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д заасны дагуу санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж хэлэлцүүлэх горимын санал гаргав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гарсан талаар мэдэгдэж, хэлэлцэхээр тогтов.

Зургаа. “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 13 цаг 25 минутад түр завсарлаж, 15 цаг 14 минутаас үргэлжлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяшаагаас Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд хандаж “Ховд аймгийн Мянгад сумын нутаг дахь газрын ховор элементийн Халзан бүрэгтэйн орд газрын талаар” тавьсан асуулгын талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас 2023.11.07-ны өдөр ирүүлсэн албан бичгийг танилцуулж, уг асуулгын хариуг хойшлуулсан талаар мэдэгдэв./15:15/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв./15:19/

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Н.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	10
Бүгд:	55

81.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай

**Нэгдүгээр бүлэг
Нийтлэг үндэслэл**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 10
Бүгд: 53
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2 дугаар зүйл.Монгол Улсын 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 10
Бүгд: 53
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёрдугаар бүлэг Монгол Улсын 2024 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Их Хурлын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0 100.0
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0 510.0
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,737.7 2,737.7
5	Монгол Улсын Ерөнхий сайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар үүнээс: Ирээдүйн өв санд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	648,431.7 644,002.5 520,083.2 4,429.2
6	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	15,941.5 15,941.5

7	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	132.6 132.6
8	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175.0 175.0
9	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,485.5 1,485.5
10	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд	6,000.0 6,000.0
11	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд үүнээс: Ирээдүйн өв санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	18,181,474.2 10,675,146.9 513,710.9 833,224.2 6,727,915.6 211,194.0 558,000.0 9,217.6
12	Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	83,749.0 45,000.0 2,700.0 1,552.9 34,496.1
13	Батлан хамгаалахын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	38,185.4 38,185.4
14	Боловсрол, шинжлэх ухааны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,857.9 5,857.9
15	Зам, тээврийн хөгжлийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн хөгжлийн яам Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175,300.0 150,000.0 300.0 25,000.0
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Үндэсний геологийн алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	426,173.4 421,903.3 110.0 4,160.2
17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54,588.5 54,588.5
18	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	38,454.4 850.0 2,535.1 35,069.3
19	Эрүүл мэндийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,555.4 5,555.4
20	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,665.5 8,665.5

Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 16
Бүгд: 53
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4 дүгээр зүйл. Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 18,359,777.4 сая төгрөг байна. Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд Үүнээс “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дүрмийн санд	437,311.2 83,673.5
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,600.7
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	30,000.0
4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	22,758.8
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	10,286.9

Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 12
Бүгд: 53
77.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

6.1. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал	29,711.3 29,711.3
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	132,712.7 110,623.1 22,089.6
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	4,253.4

	Урсгал зардал	4,253.4
4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	29,070.1
	Урсгал зардал	17,541.3
	Хөрөнгийн зардал	11,528.8
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	165,500.3
	Урсгал зардал	145,675.3
	Хөрөнгийн зардал	19,825.0
6	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	5,117.2
	Урсгал зардал	5,117.2
7	Улсын ерөнхий прокурор	110,621.1
	Урсгал зардал	99,272.8
	Хөрөнгийн зардал	11,348.3
8	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	18,849.9
	Урсгал зардал	18,849.9
9	Монгол Улсын Ерөнхий аудитор	41,435.6
	Урсгал зардал	40,554.5
	Хөрөнгийн зардал	881.1
10	Авлигатай тэмцэх газрын дарга	48,006.0
	Урсгал зардал	45,347.9
	Хөрөнгийн зардал	2,658.2
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	14,727.6
	Урсгал зардал	13,835.1
	Хөрөнгийн зардал	892.5
12	Төрийн албаны зөвлөлийн дарга	6,108.1
	Урсгал зардал	6,108.1
13	Үндэсний статистикийн хорооны дарга	21,217.7
	Урсгал зардал	21,217.7
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	63,976.8
	Урсгал зардал	63,976.8
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	8,314.6
	Урсгал зардал	8,314.6
16	Монгол Улсын Ерөнхий сайд	340,128.1
	Урсгал зардал	300,519.0
	Хөрөнгийн зардал	39,609.0
17	Монгол Улсын Шадар сайд	291,364.5
	Урсгал зардал	246,797.1
	Хөрөнгийн зардал	44,567.4
18	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	87,294.6
	Урсгал зардал	18,294.6
	Хөрөнгийн зардал	69,000.0
19	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	117,216.7
	Урсгал зардал	65,825.3
	Хөрөнгийн зардал	51,391.4

20	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	256,548.7 219,611.4 36,937.3
21	Гадаад харилцааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	191,067.2 177,367.2 13,700.0
22	Сангийн сайд Урсгал зардал үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	4,506,557.2 2,498,781.0 1,173,620.2 224,776.2 1,783,000.0
23	Хууль зүй, дотоод хэргийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,394,322.8 1,267,135.0 127,187.7
24	Зам, тээврийн хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	692,173.9 23,694.3 668,479.6
25	Батлан хамгаалахын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	562,839.1 542,823.8 20,015.3
26	Боловсрол, шинжлэх ухааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	4,227,177.2 3,482,306.4 744,870.7
27	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	59,929.9 19,929.9 40,000.0
28	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	549,076.2 425,487.9 123,588.3
29	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	3,945,272.0 3,896,513.9 48,758.1
30	Эрүүл мэндийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,634,404.0 1,353,325.0 281,079.0
31	Эрчим хүчний сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	335,356.1 111,070.1 224,286.0
32	Барилга, хот байгуулалтын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	415,704.8 10,411.8 405,293.0
33	Соёлын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	397,751.1 242,870.1 154,881.0
34	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Урсгал зардал	86,295.6 69,872.6

	Хөрөнгийн зардал	16,423.0
35	Шүүхийн сахилгын хорооны дарга Урсгал зардал	4,183.2 4,183.2
36	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	144,591.8 72,238.4 72,353.4
37	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	11,176.3 5,713.2 5,463.1
38	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Хөрөнгийн зардал	56,229.2 56,229.2

6.2. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	182,210.5
	Үүнээс: Хөдөөгийн сэргэлт- Амьдралын чанар	98,537.0
2	Барилга, хот байгуулалтын сайд	5,000.0
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	31,036.3
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	50,285.5

Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 18
Бүгд: 53
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 20,753,857.3 сая төгрөг байна. Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 16
Бүгд: 53
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 3,359,350.2 сая төгрөгөөр санхүүжүүлнэ. Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 14
Бүгд: 53
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9 дүгээр зүйл. “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд 25,000.0 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 13
Бүгд: 53
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10 дугаар зүйл. 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 1,231,447.7 сая төгрөг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2024 оны төсвийн жилд 513,710.9 сая төгрөг хуримтлуулна. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11 дүгээр зүйл. 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,788,332.7 сая төгрөг байна. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2024 оны төсвийн жилд 1,353,307.4 сая төгрөг хуримтлуулна. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

12.1. Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.6 болон 28¹.1-д заасан зориулалтаар хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээг 3,414,050.7 сая төгрөг хүртэл;

12.2. Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1,225,000.0 сая төгрөг хүртэл. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13 дугаар зүйл. Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2024 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 3,286,546.7 сая төгрөг байна. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 13

Бүгд: 53
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14 дүгээр зүйл.Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2024 оны төсвийн жилд 3,550,000.0 сая төгрөг байна. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 14
Бүгд: 53
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15 дугаар зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2 болон 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Гуравдугаар бүлэг

Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг

16 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	36,320.0
2	Баян-Өлгий	25,670.8
3	Баянхонгор	38,421.5
4	Булган	11,070.4
5	Говь-Алтай	33,672.2
6	Дундговь	27,041.0
7	Завхан	37,893.3
8	Өвөрхангай	33,070.5
9	Сүхбаатар	11,815.3
10	Төв	19,741.7
11	Увс	34,144.2
12	Ховд	15,014.7
13	Хөвсгөл	43,617.0
14	Хэнтий	39,282.5
15	Говьсүмбэр	6,788.5
Нийт дүн		413,563.4

Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 17
Бүгд: 53
67.9 хувийн саналаар дэмжигдлээ.

17 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	9,331.2
2	Дорнод	2,976.5
3	Өмнөговь	719,881.4
4	Сэлэнгэ	1,363.3
5	Дархан-Уул	658.2
6	Улаанбаатар	230,261.5
7	Орхон	179,620.9
Нийт дүн		1,144,093.1

Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 16
Бүгд: 53
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	12,118.9
2	Баян-Өлгий	11,406.6
3	Баянхонгор	20,660.6
4	Булган	13,601.6
5	Говь-Алтай	16,592.9
6	Дорноговь	41,298.3
7	Дорнод	24,783.3
8	Дундговь	15,244.6
9	Завхан	14,040.3
10	Өвөрхангай	13,854.9
11	Өмнөговь	45,585.0
12	Сүхбаатар	17,474.9
13	Сэлэнгэ	26,529.0
14	Төв	27,155.9

15	Увс	12,477.3
16	Ховд	28,053.0
17	Хөвсгөл	15,990.5
18	Хэнтий	17,789.1
19	Дархан-Уул	19,834.2
20	Улаанбаатар	47,781.3
21	Орхон	33,099.6
22	Говьсүмбэр	6,704.8
Нийт дүн		482,076.7

Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 12
Бүгд: 53
77.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөвдүгээр бүлэг Бусад зүйл

19 дүгээр зүйл.“Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 14
Бүгд: 53
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20 дугаар зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 14
Бүгд: 53
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21 дүгээр зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 14
Бүгд: 53
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 14
Бүгд: 53
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 12
Бүгд: 53
77.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Л.Мөнхбаатар: Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 17
Бүгд: 53
67.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 22
Бүгд: 53
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёрдугаар бүлэг Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн орлого, зарлага

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	5,893,277.1
	1.1 Ажил олгогчийн төлөх шимтгэл	2,563,916.6
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	1,833,539.5
	1.3 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	21,034.5
	1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	237.9
	1.5 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	258,491.7
	1.6 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	4,954.0
	1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,809.1
	1.8 Бусад орлого	33,319.8
	1.9 Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	1,174,974.0
	Нийт орлого	5,893,277.1

Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 11
Бүгд: 52
78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	67,232.2

Санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 14
Бүгд: 52
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	5,188,403.3
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	4,741,061.0
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	262,434.5
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	61,900.1
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	123,007.7
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	0.0

1.6 Даатгуулагчид буцаан олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	0.0
Нийт зарлага	5,188,403.3

Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 12
Бүгд: 52
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 13
Бүгд: 52
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 9
Бүгд: 52
82.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 11
Бүгд: 52
78.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Л.Мөнхбаатар: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай

**Нэгдүгээр бүлэг
Нийтлэг үндэслэл**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 12
Бүгд: 53
77.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Л.Мөнхбаатар: 2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёрдугаар бүлэг

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн орлого, зарлага

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,964,757.3
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	859,154.8
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	324,113.0
	1.3 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	746,804.8
	1.4 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	34,684.8
	Нийт орлого	1,964,757.3

Санал хураалт явуулъя.
Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 13
Бүгд: 53
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	-85,000.0

Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 12
Бүгд: 52
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5 дугаар зүйл. 2024 он төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,933,171.6
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	887,716.8
	1.2 Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	837,652.6
		137,322.8
	1.3 Эмийн санд олгох	
	1.4 Үйл ажиллагааны урсгал зардал	16,916.7
	1.5 Эрсдэлийн сан	53,562.6
	Нийт зарлага	1,933,171.6

Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 10
Бүгд: 52
80.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 11
Бүгд: 52
78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 8
Бүгд: 53
84.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Н.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй

Холбогдүүлэн боловсруулсан:

Л.Мөнхбаатар: 1. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 9
Бүгд: 53

83.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 12
Бүгд: 53

77.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 13
Бүгд: 53
75.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 15
Бүгд: 53
71.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53
79.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 8
Бүгд: 53
84.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 8
Бүгд: 53
84.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 10
Бүгд: 53

81.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 10
Бүгд: 53

81.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 16
Бүгд: 53

69.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 9
Бүгд: 53

83.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 13

Бүгд: 53

75.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 10

Бүгд: 53

81.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

21.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

22.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

23.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 11

Бүгд: 52

78.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

24.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 9

Бүгд: 52

82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

25.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 9

Бүгд: 52

82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

26.“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

27.“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 9

Бүгд: 52

82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 16 цаг 48 минутад түр завсарлаж, 17 цаг 09 минутаас үргэлжлэв.

Арав.“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Н.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 19
Бүгд: 53
64.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Н.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Хавдар судлалын үндэсний төвийн 2 дугаар барилгын нэмэлт хөрөнгө оруулалтыг 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусган хэрэгжүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 17
Бүгд: 53
67.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

“8/улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих бүх шатны эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний барилга байгууламжийн жишиг зургийг хөгжлийн

бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэйгээр стандартад нийцүүлэн шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 19
Бүгд: 54
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Л.Энх-Амгалан, Ч.Хүрэлбаатар нарын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах ажлыг” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 20
Бүгд: 54
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж “ЖДҮ, Хөгжлийн банк, Нүүрсний хулгай, Оффтейк гэрээ, Төмөр замын хулгай, Боловсролын зээлийн сан, Ногоон автобусны луйвар-хариуцлага тооцооч ээ” гэсэн лоозон байрлуулсан байв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Төмөр замын татах хэсгийн ашиглалтын хэлтсийн ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 6 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Баянхонгор аймгийн Баянбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ундрэм, Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн урилгаар Ховд аймгийн Ховд сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, “Отгонтэнгэр” их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн хөтөлбөрийн 1, 2 дугаар дамжааны оюутнууд, “Петровис” компанийн 21 аймгийн салбар зөвлөлийн удирдах ажилтнууд, Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1993 оны төгсөгчид, Баянхонгор аймгийн Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 56 минут үргэлжилж, 72 гишүүнээс 59 гишүүн хүрэлцэн ирж, 82.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 15 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

Их Хурлын гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг хийнэ.

2-т, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэхийг шийднэ.

3-т, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

4-т нь, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 2024 оны төсвийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан тогтоолын төслийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлэг.

5-д, “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлэг, зарчмын зөрөөтэй 2 саналтай.

Үдээс хойших хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаагаас Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Амарбаясгаланд хандаж тавьсан асуулгын хариуг сонсоно. Ийм асуудлуудыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж албан бичиг ирүүлсэн байна. Албан бичгийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Миний бие 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гэсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Уулзалт хийгээд, би энэ жил нийтдээ 81, хоёр уулзалт хийсэн байгаа. Дахиад оны эцсээр бас нэлээн хэдэн уулзалт хийнэ. Энэ уулзалт болгон дээр гарч байгаа ганцхан л зүйл байгаа. Энэ янз янзын хулгайнууд их хийж байна. Тэр хулгайнууддаа хариуцлага тооцооч ээ ийм зүйл л ирж байгаа. Одоо ингээд энэ хар даа гадаа ЖДҮ-ийнхэн энэ ордон

дотор хуран цуглаж байна. Түүн дээр ЖДҮ-ийнхээ мөнгө хулгайлсан талаар ерөөсөө 1 ширхэг ч ярихгүй байна гэж байна шүү дээ. Тэгээд л яамны мөнгөөр баахан ингээд хурал цуглаан хийдэг. Тэгээд тэд нарын та нарын ЖДҮ-г чинь хөгжүүлээд л өгнө гэдэг. Тэгээд ЖДҮ-ийнхээ мөнгийг нь хусчихдаг ийм замбараагүй болоод байна шүү дээ.

Тэгээд энэ хажууд энэ манай Их Хурлын энэ ордны танхимд оноос гараад 110 хэд дэх уулзалтаа юу, чуулгаа хийж байна гэж байна шүү дээ. Үгүй ээ, энэ чинь юу вэ. Энэ чуулга хийгээд хурал, зөвлөгөөн хийгээд хөгжчихдөг байсан бол Монголд бүр амьтны улсын орой дээр гарахаар болчихлоо шүү дээ. Тийм ерөөсөө. Хурал ихэдвэл ажил муудсаныг гэж ярьдаг. Батсуурь гишүүний хэлж байгаа зөв. Тэгээд Хөгжлийн банк, нүүрсний хулгай 44 их наяд төгрөгийн, Эрэдэнс тавантолгойн, оффтейк гэрээ 14 их наяд төгрөг тэндээс нь ашиглалтад орсон нэг ширхэг ч юм байхгүй. Төмөр замын хулгай нэг компанийн хашаа руу оруулаад л нүүрс ачихад л нэг цуваа вагон 500 сая төгрөгийн авлига өгдөг. Боловсролын зээлийн сан бүх л үеийн туршид тэр боловсролын зээлийн санг тонож байсан байна шүү дээ. Тэгээд ногоон автобус бараг 150 сая төгрөгийн үнэтэй автобусыг л 400 саяар шахчихсан байна шүү дээ. Ийм замбараагүй.

Тэгээд энэ дээр хүмүүс иргэд юу гэж байна вэ гэхээр ерөөсөө энэ эрх баригч нар нэг нь ногоон автобус хулгайлчихсан, нөгөөдөх нь нүүрсний хулгайд орчихсон, нөгөөдөх нь төмөр замын хулгай хийчихсэн, тэгээд бүгдээрээ ЖДҮ-д холбоотой учраас 1 нэгэндээ барьцаалагдсан. Чамайг тэгэх юм бол ингэнэ, ингэх юм бол тэгнэ гээд ингээд ерөөсөө нэгэндээ барьцаалагдаад ямар ч хариуцлага тооцохгүй ийм л нөхцөл байдалтай байна гээд. Энэ хариуцлага тооцохгүй л энэ ард иргэд аюул болох гэж байна. Хөөе. Үүнийгээ ухаар. Хариуцлага тооцохгүй бол энэ Ардын намыг чинь бүр ингээд бүр үнсэн товрог болгочхож байна. Энэ 2 том нам ингэж бас үл бүтэх

нөхдүүдээсээ болж ийм асуудалд орж болохгүй.

Тийм учраас энэ иргэдийн хүсээд байгаа тэр хариуцлага тооцох тэр асуудлыг энэ чуулганы хуралдаанаар зайлшгүй хэлэлцэхийг шаардаж байна. 5 дахь өдрийг тэгээд л нэг янз янзын нэг сонин сонин юм л хэлэлцээд л өөрсдөө таалагдсан тэр зүйлийг л Ерөнхий сайдын цагаар хэлэлцдэг. Энэ дээрээ энэ хулгайгаа яаж тооцож байгаа талаар заавал ярихыг Хууль зүйн сайд, Их Хурлын дарга, та бүхнээс шаардаж байна.

Л.Мөнхбаатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Тодорхой асуудлаар мэдээлэл авах шаардлагатай байгаа бол Улсын Их Хурлын гишүүн асуулга тавьж болно. Түүний дагуу Засгийн газрын гишүүд хариулах боломжтой гэдгийг хэлье.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дага, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хуулийн төслийн хэрэгжиж эхлэх хугацаа, хуулийн төсөл батлагдсанаар хэдэн эмэгтэй цэргийн албан хаагчийн Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх, төсөвт үүсэх ачааллын талаар асуулт асууж хариулт авлаа. Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэллэгийг хууль зүйн техникт нийцүүлэн жигдлэх, хуулийн дагаж мөрдөх хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байхаар зарчмын зөрөөтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүнд баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Гүрсэдийн Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Сүнрэвийн Ганбямба, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Бригадын генерал Дагвадоржийн Ганхуяг, БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Чулуунборын Гандирваа, БХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Гүрбадамын Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Басангийн Батжаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Пүрэврагчаагийн Баярболд нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. Байна уу? Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Байнгын хорооны дарга Гомпилдоогийн Мөнхцэцэг асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой ийм бас хуулийн өөрчлөлт оруулж ирж байгаад бас дэмжиж байгаа. Тэгэхээр энэ хил дээр ажиллаж байгаа хилийн цэргийн ар гэр болоод ингээд ажиллаж байгаа эмэгтэйчүүдээс бас нэлээн олон асуудлуудыг ялангуяа манай эмэгтэй гишүүдэд бас тавьж байсан. Бас эмэгтэй гишүүд хил дээр очиж ажиллаад, ер нь яг энэ хилд ажиллаж, хилийн бүсэд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн нийгмийн асуудлуудыг тэр тусмаа ингээд нөхрөө дагаад энд ажиллаж байгаа, амьдарч байгаа эмэгтэйчүүд ер нь бас ажил үүрэг гүйцэтгэхэд нэлээн хүндрэлүүд байдаг. Ялангуяа тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудал бас нэн тэргүүнд тавигдах шаардлагатай байдаг гээд ингээд олон зүйлүүдийг бас ярьж байсан.

Тэгэхээр яг энэ хил дээр ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн асуудлууд энэ дээр яг тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлууд яг хэдий хэмжээгээр бас орж ирсэн бэ гэдэг ийм асуултыг тавья гэж ингэж бодож байсан. Тэгээд ер нь ингээд нөхөр нь ингээд эрт тэтгэвэрт гарчихдаг, дагаад бас тэр хил дээр ажиллаж байгаа эмэгтэй бас нөхрөө дагаад бас ингээд явах шаардлагатай болчихдог. Тэгэхээр энд бас тэтгэврийн зөрөө гараад байдаг. Энэ дээр ямар нэгэн хууль зүйн, эрх зүйн зохицуулалт хийж өгөөч ээ гэдэг хүсэлтүүдийг бас нэлээн тавьж байсан. Ийм зохицуулалтууд хэр туссан бэ гэдэг ийм асуултыг асууж байна.

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Батлан хамгаалахын сайд Сайханбаяр хариулъя. Ажлын хэсгийн хэддүгээр микрофон байна. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

Г.Сайханбаяр: Баярлалаа. Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өглөөний амрыг эрье. Мөнхцэцэг гишүүний тавьсан асуултад хариулъя. Тэгэхээр хуулийн хамрах хүрээ гээд үндсэн заалт дээрээ зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч энэ хуульд хамрагдана гэдгийг маш тодорхой заагаад өгчихсөн байгаа. Тэгэхээр эмэгтэй цэргийн албан хаагчдын хувьд хилд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагчид энэ хуульд хамрагдаад явна. Байнгын хорооны хуралдаан дээр бас энэ чиглэлийн асуултыг Мөнхцэцэг гишүүн маань асууж байсан. Тэр нь энэ хилд ажиллаж байгаа алслагдсан газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагчдын гэр бүлтэй холбоотой асуудлыг хөндөж байсан. Энэ бол энэ хуулийн хүрээнд хамаарахгүй ээ. Энэ цэргийн албан хаагчдын хувьд бүрэн гүйцэд хамрагдаад явах юм байгаа юм.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын удирдлагаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Төмөр замын татах хэсгийн ашиглалтын хэлтсийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил хөдөлмөрт хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураана. 3 санал байгаа.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн ”Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон” гэсний дараа “амаржсаны,” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Цэргийн алба хаагч эмэгтэйн энэ хуулийн 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэлийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, шилжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг. Санал хураалт.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг. Санал хураалт.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн дэмжсэн санал өгсөн байна. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг. Санал хураалт.

69 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Ажлын хэсэгт баярлалаа.

10.32 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудал чинь эрхэлсэн сайд нь байгаа билүү, байгаа юм байна. Асуудлыг хэлэлцье дээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Засгийн газраас Засгийн газрын тусгай сангийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсны дагуу өнөөдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Эрүүл мэндийг дэмжих санг байгуулан ажиллаж байгаа бөгөөд Эрүүл мэндийг дэмжих сан нь архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс санхүүжиж байгаа билээ. Тус санд жилд дунджаар 2-3 тэрбум төгрөгийг улсын төсөвт хуваарилан эрүүл мэндийн сайдын багцад батлагдаж, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандан судалгааны ажилд зарцуулж байна.

Цаашид тус сангийн үйлчлэх үүргийг өргөтгөн дараах үйл ажиллагааг санхүүжүүлж байхаар хуулийн тус төсөлд тусгасан болно.

1. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад оношилж эмчлэх боломжгүй 26 төрлийн өвчнийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан байдаг. Гэвч уг өвчнийг оношлох, эмчлэх технологийг эх орондоо нутагшуулахад эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт, хүний нөөц, техник технологийн чадавх хангалтгүйн улмаас ихээхэн удаашралтай байгаагийн улмаас гадаад улсад очиж эмчлүүлэх иргэдийн тоо дорвитой буурахгүй өсөх хандлагатай байна. Иймд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийг дээрх өвчтөнүүдийг оношилж, эмчлэх, шинэ технологи нэвтрүүлж, нутагшуулах зардал зарцуулж байхаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчний тоог цөөрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад иргэдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулна хэмээн үзэж байна.

2. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчилгээнд хамрагдсан иргэдэд эмчилгээний зардлын тавхан хувийг олгож байгаа нь иргэдийн зарцуулж байгаа мөнгөн дүнтэй харьцуулахад маш бага хэмжээ юм. Уг зардал жилд жил бүр 500 сая төгрөгийг улсын төсөвт батлагдаж ирсэн. 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт 400 гаруй иргэнд 200 мянгаас 30 хүртэлх сая төгрөгийн буцаан олголтыг олгож байсан байна. Иймд гадаад улсад эмчилгээнд, Иймд зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчилгээнд хамрагдсан иргэдэд буцаан олгох эмчилгээний зардлын хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэн уг сангаас санхүүжүүлсэн хуулийн төсөлд тусгалаа. Төсөл батлагдсанаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хувь хүний төлөх төлбөрийн хэмжээг бууруулах, санхүүгийн эрсдэлийг хуваалцахад эергээр нөлөөлнө хэмээн үзэж байна.

3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй, эс үгүй бол тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорын эрхийг хүндэтгэж, оршуулгын тэтгэмжийг уг сангаас олгодог байхаар хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийг 5 дахин нэмэгдүүлж, 2024 онд 10 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн зарцуулахаар 2024 оны улсын төсөвт тусгасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Засгийн газраас өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Чинзориг сайдад баярлалаа.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа танилцуулна. Таныг өндөрт урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг судлах, тандах үйл ажиллагаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний технологийг нутагшуулах үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангаагүй, эсвэл тэтгэмжийн шимтгэл төлж байгаагүй амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгохтой холбоотойгоор хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Монгол Улсад эмчлэгддэггүй өвчин эмгэгүүдийг дотооддоо эмчлэхэд шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх болон техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа чихрийн агууламж өндөр орсон амтат ус ундаанд онцгой албан татвар ноогдуулах тухай хуулийн төслийг

санаачлан өргөн мэдүүлсэн байгаа тул энэ хуулийг батлагдсаны дараа энэ татварын хуулийг санаачлах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Эрүүл мэндийг дэмжих сангийн зарцуулалтын талаар, мөн дотоодод оношлогдож чадахгүй байгаа өвчнүүдийг оношлох, шинэ техник технологи нэвтрүүлэлтийн талаар болон энэ чиглэлээр бэлтгэгдсэн чадварлаг багтай хамтран судалгаа, үйл ажиллагаа явуулах талаар хэрхэн анхаарч байгаа талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Одонтуяа даргад баярлалаа.

Зочин танилцуулъя. Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн сурлага спортын өндөр амжилтыг та бүгддээ хүсэн ерөөе.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, Эрүүл мэндийн яамны Санхүү эдийн Засгийн газрын

Санхүү даатгалын хэлтсийн дарга Лхагважавын Мөнхцэцэг нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. Наянтайн Ганибал гишүүнээр тасаллаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Эрүүл мэндийн сайд Чинзориг сайдын оруулж ирж байгаа энэ хуулийн төслийг би санал нэгтэй дэмжиж байна. Яагаад гэвэл өнөөдрийн энэ гадаадад эмчлүүлэх хүсэлт өгч байгаа хүмүүсийн тоо маш их байгаа. Мэдээж дотооддоо эмчлүүлээд эмнэлгээр яваад л байдаг, яваад л байдаг. Гэхдээ үр дүн гарахгүй бас эмчлэгдэх боломжгүй. Ялангуяа сүүлийн үед тийм ховор төрлийн хавдраар өвчилсөн хүүхдүүдийн тоо эрс өсөж байна. Жишээ нь олон хүмүүс хүсэлт тавиад л эмэгтэй гишүүний хувьд үүнийг шийдэж өгөөч, гадаадад эмчлүүлэх гэсэн юм, зардал тусгах тал дээр туслаад өгөөч гэдэг хүсэлт өргөдөл өнөөдөр маш ихээр ирж байна. Тэгээд бид нар үүнийг яаж ч шийдэж чаддаггүй. Яагаад гэвэл Засгийн газрын хуралдаанаар энэ гадаадад эмчлүүлэх нэг 5 сая хүртэлх төгрөг 5 хувь нь байдаг гээд ярьж байна л даа. Энд сая. Гадаад улсад эмчилгээнд хамрагдсан иргэдэд эмчилгээний нийт зардлын дөнгөж 5 хувийг л олгож байгаа гээд энэ Эрүүл мэндийн даатгалын олгож байгаа мөнгө. Гэхдээ энэ хэнд ч хүрдэггүй. Тэгээд энэ тусгаад нэг үндсэн шалгууртайгаар тодорхой хүмүүст л олгогддог. Тэгэхдээ маш бага мөнгө байдаг. Тэгвэл яг энэ эрэлт хэрэгцээтэй зайлшгүй эмчлүүлэх, ялангуяа хүүхэд, тэгээд бусад хүмүүст энэ дэмжлэг хэрэгтэй байгаа юм.

Тийм учраас Эрүүл мэндийг дэмжих сангийн энэ хөрөнгийг нэмэгдүүлэх, энд бүр төр бодлогоор байх. Мэдээж тэр өвчнийг Монголдоо эмчлэх бололцоог, тоног төхөөрөмжийг гаднаас оруулж ирэх энэ тэр нь ирээдүйд бидний

хийх зайлшгүй ажил. Яагаад гэвэл эрүүл мэндийн чиглэлээр гадагшаа мөнгө урсаад байна гээд нэг талаасаа хүмүүс шүүмжилдэг ч дотооддоо үнэхээр боллоцгоогүй, зайлшгүй гадагшаа явж эмчлүүлэх хүмүүсийн тоо сүүлийн үед үнэхээр нэмэгдээд байгаа юм. Ялангуяа хавдар дээр, ховор төрлийн өвчлөл дээр. Тийм учраас ийм хүмүүсээ дэмжих нь маш чухал байгаа учраас үүнийг бас манай гишүүд дэмжээд явчих нь зөв болов уу гэсэн байр суурьтай байна.

Харин төсөв хэлэлцэж байгаа энэ үед бас өнөөдөр бараг эцсийн хэлэлцүүлэг явагдах байх. 24 оноос тусгах юм байна, 24 оноос 3-5 дахин нэмэгдүүлж 10 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр улсын төсөвт тусгасан гэж байна л даа. Тэгэхээр энэ маань өөрөө төсөвтэй бас уялдаж байгаа юм байна гэж ойлгож байна. Тэгэхээр бас дэмжиж байна. Тэгээд Чинзориг сайдыг энэ 10 тэрбум гэдэг бас хар хангалттай биш тийм ээ. Одоо тэгээд шалгуураа өөрчлөх үү, үүнийг дагаад. Учир нь одоо яг Засгийн газрын хуралдаанаар энэ гадаадад эмчлүүлэх хүмүүс яг ийм ажил албан тушаалтай хүмүүст л дэмжлэг үзүүлнэ гэсэн заалт байдаг. Бусад яг хүмүүст энэ олдох боломжгүй байдаг, хүрэлцдэггүй. Тэгэхээр энэ 10 тэрбум дээр яг ямар ямар шалгуур тавьж, ямар эмчилгээ хийлгэх хүмүүст энэ дэмжих сангийн мөнгийг зарцуулахаар төлөвлөж байгаа талаар товч мэдээлэл авахыг хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариуллаа. Хэн хариулах вэ? Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулья.

С.Чинзориг: Оюунчимэг гишүүний асуултад хариулья. Тэгэхээр одоо Тусгай сангийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад эрүүл мэндийг дэмжих сан гээд энэ сан ажиллаж байгаа. Яах вэ, би түрүүн хэлсэн, тэр архи, тамхины онцгой татварын 1-2 хувь, эмийн импортын гаалийн болоод нэмүү өртгийн 2 хувиар орлого бүрддэг. Энэ гүйцэтгэлээр нь тооцоод үзвэл нэг жилд

нэг 10-12 тэрбум төгрөг төвлөрөхөөр энэ тооцоо байдаг. Гэхдээ жил жил, тутам нэг улсын төсөвт 2-3 тэрбум төгрөг төсөвлөж өгдөг. Энэ хөрөнгөөр нь одоогийн байгаа хуулийн дагуу зөвхөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд буюу тандалт судалгаа, нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажилд зарцуулаад байгаа юм.

Ер нь иргэний эрүүл мэндийг хамгаална гэдэг бол 2 талтай гэж үздэг. Нэг тал нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нөгөө тал нь эмнэлгийн тусламж үйлчилгээ. Тийм учраас энэ сангийн үйлчлэх хүрээг нь өргөжүүлж, ялангуяа тэр эмнэлгийн тусламж үйлчилгээнд бас жаахан чиглүүлье. Дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа 26 төрлийн өвчин байна гэсэн ийм жагсаалт байдаг. Тэгэхээр энэ өвчнийг эмчилдэг, оношилдог технологи нэвтрүүлэхэд зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө хариуцаж хий гэхээр нь технологи нэвтрүүлэх, нутагшуулах ажил нэлээн удаашралтай байгаа. Тийм учраас энэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах зардлыг тодорхой энэ сангаас шийдэж өгье. Тэгээд дараагаар нь энэ шинэ технологи Монголд бас нутагшсан, нэвтэрсэн гээд мэргэжлийн салбар зөвлөлд дүгнэлт гаргавал, нөгөө даатгалын сан руу шилжүүлдэг байх. Ийм зохицуулалтыг хийж өгч байгаа юм.

2 дахь асуудал нь зайлшгүй шаардлагаар ялангуяа энэ дотоодод оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнөөр өвчилсөн иргэдэд гадагшаа эмчилгээнд яваад ирвэл эмнэлгийн санхүүчдийн тусламж дэмжлэг үзүүлэх асуудал маш бага. Зөвхөн ирсэн хойно нь төлбөр зардлынх нь тавхан хувийг л олгож байгаа юм. Тэгэхээр үүнийг үе шаттайгаар нэмэгдүүлье. Нэгэнт өөрсдөө төр өөрөө бид дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байна гээд жагсаалт гаргачхаад энэ төрлийн өвчнөөр гадагшаа эмчилгээнд яваад ирж байгаа иргэддээ эмчилгээнийх нь тавхан хувийг өгнө гэдэг дэндүү бас харамсалтай байна гэж. Тийм учраас энэ

зайлшгүй шаардлагаар гадаадад эмчилгээнд хамрагдсан иргэдийн олгосон энэ санхүүжилтийн хэмжээ бас үе шаттай нэмэгдүүлье гэж тооцож байгаа. Гэхдээ би зөвхөн энэ албан тушаалтнуудад энэ Эрүүл мэндийг дэмжих сангаас эмчилгээний зардлын төлбөр өгдөг гэж ойлгохгүй байгаа. Тийм асуудал байхгүй. Зайлшгүй шаардлагаараа л дотоод оношилж, эмчилж чадахгүй, зайлшгүй шаардлагаар гадагшаа эмчилгээнд хамрагдсан Монгол Улсын иргэд бас хамаарна гэсэн. Ингээд энэ хууль батлагдвал энэ журмыг нь Засгийн газар батлах юм. Журмыг нь. Тэгэхээр энэ журам дээрээ нэлээн бас тодорхой зохицуулалтууд хийж өгнө. Зайлшгүй шаардлагаар гэдгийг нь юу гэж үзэх юм. Гол нь тэр дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнөөр л гадагшаа эмчилгээнд явсан бол санхүүжилтийн хэмжээ олгодог байхаар ингэж нэлээн нарийвчилсан зохицуулалт хийж өгнө өө гэж.

Ирэх оны төсөв дээр 10 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа. Сайдын багц дээр энэ гадаад эмчилгээний зардал нэг жил тутам 500 сая төгрөг төсөвлөдөг байсныг энэ жил ирэх жилийн төсөв дээр 1 тэрбум болгож нэмэгдүүлсэн. Ингээд энэ 11 тэрбум төгрөгийн хүрээнд л нийгмийн эрүүл мэнд, технологи нэвтрүүлэх, иргэдэд олгох санхүүгийн төлбөрийг үе шаттайгаар бас нэмэгдүүлэх гэсэн ийм 3 арга хэмжээг л зохицуулья гэж л төлөвлөж энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуултаа асууя.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Өнөөдрийн Засгийн газраас буюу Эрүүл мэндийн яамнаас оруулж ирж байгаа энэ хуулийн төслийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм. Энэ олон жилийн турш ард иргэдийн өмнө тулгамдаад байгаа асуудлууд болон түүнээс гадна эрүүл мэндийн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд өнөөдрийн энэ хуулийн төсөл би үр

дүнгээ өгнө гэж бодож байгаа. Би 2017 онд Эрүүл мэндийн сайдаар томилогдон ажилласан. Намайг ажиллаж байхад эх орондоо эмчилдэггүй 39 өвчин байсан. Тэгээд 3 жилийн хугацаанд бид нар 26 болгож буулгаж чадсан юм, Чинзориг сайд аа. Энэ тоо одоо ерөөсөө буурахгүй байгаа юм. Яаж бууруулж чадсан бэ гэвэл би сайндаа биш л дээ. Эрүүл мэндийг дэмжих санд хэрвээ бид нар төсвөөс мөнгө төвлөрүүлж чадвал эх орондоо эмчилж чадахгүй байгаа өвчтөнүүдийн талаар техник технологи 1 дүгээрт нэвтрүүлэх, 2 дугаарт эрүүл мэндийн салбарынхныгаа багаар нь өндөр хөгжилтэй оронд сургах, мөн гадаадын туршлагатай эмч нарыг эх орондоо авчирч туршлага судлуулах энэ чиглэл маш чухал байдаг юм. 3 жилийн хугацаанд эх орондоо эмчилж чадахгүй байгаа өвчнийг 13 болгож бууруулж чадаж байсан. Яагаад гэвэл бид нар гадаадад олноор нь сургасан, маш олноор нь сургаж чадаж байсан. Тийм болохоор зэрэг энэ төвлөрч байгаа 10 тэрбумаа хамгийн нэн түүрүүнд эх орондоо эмчилж чадахгүй байгаа өвчнүүдийг эх орондоо эмчилдэг болгох тал дээр л нэлээн илүүтэй бас анхаарал хандуулж зарцуулах хэрэгтэй гэсэн 1 дүгээрт ийм саналыг хэлэх гэсэн юм. Тэгэхээр та энэ нийт энэ санд төвлөрөх мөнгөө хэрхэн яаж, хэдэн хувиар нь хуваарилах гэж байгаа юм бэ гэдэг талаар хариулт өгөөч ээ гэж.

2 дугаарт, эх орондоо одоогоор эмчилж чадахгүй байгаа учраас техник технологи нэвтэртэл хүлээнэ ээ гэх юм бол хүндээр өвдсөн байгаа хүмүүсийн амь нас эрсдэлд орж байгаа юм. Тийм учраас асуудал шийдэгдтэл гадаад оронд явуулж эмчлүүлэх нь тодорхой. Үнэхээр эмчилгээний зардлын тавхан хувийг өгдөг юм. Тэр зардал нь өөрөө 300 сая, 500 сая болдог. Тэрний тавхан хувийг л төрөөс Эрүүл мэндийн яамнаас өгч байгаа. Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгийг нэмэгдүүлснээр хүүхдийн эмчилгээнд тухайлбал гадаадад эмчлүүлээд ирэхэд хэдэн хувийг нь өгөх юм, том хүнийхэд хэдэн хувийг нь өгөх юм, хэрхэн яаж хуваарилах гэж байгаа юм. Засгийн газар

луу оруулах журмынхаа төслийг та нар маань яаж хийж байгаа юм бэ гэдэг асуудлыг би нэн тэргүүнд сонирхож байна. Энэ яагаад гэвэл иргэдийн өмнө хамгийн тулгамдаж байгаа асуудал.

Тухайн үед Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргаар гавьяат эмч Баясгалан ажиллаж байхдаа энэ талын тооцоог хийгээд, ер нь нэг жилдээ 10 тэрбум төгрөгийн асуудал гадаад эмчилгээнд хэрэгтэй болоод байх юм байна гэдэг ийм тооцоо судалгааг хийсэн байдаг. Тэгэхээр цаашдаа Эрүүл мэндийг дэмжих сангийн энэ хөрөнгө төвлөрөлтийг анх удаа Чинзориг сайдын үед 10 тэрбум болж байна. Ийм байсан түүх байхгүй. Үүнийг нэмэгдүүлэх шаардлагатай. Тэгэхдээ би бас эдийн засаг тийм амаргүй байгаа үед Засгийн газар, Сангийн яам дэмжих сангийн хөрөнгийг анх удаа 10 тэрбум болгон төвлөрүүлж байгааг үнэхээр сайшааж байна. Манай Чинзориг сайдын хөөцөлдлөгөө нэлээн байсан байх гэж бодож байна.

Хамгийн гол нь нэгэнт олдож байгаа энэ сайхан боломжийг маш үр дүнтэй, яг хэрэгтэй газар нь төвлөрүүлэх ёстой.

Түүнээс гадна Эрүүл мэндийг дэмжих сангийн эд хөрөнгө төвлөрүүлэлт бол олон нийтэд нөлөөллийн ажиллагаа явуулах, эрүүл мэндийн боловсролын чиглэлд явуулах, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй ажиллахад бас зориулагдах ийм заалттай байдаг. Саяын 3 чиглэл рүү явуулаад нөлөөллийнхөө ажлыг /Мөнх-Оргил сайд аа, би Чинзориг сайдад асуулт тавьж байгаа байхгүй юу./ Тэгэхээр энэ нөлөөллийнхөө ажил дээр олон нийтэд эрүүл мэндийн боловсролоо олгох чиглэл дээр та бүхэн маань хөрөнгө төвлөрүүлэлт хийж байна уу, үгүй юү, бүр больчихож байгаа юм уу. Энэ хэдэн тодруулгыг аваад дараа нь нэмж асууя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг.

С.Чинзориг: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Би тантай яг санал нэг байгаа юм. Гол нь бид нар энэ шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулахад л энэ Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг дийлэнхийг нь зарцуулна л гэж. Тэгж байж энэ гадагшаа эмчилгээнд явж байгаа иргэдийн урсгал багасна. Тэгж байж энэ иргэд хувиасаа мөнгө төлж, гадаад улс оронд эмчилгээ хийлгэдэг энэ эрсдэл буурна гэж үзэж байгаа. Тийм учраас 1 дэх асуудал нь тэр технологи нэвтрүүлэх асуудал. Дотроо таны хэлээд байгаа гадагшаа эмнэлгийн мэргэжилтнүүдээ багаар нь явуулж, сургалтад хамруулж чадавх хөгжүүлэх, гадаадаас өндөр чадавхтай баг ажиллуулж, туршлагыг нь суулгаж авах, оношилгоо, шинжилгээний тоног төхөөрөмжийн бас нэг хүртээмжийг нэмэгдүүлэх эд нар гээд олон ажил хийнэ гэсэн ийм бодолтой байна. Би энэ утгаараа энэ сангийн хөрөнгийн дийлэнх нь тэр технологи нэвтрүүлэх, нутагшуулах, зардалд зарцуулагдаж байх ёстой гэсэн ийм бодолтой байгаа. Нэг болгоомжилж байгаа юм. Ер нь олон нийтийн иргэдийн дунд энэ тусгай сангуудын зарцуулалт их муу байна, хяналт их муу байна, ашиглалт шамшигдуулалт их байна энэ тэр гэсэн асуудал шүүмжлэлтэй байгаа. Тийм учраас үүнийг тэр сангийнхаа журмыг Засгийн газар оруулахдаа энэ бүх эрсдэлийг нарийн тооцож боловсруулж оруулах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Бусад сан шиг дараагаар нь асуудал үүсгэсэн, цөөхөн хүн авдаг, ар өврийн хаалгаар авдаг, албан тушаалтнууд авдаг гэсэн ийм бас сан болчихсон гэсэн юм руу оруулчих вий дээ гэдэг ийм бас болгоомжлол бас байгаа. Тийм учраас энэ ийм бас эрсдэл гаргахгүйгээр зохицуулалтыг нь маш нарийн тооцож хийнэ ээ гэж төлөвлөж байна.

22 оны тооцоогоор үзэхэд нийт гадагшаа явсан иргэдийн эмчилгээний төлбөрт зардалд өгсөн төлбөрийн хэмжээ нэг 13 тэрбум төгрөгийн төлбөр гарсан гэсэн ийм нэхэмжлэл Эрүүл мэндийн яаманд ирсэн юм байна лээ. Үүний 5 хувь

гэхээр нэг 650 орчим сая төгрөгийг л бид нар барагдуулж өгсөн. Миний баримжаа тооцоогоор ирэх жил зайлшгүй шаардлагаар гадагшаа эмчилгээнд явсан хүүхдийн эмчилгээний зардлын 50 хувийг нь бас буцаан олгодог болгоё. Том хүнийг жаахан ялгамжтай хандъя, том хүний зардлын 20 хувийг нь буцааж олгодог болгоё гэсэн ийм бас урьдчилсан тооцоо хийж байгаа. Ийм чиглэлээр төсөв мөнгөө бас бодож тооцож байгааг хэлье.

Иргэний эрүүл мэндийн боловсролтой холбоотой асуудал маш чухал. Засгийн газарт иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар бас авах арга хэмжээний тухай асуудал оруулж, Засгийн газарт тогтоол гаргасан. Одоо салбарын 5 яамтай хамтраад бид нар иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлахаар ажиллаж байна. Тодорхой хэмжээгээр иргэдэд нөлөөлөл үзүүлэх ялангуяа эрүүл зөв амьдралын хэв маяг тогтоох асуудал маш их чухал. Үүнтэй холбоотойгоор бас холбогдох төсөв бас ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Та тодруулах уу? Даваажав Чинцэнгийн Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

Д.Сарангэрэл: Ер нь иргэдээ толгой дараалан гадаадад явуулж, эмчлүүл ээ гэсэн үг биш л дээ. Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн дүгнэлтээр гадаадад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх ёстой гэсэн дүгнэлт гарсан үед л энэ журам үйлчлэх учиртай. Тэгэхээр Чинзориг сайд аа, үнэхээр дэвшил гарч байна. Өмнө нь ингээд эмчлүүлэхэд нь 5 хувийг нь өгдөг байсан бол хүүхдэд 50 хувийг нь, том хүнд 20 хувийнх нь зардлыг эргүүлж өгөхөөр ийм дэвшил гаргасан хуулийн төсөл санаачлаад оруулж ирж байгаад их баярлаж байна. Өнөөдөр хилийн чанадад ажиллаж, амьдарч сурч байгаа 200 гаруй мянган иргэд маань Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулж байгаа. Харин эсрэгээрээ эх орондоо 26 өвчнийг эмчилж чадахгүй

байгаа учраас гадаадад эмчилгээний зорилгоор валютын урсгал ихээхэн явж байгаа. Түүнээс гадна айл өрхөд эдийн засгийн дарамтууд маш ихээр учирч байгаа. Эдгээр асуудлыг шийдвэрлэх чиглэлд та бүхэн маань ийм санаачилгатай ажиллаж байгаад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад нэмж хариулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулъя.

С.Чинзориг: Тийм ээ, бид нар энэ хуулийн төслийг санаачилж оруулахдаа гол нь иргэдэд очиж байгаа санхүүгийн дарамт эрсдэлийг л бас бууруулах чиглэлээр л нэлээн бас ахиц дэвшил гаргая л гэж бодож байгаа юм. Тийм учраас тодорхой хэмжээгээр тэр Эрүүл мэндийг дэмжих сангийнхаа журмыг маш ямар нэгэн бас эрсдэл гаргахгүй байхаар зохицуулалт хийх хэрэгтэй. Тэр технологи нэвтрүүлэх асуудлыг ч гэсэн тэр салбар зөвлөлийн дүгнэлт гарсны дараагаар нэвтэрүүлье ээ гэж үздэг байх. Тэгээд Даатгалын сан руу шилжүүлдэг байх. Зайлшгүй шаардлагаар эмчилгээнд явахад тэр мэргэжлийн эмнэлгийн дүгнэлт гарсан нөхцөлд л гадагшаа явуулдаг.

Нэг асуудлыг бид нар шийдэж чадахгүй юм билээ, Сарангэрэл гишүүн ээ. Уг нь гадагшаа зайлшгүй шаардлагаар эмчилгээнд явж байгаа иргэд яваад ирсэн хойно нь зардал өгөх биш явахад нь уг нь зардал өгдөг бол нэлээн хүндээ их тийм дэмжлэг болохоор юм байгаа юм. Одоо болявах гэж байна гээд зардал байхгүй нэг баахан хандив гуйсан улсууд байна шүү дээ. Тэгэхээр үүнийг би нэлээн ярьж байгаа. Гэтэл урьдчилж мөнгө өгөх тийм боломж байхгүй байна л гэж манайхан яриад байгаа юм. Тэр онош нь очоод бас батлагдах уу, үгүй юу, өөрчлөгдөх үү яах вэ, эд нар гээд асуудлууд маш их асуудлууд байна гээд. Тэгээд тэгэхээр урьдчилж мөнгө өгөх асуудал боломж байхгүй байна. Гэхдээ яах вэ, яваад ирсэн хойно нь тэр хувь хэмжээг нь нэмэгдүүлээд олгодог байх л тэр л

зарчмаар явах нь зүйтэй юм болов уу гэсэн ийм бас байр суурьтай л байх.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар БГД-ийн 6 дугаар хорооны иргэдийн төлөөлөл мөн Баянхонгор аймгийн Баянбулаг сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Энэ 600-650 орчим сая төгрөг юм шиг байна шүү дээ. Тэгээд энэ чинь бүх хүмүүсийн зовлонг шийдэж чадахгүй л дээ. Тэгэхдээ яах вэ, бага хэмжээгээр ч болтугай нөгөө бас нэг өвчин зовсон гадна дотно эмчлүүлж байгаа хүмүүсийн хүүхдүүдийн асуудлыг шийдэх байх. Бага хувиар. Чинзориг сайд аа, энэ сангийнхаа хөрөнгийг нэмэгдүүлж, гадагш нь мөнгө гаргах гэдэг бодлого чинь яах вэ, өнөө маргаашдаа л бид нарын зовлон. Ер нь цаашдаа яг ийм бодлогыг бас явуулах ёсгүй байх гэж бодоод байгаа юм.

Бид аль болохоор одоо бид Монголчууд Солонгос улс руу ойролцоогоор жилд 300 орчим сая доллар зөвхөн эмчилгээ үйлчилгээнд зарцуулж байна. Энэ албан бус судалгаа. 300 орчим сая доллар. Энд тоног төхөөрөмж нь байгаа, тохиолдол нь элбэг байдаг, эмч нарынх нь туршлага энэ саяын яриад байгаа тэр технологи гэдэг юм чинь муу байгаа учраас гадагшаа яв гэдэг зөвлөгөөг эмнэлгүүд өгөөд байгаа байхгүй юу. Тэгээд сүүлдээ энэ эмнэлгүүд чинь аялал жуулчлалын товчооны ажилтан шиг болчхож байна шүү дээ. Энэ улсын тэр эмнэлэг их сайн, энэ рүү л яваарай гээд.

Тэрийг сонсохын тулд эмнэлэг дээр очоод байгаа байхгүй юу. Уул нь үүнийг чинь аваад манай тэр эмнэлэгт эмчилнэ ээ, энэ баг эмчилнэ ээ гэж ярьж байх ёстой юм байгаа юм.

Миний бодоход энэ гаднаас тэр сайн туршлагатай багуудыг нь эмч нарыг нь хөлсөлж авчраад 1, 2 хүүхдийн асуудлыг биш нийт олон хүүхдийн асуудлыг шийдэхийн тулд тэр эмч нарын багийг нь эмч нартай нь авчирч байгаад энд бид нар хийх юм бол 1 дүгээрт, дагалдан орж байгаа Монгол эмч нар чинь туршлагатай болчхож байгаа юм.

2 дугаарт, нөгөө таны яриад байгаа технологи суурьших юм чинь явчхаж байгаа юм. Энэ хэлбэрээр ингээд цаашдаа гадагшаа явж эмчлүүлсэн болгонд мөнгийг нь өгнө өө гэдэг юмаар явах юм бол манай энэ эмнэлгийн эрүүл мэндийн тогтолцоо чинь өөрөө гажуудалтай болно шүү. Ялангуяа энэ хүнд, зайлшгүй тэр нэг ховор тохиолдлууд байна шүү дээ, 100 мянган хүн тутам нэг тохиолддог, 10 мянган хүн тутам нэг тохиолддог ч гэдэг юм уу тийм юмнууд дээр бид нар тусалж дэмжилгүй л яах вэ, тэрийг бол. Энэ түгээмэл шинжтэй өвчнийхөө юмнуудыг бид нар бас анхаарч харж, явах нь зүйтэй болов уу л гэж харж байна.

2 дахь юм нь энэ бол энэ хуультай холбоотой биш Эрүүл мэндийн даатгалын энэ эмийн хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг ер нь яаж гаргаж байна аа? Би энэ дээр нэг санал байна. Үүнийг та бас эргэж харж үзээч. Одоо энэ хараад байхад энэ уураг гээд зуухан грамм альбумин гээд энэ уургийг 240 мянгаар 7 хоног тутам тариулахад л тэр айлын өрхийн амьдрал хүнд болж байна шүү дээ. Маш их хэрэглээтэй байна, энэ, маш их хэрэглээтэй байна. Энэ дандаа хавдрын голцуу өвчлөлтэй хүмүүс дээр түлхүү хэрэглэгдэж байгаа уургийн дутагдал. Тэгээд энэ уургийг тэр жагсаалт дотор хөнгөлөлттэй үнэд нэг 50 хувьд нь ч байна уу, 40 хувьд нь оруулах боломж бололцоонууд байна уу. Энд яг аль аль эм орох вэ гэдгийг даатгалынхан шийдэж

байна уу, танайхаас санал онол эмнэлгүүдээс ер нь авдаг юм болов уу. Үүнийг ер нь цаашдаа анхаараасай л гэж би. Асуулт алга. Надад ийм саналууд л байна.

Л.Мөнхбаатар: Раднаасэд гишүүн тодорхой саналууд хэллээ. Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

Б.Баттөмөр: Өнөөдөр энэ Монголын нийгмийн хамгийн эмзэг асуудлыг л ярьж байна даа. Энэ гадагшаа явж байгаа зардал замаа алдсан шүү дээ. 350-400 сая доллар Солонгос, Тайланд, Турк гээд жилд зарцуулж байна гэсэн ийм судалгаа байдаг юм байна лээ. Тэгээд сая тэр Раднаасэд гишүүний ярьж байгаа тэр шүү дээ. Манай эмч нар бид чадахгүй ээ гадагшаа яв гэж. Энэ хорт хавдар энэ өвчтөнүүдийг чинь эмчилдэг бол шинээр нээлт хийх гээд байгаа юм биш шүү дээ. Хүний хийчихсэн юмыг л Монголд нутагшуулья л гээд байгаа шүү дээ. 30 жил ярьж байна шүү дээ, бид нар. Тэгээд яагаад үүнийг ингээд яагаад байдаг юм. Энэ 10 тэрбум төгрөгийн л асуудал ярьж байгаа байхгүй юу, энэ 10 тэрбум төгрөг юу ч биш шүү дээ. Энэ эдийн засгийн шинжлэх ухааны Нобелийн шагналт нөгөө Давло гээд нэг хүний хэлсэн үг байдаг юм. Ядуурлын хавх гэж. Монгол дээр орчуулах юм бол тэгж. Энэ хавханд ордог вэ гэхээр зэрэг өвчлөөд дунд түвшний амьдралтай хүмүүс ядуурал руу ороод байгаа юм. Яагаад гэхээр өвчлөөд бүх юмаа зараад тэгээд юу ч үгүй болоод ядуурал руу ордог. Энэ Монголд байж байгаа шүү дээ. 42,5 хувь нь ядуурах магадлалтай болчихсон. Тэгээд энэ үүнийг л бид яриад байдаг ерөөсөө л болдоггүй. Энэ одоо тэр Солонгос, Япончуудаас нь тэр гуйдаг юм уу, түүдэг юм уу, мөнгийг нь төлдөг юм уу, Монголд авчраад тэд нарыг дагалдуулж сурах ёстой шүү дээ. 1, 2 хүн яваад тийм амжилт олохгүй ээ. Яах вэ, үнэхээр онцгой мэргэжлийн сайн тэр хэл болсон нь сайн мэддэг барьдаг улсууд нь очоод хийвэл гайгүй л байдаг байх.

Энэ сүүлийн үед энэ гаднын нэг хүн ярьж байсан юм. Танай хамгийн аюултай юм нь хүүхдийн өвчлөл. Гадаадад очиж эмчлүүлж байгаа Монголд эмчлэх боломжгүй хүүхдийн өвчлөл аягүй ихсэж байна гэж. Энэ ямар учир шалтгаанууд байна аа? Үүнийг судалж мэдсэн юмнууд байна уу, үгүй юү?

Манай энэ хорт хавдрын шинж чанарууд ер нь ямар байдаг юм бэ? Монголын ийм онцлогтой тийм хорт хавдар гэж байна уу? Ямар юм байна? Яагаад энэ элэг ингэж их өвдөөд, хорт хавдраар өвчлөөд байна, ходоод, нойр булчирхай гээд. Энэ энэ тэр дээр ийм судалгаанууд байдаг юм уу, үгүй юү гэсэн ийм юм байгаа юм.

Энэ яах вэ дээ, сая энэ би маш их ярьж байгаа. Эрүүл мэндийн салбартаа энэ мөнгөө төсвөө сайн тавьж өгөөч ээ гээд. Тэгээд яах вэ дээ, тэгээд 1 эрхтэн шилжүүлэх манай Чинбүрэн эмч энэ тэр аль эрт шилжүүлээд юмаа хийчихсэн шүү дээ. Тэгээд л 140 тэрбум төгрөгөөр л эмнэлэг л барина гээд л яах явж байна л даа. Манай энэ улсын эмнэлгүүдийн энэ газруудыг нь бүгдийг нь авчихсан юм гэсэн. Энэ улсын эмнэлгүүдээ түшиглээд эхний ээлжид байна даа, одоо жишээлэхэд Төв аймгийн Сэргэлэн сумд эмнэлэг барина гэдэг чинь 0 цэгээс эхэлнэ шүү дээ. Тэр лүү хүн явна, тэр эмч, сувилагч нар нь хаана амьдрах юм. Энэ байж байгаа энэ хавдрын эмнэлэг энэ бусад эмнэлгүүдээ түшиглээд зарим хүмүүс зээл аваад эмнэлэг барьчихсан буцаад улсад худалдъя гээд явж байдаг юм гэсэн. Үгүй ээ, ийм боломжуудыг ашиглаад маш яаралтай хурдтай шийдэх хэрэгтэй байна шүү дээ. Үүнийг. 1 дэх асуудал энэ, энэ ийм боломжууд байна уу.

2-т нь, эмийн чанарын асуудал. Үүнийг яах юм. Хамгийн муу, чанар муутай, хугацаа дууссаны эмүүдийг авч ирж байгаа. Ер нь эмийн бодлого ер нь цаашдаа ямар байх юм? Үүнийг хэлж өгөөч ээ. Энэ тэгээд архи, тамхинаас 1, 2 хувь гэнэ. Үүнийг жоохон нэмэгдүүлж бариад энэ сангийнхаа хөрөнгийг л

нэмэгдүүлэх юм. Энэ талаар бодох ийм шаардлага байна шүү. Би асуултдаа хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Бид нар шинэ технологи нэвтрүүлэх асуудал дээр Баттөмөр гишүүний асуултад хариулахад зардлыг нь тухайн эрүүл мэндийн байгууллага өөрсдөө хариуцаж хий гэдэг учраас энэ их нэг явцгүй байгаа юм. Тухайлбал нэг өвчнийг эмчлэх технологи нэвтрүүлэхэд доод тал нь 50 тохиолдол хийгдсэн байх ёстой гэдэг юм байна лээ, 50 тохиолдол хийгдсэн байх ёстой. Тэгээд энэ 50 тохиолдлыг тус бүрийнх нь зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө хариуцаж хий гэдэг учраас энэ шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах асуудал ингээд ерөөсөө явахгүй байгаа юм. Тэгээд үүний дараагаар нь бид нар энэ технологи нутагшлаа гэж үзвэл тэр мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлт нь гараад Эрүүл мэндийн даатгалын сангаас цаашдаа санхүүжүүлдэг байх ийм чиглэл рүү асуудал оруулах ёстой байсан.

2 дахь асуудал нь, бид нар ер нь эрүүл мэндийнхээ энэ салбарт баримтлах бодлогодоо нэлээн томоохон өөрчлөлт хийх болчихсон юм байна лээ. Өвчилсөн хойно нь л эмнэлэгт тусламж үзүүлнэ гээд байдаг. Ер нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг олон жил орхигдуулж явж ирсэн байна гэж. Бусад орнууд чинь нийгмийн эрүүл мэнд анхан шатын тусламж үйлчилгээндээ нийт тус тусламж үйлчилгээнд чинь 50-80 хувь нь тэнд үзүүлдэг, санхүүжилтийнхээ 50-80 хувийг тэнд өгдөг. Гэтэл манайх эсрэгээрээ дөнгөж 1 хорьхон хувиа л нийгмийн эрүүл мэнд, анхан шатын тусламж үйлчилгээнд үзүүлж байгаа. Тийм учраас энд нэлээн бодлогын өөрчлөлт оруулах шаардлага. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хууль бас оруулж ирж оруулж ирж байгаа. Үүнийг бас яаралтай шийдэж өгмөөр байх юм.

2 дахь асуудал, ер нь цаашдаа бид нар иргэний эрүүл мэндийн боловсролтой холбоотой асуудал ярих ёстой юм байна лээ. Үндсэн хуульдаа иргэн эрүүл мэндээ хамгаалах нь иргэний журамт үүрэг гэсэн Үндсэн хуулийн заалттай. Иргэн ч ярьдаггүй, төр ч ярьдаггүй. Нөгөө талаас энэ олон улсын байгууллагууд, эрдэмтэн, судлаачдын хийж байгаа судалгаа эд нарыг харахаар иргэний зөв амьдралын хэв маягаас чинь энэ эрүүл мэндийн асуудлыг чинь бараг 55 хувь нь шалтгаалдаг гэдэг асуудал яригдаад шүү дээ. Тийм учраас энэ иргэний эрүүл мэндийн боловсролын асуудал дээр нэлээн томоохон бас өөрчлөлт хийж, иргэдийн зөв амьдралын хэв маяг төлөвшүүлэх, буруу дадал зуршилд өртөхгүй байх, үүнтэй холбоотой асуудал нэлээн тийм нөлөөллийн ажил маш хийх хэрэгтэй.

Энэ 26 төрлийн дотоодод оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчний чинь 14 нь хүүхдийн өвчлөл байгаа юм байна лээ. Хүүхдийн өвчлөл байгаа юм. Тийм учраас бид нар энэ хүүхдүүдэд зайлшгүй дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнөө л гадагшаа эмчилгээнд явж байгаа бол зардал олгодог байх. Энэ нэлээн нарийн зохицуулалт хийж өгнө өө гэж.

Хорт хавдар маш өндөр байна. Хорт хавдрын өвчлөл маш өндөр байна. Дэлхийд. Хамгийн харамсалтай нь хорт хавдрын шалтгаант нас баралтаараа дэлхийд их 1-д бичигдэж байгаа. Энэ хамгийн харамсалтай мэдээ байна. Тийм учраас энэ шинэ технологи нэвтрүүлэх, эмнэлгүүдийг чадавхыг нь бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах гээд асар их ажил хийх нь байна.

Эмийн үнэ, чанартай холбоотой асуудал иргэдийн дунд маш их үг хэлтэй байдаг. Бид нар Төрийн худалдан авалтын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Энэ хуулиараа 1 сараас хэрэгжинэ. Төрийн эрүүл мэндийн байгууллагууд даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг бид нар шууд олон улсын худалдан

авалтын системийн ашиглаж шууд ...
/минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр тодруулж асууя.

Б.Баттөмөр: Энэ улсын төв эмнэлгүүдийн газруудыг бүгдийг нь хүмүүс авчихсан байдаг юм гэнэ лээ. Энэ ямар судалгаанууд, ямар юм байна аа? Энэ хэдэн том эмнэлгүүд байгаа шүү дээ. Сүрьеэгийн эмнэлэг, Хорт хавдрын тийм, хавдрын эмнэлэг тийм ээ. Тэгээд улсын клиникийн эмнэлгүүд гээд. Үүнийг тэр хууль бус байдаг юм бол яадаг юм, эсвэл ямар боломж байна? Энэ байгаага л тордож ашиглах нь л илүү зардал багатай л байх юм болов уу л гэж л надад бодогдоод байгаа юм л даа.

Тэгээд иргэний эрүүл мэндийн боловсрол гэдэг үнэхээр чухал. Энэ дээр манай ЭМЯ ер нь тэгээд л бүх л түвшинд л үүнийг ярих ёстой л доо. Энэ төрийн энэ зайлшгүй хяналтад байдаг нэг тийм хэдэн бараа байдаг юм гэнэ лээ. Тэрний нэг нь эм шүү дээ. Чанартай эм л хүн хэрэглэх ёстой шүү дээ. Даралтын эм хуурамч эм, чанар муутай эм авчраад л уугаад л харваж байна шүү дээ, энэ чинь. Тэгээд ингээд цаашаа яваад байж болохгүй байх л даа. Энэ дээр ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад нэмж хариулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг.

С.Чинзориг: Төрийн эрүүл мэндийн байгууллагуудын эзэмшлийн газар бас нэлээн олон жилийн өмнөөс хувьд шилжсэн, тодорхой эздэд шилжсэн ийм асуудлууд асар их байгаа юм байна лээ. Манай Хавдрын эмнэлэг, 3 дугаар эмнэлэг эд нар чинь машинтай хүн битгий хэл явган хүн ч орохын зай байхгүй ийм маш их ийм шигүү болгочихсон. Бүх төрөлжсөн эмнэлгүүдийг хувийн эмнэлгүүд тойроод шавчихсан, бүх төрөлжсөн эмнэлгүүдийг эмийн сангууд тойроод шавчихсан ийм л байдалтай байгаа. Тэгээд Засгийн газар дээр үүнийг

ярьсан. Барилга, хот байгуулалтын сайдаар ахлуулсан ажлын хэсэг гаргасан. Ер нь төрийн байгууллагуудын мэдлийн эзэмшлийн газрыг хэдэн оноос яаж хувьд шилжүүлсэн юм, хууль юм уу, хууль бус юм уу, үүнийг судалж танилцуул гэсэн. Энэ хүрээнд тодорхой асуудлууд яригдах болов уу гэж бодож байна.

Эмтэй холбоотой би санал болгоно. Эм бол стратегийн бүтээгдэхүүн. Үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой бүтээгдэхүүн. 30 жил эмийн асуудлыг хувийн хэвшлийн нуруун дээр тохоод явж ирсэн юм байна лээ. Төрийн оролцоо, хяналт маш сул. Нөгөө талаасаа стратегийн бүтээгдэхүүн юм бол төрийн оролцоо, дэмжлэг ерөөсөө байдаггүй явж ирсэн. Тийм учраас төрийн оролцоо дэмжлэг байх хэрэгтэй байна. Нөгөө талдаа төрийн зохицуулалт хяналт байх ёстой байна гэсэн би ийм байр суурьтай байгаа. Яг ийм байр сууриараа хуульдаа өөрчлөлт оруулж удахгүй Их Хуралд оруулж ирнэ.

Төрийн худалдан авалтын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Би түрүүн цаг багассангүй. Олон улсын энэ худалдан авалтын систем байна. Баттөмөр гишүүн ээ, хүүхдийн сангийн дэлхий даяар үйлчилдэг маш том худалдан авалтын систем байна. Тэгээд энэ төрийн худалдан авалтын хуульд өөрчлөлт оруулаад энэ ОУБ-ын худалдан авалтын системийг ашиглаад шууд эм, эмнэлгийн хэрэгслээ худалдан авдаг байх ийм хуулийн зохицуулалттай болсон. 1 сараас хэрэгжинэ. Тийм учраас би эхний ээлжид ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу. 1 минутад багтаагаад тодруулгад хариулъя.

С.Чинзориг: Тэгэхээр 1 сараас энэ хууль хэрэгжинэ. Тийм учраас төрийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авч ашиглаж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг төр өөрөө энэ олон

улсын худалдан авалтын системээр шууд худалдан авалт хийдэг байх ийм журам руу шилжинэ. Ингэвэл энэ эмийн үнэ, чанартай холбоотой нэлээн асуудал гарах байх.

2 дахь асуудал нь эмийн чанар дээр хяналт тавьдаг, хяналт баталгаажуулалт хийдэг лабораторийг, бас хүчин чадлыг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Дэлхийн банкны санхүүжилтээр ирэх жил бид нар нэг 5 тэрбум төгрөгийн дэмжлэг авч, эмийн лабораторийг нэлээн орчин үеийн жишигт нийцсэн ийм лабораториудаа болгохоор ажиллаж байна. Ингэх юм бол бас нэлээн бас ахиц гарах болов уу гэж бодож байгаа юм.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Петровис компанийн 21 аймгийн салбар зөвлөлийн удирдах ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил, хөдөлмөрийн өндөр амжилт сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. Наранбат захирал өөрөө явж байгаа юм байна.

Одоо хэн асуух билээ. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе. Бид бас их чухал сэдэв энд яригдаж байна. Тийм учраас Чинзориг сайд бас энэ тусгай сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт барьж байгаад бас талархалтай байна. Ер нь энэ технологийн дэвшлийг авчрахын тулд зайлшгүй хөрөнгө оруулалт хийж байж л бид авчрахгүй бол үүнийг биеэ даагаад эмнэлгүүд өөрсдөө хийчих боломж маш хязгаарлагдмал. Тэгээд 20 оны сонгуулиар бүрдсэн энэ Их Хурлын үндсэн том зорилго бол бид ард иргэдээс санхүүгийн дарамт үзүүлэхгүйгээр дэлхийн шилдэг технологиудыг Монголдоо хийх энэ том зорилгын төлөө явж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр яг

энэ чиглэлд энэ сангийн үйл ажиллагаа зарцуулагдана гээд тэгж ойлгож байна.

2 дахь зүйл ер нь дэлхийн өндөр хөгжилтэй орон битгий хэл, Монгол битгий хэл дэлхийн өндөр хөгжилтэй орнууд хүртэл өөрийн орондоо эмчилж чадахгүй хүмүүсээ чаддаг улсууд руу нь даатгалын системээрээ явуулж эмчилдэг ийм туршлага байгаа юм. Тухайлах юм бол арваад жилийн өмнө Англи улс гэхэд л өвдөгний үе солих эмчилгээгээ өөрсдөдөө хийхгүй Германд өвчтөнүүдээ илгээж, даатгалын тогтолцоогоороо тэндээ гэрээ хэлэлцээр хийгээд, тэгээд тэр хүмүүсээ хямд зардлаар эмчлэх боломжийг олгодог байсан. Тэгэхээр бид ч гэсэн бас энэ зам руу явах хэрэгтэй. Нэгэнт эмчилж чадахгүй байгаа бол эдийн засгийн хувьд цөөхөн хүмүүсийг эмчлэх өртөг ихтэй байгаа бол бид даатгалын системээрээ дамжуулаад тэр хүмүүс өөр оронд очоод эмчлүүлсэн бол тэрийг нь худалдаж авдаг энэ тогтолцоогоо дэлгэрүүлэх хэрэгтэй. Бид илүү сайн жишгийг дуурайх ёстой. Тэгэх юм бол бид сая зарим гишүүдийн хэлж байгаагаар зүгээр гадаад руу өвчтөн илгээдэг, хэдэн жуулчлалын байгууллагуудыг дэмжих биш харин эсрэгээр ЭМЯ бодлогоор эмчилж чадахгүй байгаа өвчтөнүүдээ эмчлэх, худалдан авах үйл ажиллагаа хийхийн тулд олон улсын тендер зарлаж, тэр өвчтөнүүдийг эмчилж чаддаг эмнэлгүүдтэй Монгол хүнд ээлтэй ийм тогтолцоог бий болгоод аажим Монголдоо өөрсдөө хийдэг болох энэ тогтолцоо руу орох ёстой. Үүнийг Чинзориг сайд бас анхаарч байсан гэж хүсэж байна.

Тийм учраас бидэнд сайн туршлага байна. Бид маш олон олон өвчнүүдийг эмчилж чаддаг болсон. Тийм учраас ЭМЯ энэ мэргэжлийн ерөнхий мэргэжилтэн гэдэг энэ том бүтцээ ашиглан түрүүн Сарангэрэл сайд бас чухал асуулаа шүү дээ, яг ямар журмаар хийх вэ? Бид хуульдаа ингээд баталчихлаа, тэр журмаа батлахдаа энэ ерөнхий мэргэжилтнүүд нь энэ өвчнийг эмчилж чадахгүй байна гэдэг бүр шийдвэр гаргуулдаг, тэр нь олон

нийтийн хяналттай ийм зөвлөл байгуулах ёстой. Энэ зөвлөлөөр дамжиж шийдвэр нь гарах ёстой. Тухайлах юм бол бид элэг сольдог болчихсон л гээд байгаа. Тэгтэл цусны бүлэг ижил биш улсуудад бид элэг сольж чадахгүй л байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр зөвхөн өвчний төрөл гээд код тавьчихаад болохгүй шүү. Энэ дээр бүр яг мэргэжлийн зөвлөлийн шийдвэр нь гараад яг энэ тохиолдлыг хийж чадахгүй юм байна, хүндрэх юм байна гээд энэ асуудлыг шийдэхийн тулд заавал зөвлөл ажилладаг.

Дараагийн нэг асуудал бол хүүхдийн өвчнийг та 50 хувийг нь даачих юм сан гэсэн бодож байгаа бодол байна. Зөв. Би бас энэ дээр их талархалтай байна. Гэхдээ болж өгвөл нэгэнт Монголдоо эмчилж чадахгүй гэж байгаа бол 100 хувь даах энэ боломжийг бид эрэл хайгуул хийх ёстой. Үүний төлөө ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Бид бас дараагийн нэг хэлье гэсэн санаа бол түрүүн бас энэ хорт хавдрын өвчлөлийн тухай ярьж байна. Манайд тохиолдож байгаа энэ нас баралтын гол шалтгаан болж байгаа энэ хорт хавдрууд дандаа урьдчилан сэргийлэх боломжтой хорт хавдрууд шүү дээ. Урьдчилан сэргийлэх боломжтой, эрт илрүүлэх юм бол эмчлэх боломжтой хорт хавдрууд. Тийм учраас эрт илрүүлэх үзлэгтээ энэ бодлогын хувьд хорт хавдрын хөтөлбөрөө буцаагаад “дэд хөтөлбөр” биш жинхэнэ “үндэсний хөтөлбөр” болгооч ээ. 24 онд би таныг үүнийг хийгээсэй гэж хүсэж байна. Хорт хавдартай тэмцэх. Үгүй ээ энэ чинь нэг элэгний хавдар, ходоод, улаан хоолой, уушгины хавдрыг бид эрт илрүүлж болж байна. Сая бид чуулганаараа умайн хүзүүн хорт хавдрын вакциныг товлोलт вакцинд оруулж чадлаа.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгээд хуулийн төслийг дэмжиж байгаад бас талархаж

байна. Ер нь бид нар гол нь энэ шинэ технологи нэвтрүүлэх, оношилгооны шинэ технологи нэвтрүүлэх, эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэх энэ ажил руу л нэлээн гол анхаарал хандуулна гэж бодож байгаа. Олон жил яригдаж байгаа асуудал юм байна лээ. Хамгийн гол нь тэр технологи нэвтрүүлэх зардлынх нь асуудлыг шийдэж өгөхгүй бол энэ шинэ технологи нэвтрүүлнэ, нутагшуулна гэдэг асуудал бол явахгүй байгаад байгаа юм. Чинбүрэн эмч өөрөө эмч хүн мэдэж байгаа надаас илүү мэдэж байгаа, мэдэж байгаа. Нэг технологи нэвтрүүлнэ гэхэд л доод тал нь 50 тохиолдол хийгдсэн байх ёстой гэдэг юм байна лээ шүү дээ. Тэгээд тэр 50 тохиолдлыг хийнэ ээ гэдэг чинь асар их хэмжээний хүч хөрөнгө зарцуулна л гэсэн үг. Тэрийг нь шийдэж өгөхгүй өгөхгүйгээр энэ явахгүй юм байна гэж. Би хэдийгээр мэргэжлийн бус хүн ч гэсэн бас тэгж ойлгож үүнийг нь шийдэж өгье л гэж байгаа юм.

Шинжлэх ухаан технологийн сангаас манайх бас нэг хэсэг нь төсөл явуулаад санал авдаг юм, төсөл авдаг юм байна лээ. Тэгээд энэ тэр нь бас их дэмжлэг багатай байгаад байгаа юм. Би тэр гишүүд яриад байгаатай би 100 хувь санал нэг байна. Эрүүл мэндийг дэмжих сангийнхаа энэ хөрөнгийн журмыг Засгийн газар оруулж батлуулахдаа ямар нэгэн үг хэл гаргахгүй байхаар, эрсдэл үүрэхгүйгээр, тэгээд энэ бусад сангуудын жишиг шиг тэгээд муу нэртэй сан болгочихгүй байх вий л гэдэг. Энэ миний толгойны өвчин байгаа. Маш олон талаас нь бодож байгаа. Эрсдэл гаргачих вий дээ, цөөхөн хүн хамрагдсан, танил талаараа, албан тушаалтнууд авдаг ийм сан болгочих вий дээ гээд ингээд бас нэлээн болгоомжлол байгаа. Үүнийг ялангуяа тэр олон нийтийн хяналттай эд нар байх эд нар гээд энэ санаануудыг бид нар авч хэрэгжүүлнэ.

Хамгийн гол нь бид нар нэг юм цаашдаа энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуулиа батлуулаад, иргэний эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр

нөлөөллийн ажил маш сайн хиймээр юм байна лээ. Халдварт бус өвчин энэ хавдар, халдварт бус өвчинг би, энэ бол үндсэндээ бүрэн эдгэх боломжтой өвчин. Хамгийн гол нь энэ хавдраар өвчилж байгаа иргэдийн маань харамсалтай нь 74 хувь нь хожуу оношлогдож байна л гэдэг мэдээ гараад байгаа юм. Хожуу оношлогдож байна. Бараг л эцсийн шатдаа очсон хойноо л манайх оношилгоонд ороод. Тийм учраас энэ эрт илрүүлэг оношилгоо дээр бид нар нэлээн тийм шинэ технологи нэвтрүүлэх, нэлээн тийм шинэчлэл хийх хэрэгтэй юм байна лээ. Нэлээн тийм эрс шинэчлэл хийхгүй бол 74 хувь нь хожуу оношлогдоод л яваад байвал бидний энэ ажил нэлээн урагш гарахгүй. Тийм учраас нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудлыг шинэ шатад гаргах, иргэний эрүүл мэндийн боловсролыг шинэ шатад гаргах, тэгээд энэ эрт илрүүлэг, оношилгоо шинжилгээ дээрээ нэлээн бас тийм эргэлт хийхгүй бол энэ нэлээн ахиц гарахгүй ээ гэж би санал нэг байна.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Тэгэхээр энэ бидэнд түрүүн нөгөө хэлээд байгаа сайн туршлага гэдэг маань Монголдоо хөрөнгө оруулалтыг дэмжээд, тэгээд таны хэлж байгаа зөв л дөө. Ер нь нэг хагалгааг жишээлбэл шинэ технологийг нэг 50 удаа Монгол эмч нар маань гаднын зөвлөхүүдийнхээ хяналт доор хийчихнэ гэдгээ л сурчаж байгаа арга. Тэгээд л хэвшээд л практикт орчихдог. Юм эхлэхэд хэцүү байдаг. Эхэлсний дараа энгийн л болдог. Яг энэ жишээ бол эртхэн шилжүүлэн суулгасан, бас нойр булчирхайн хагалгааг Монголд нэвтрүүлэхэд 220 сая төгрөгийн “цөм технологийн сан”-аас дэмжлэг аваад өнөөдөр Монголчууд бид өөрсдөө хийж чаддаг болоод байж байгаа.

Тэгээд бас бид үнэхээр эмчлээд эмчлээд дэлхий даяар эмчилж чадахгүй, үр дүн нь гарахгүй болчихсон улсууд маань бас хөөрхий Монгол эмч нартаа

итгэхгүй, Монголын эрүүл мэндийн салбартаа итгэхгүй, гадаад явж заавал хайнаа хагална гэдэг. Тэгэхээр энэ бол ийм өвчнүүдийг санхүүжүүлэх нь өөрөө утгагүй л дээ. Тийм учраас бид заавал энэ зөвлөлдөө мэргэжлийн зөвлөлүүд байж, ажиллаж үүнийг дэмжих нь өөрөө их чухал юм.

Л.Мөнхбаатар: Чинзориг сайд тодруулгад нэмж хариулъя.

С.Чинзориг: Тэгээд энэ хууль ингээд дэмжигдээд, хэлэлцэх эсэх нь дэмжигдээд батлагдвал би гишүүдтэйгээ бас нэг зүйл дээр бас нэлээн ярилцмаар байгаа юм. Энэ журам дээрээ нэлээн сайн ярьж саналыг нь авъя. Ялангуяа Байнгын хороон дээр.

2 дахь асуудал нь гаднаас дотоодод шинэ технологи Монголдоо шинэ технологи нэвтрүүлэх асуудал дээр бид зөвхөн анхаарах юм уу, эсвэл цаашдаа энэ орон нутагт төлөвлөлийг сааруулах хүрээнд, орон нутгийг чадавхжуулах хүрээнд орон нутаг Монголд энэ нутагшчихсан технологийг орон нутгийн нэгдсэн эмнэлгүүд бас нэвтрүүлэх нутагшуулахад нь бас дэмжлэг үзүүлэх ёстой юу, үгүй юу гэдгийг бас нэлээн бас яримаар юм байна лээ. Би орон нутгийг бас чадавхтай болгоход нь нэгэнт одоо 1 дүгээр эмнэлэг хийгээд чадчихсан, 2 дугаар эмнэлэг хийгээд чадсан бол орон нутгийнхан хийж чадахгүй байгаа бол тэрийг нутагшуулахад тэр багийн энэ чадавхтай болгодог энэ бас дэмжлэг ч гэсэн бас байх нь зөв юм болов уу гэсэн бодолтой байгаа. Тэгээд ийм юмнуудаа бид нар Байнгын хороо дээрээ гишүүдийнхээ саналыг бас нэлээн бас ярина гэсэн ийм бодолтой байгаа.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын

гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөе.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Энэ өдрийн мэнд. Тэгээд их чухал хууль орж ирж байна. Энэ Монгол Улсын Засгийн газрын Эрүүл мэндийн яамнаас бас хүнээ бодсон, хүн рүүгээ чиглэсэн ийм л зүйлийг гаргаж ирж байна. Тэгээд 10 тэрбум гэхээр жоохон бага л санагдаж байна. Гэхдээ яах вэ, юм эхлүүлж байгаа учраас урьд нь зарцуулж байсныгаа бодвол хамаагүй л илүү болж эхэлж байгаа юм байна. Ер нь тэгээд 26 төрлийн энэ өвчний ирэх 24 оноос бид нар яг алинаас нь эхэлбэ гэсэн ер нь төлөвлөгөө байгаа вэ? Энэ тал дээр бас судалгаа хийсэн юмнууд байгаа юу?

Дээрээс нь ер нь тоног төхөөрөмж нь л байж байвал энэ 3 дахь шатлалын эмнэлэг дээр, аймгийн нэгдсэн эмнэлгүүд дээр хийх боловсон хүчнүүд бас байдаг юм байна лээ. Одоо жишээ нь өвдөгний үеийг Хэнтийн нэгдсэн эмнэлэг дээр сольчихъё л гэж байгаа байхгүй юу. Бид нар чадна, тоног төхөөрөмж л хэрэгтэй байна гээд. Тэгэхээр бас яг ийм орон нутагт нутагшуулахад эндээ нутагшчихсан, орон нутаг руу хийдэг болгоход шаардлагатай ийм судалгаа ер нь юмнууд ямархуу байдаг вэ?

Ер нь нийгмийн эрүүл мэндийн асуудал маш чухал. Хэдийгээр ингээд эрт илрүүлэг явж байгаа ч гэсэн өнөөдрийн нөхцөл байдал бол бүр сүүлийн шатдаа оччихсон хойно илрүүлж байгаа. Бас эхний шатдаа илрүүлж байна. Гэхдээ ер нь явж явж бид хүүхдийг бүр багаас нь энэ чихэрлэг ундаа юмнудаас хол бай гэж эцэг эх нь анхаарал тавихаас гадна энэ эрүүл мэндийн боловсролын ийм хичээлүүд ер нь бас яаж орж байгаа вэ? Энэ тал дээр ер нь ЭМЯ, Боловсролын яамтай ер нь яаж хамтарч ажилладаг вэ? Бид хоол ундны хэрэглээнээс авхуулаад л энэ хүүхэд байхаас нь л эхлэх нь би зүйтэй

юм болов уу л гэж ингэж бас боддог юмнууд байгаа юм.

Тэгээд ер нь яах вэ, журам боловсруулахад бас Байнгын хороогоороо орох уу яах вэ гээд ингээд ярьж байх шиг байна. Ер нь саналыг нь сонсоно гэж байх шиг байна. 1 дүгээрт, ер нь тэр технологио Монголдоо суулгах, эмч нараа сургах, тэгээд дараа нь тэр төлбөрийг нь төлөх ийм юм руугаа бас эрэмбэ дараатай байвал яадаг юм бол гэсэн ийм санал байгаа юм. Одоо энэ хууль ингээд л батлагдахаар магадгүй 01 сарын 01-нээс авхуулаад л маш их дарааллууд үүсэх байх. Тэгэхээр үүнийг бас нэлээн бас тал талыг нь бодож энэ дүрэм журмаа гаргаж, эртхэн зөв ойлголтуудыг нь тэр өгөхгүй бол та бидний энэ батлагдаж байгаа энэ хуулийг маань эргээд бас янз янзаар буруу зөрүү ойлгох, мушгих, гомдох тэгээд л янз янзын л юм гардаг даа гэж бас хэлэхийг хүсэж байгаа юм. Тэгээд энэ эхний 3 асуултдаа хариулт авъя гэж ингэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Содномын Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Ер нь би сая ч бас Чинбүрэн гишүүний асуултад хариулахдаа хэлчихлээ. Ер нь шинэ технологийг зөвхөн Монгол Улсад нэвтрүүлэх биш Монголд нэвтэрсэн ч гэсэн энэ төрөлжсөн эмнэлгүүддээ нэвтэрчихсэн, орон нутгуудад нэвтрээгүй байгаа технологийг бас нэвтрүүлэх энэ асуудал дээр нэлээн дэмжлэг үзүүлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Ингэж чадах юм бол иргэдийн бас энэ чирэгдэл нэлээн багасна. Энэ төрөлжсөн эмнэлгүүдийн ачаалал очер дараалал ч нэлээн бас буурна. Тийм учраас энэ төрөлжсөн эмнэлгүүдээс чадавх багийн баг бас орон нутгуудад бас ажиллуулах, орон нутгийн эмч нарыг бас тодорхой хэмжээгээр төрөлжсөн эмнэлгүүд дээр ирж бас чадавх суулгах эд нар ийм чиглэлийн дэмжлэгийг нэлээн сайн бас өгч, дэмжлэг үзүүлж ажиллах нь зүйтэй

гэсэн ийм бодолтой байгаа. Ингэж чадах юм бол орон нутгийн эмнэлгүүд ч гэсэн бас нэлээн чадавхтай болох, тусламж үйлчилгээ үзүүлэх хүчин чадал нь нэмэгдэх, орон нутгийн иргэд ч гэсэн зөвхөн Улаанбаатар хот явж энэ эмчилгээ шинжилгээнд орохгүй байх. Энэ асуудал нэлээн жигдрэхэд буурах болов уу гэж бодож байна.

2 дахь асуудал нь тэр 26 төрлийн өвчнөөс би энэ ирэх жил тэдийг нь бууруулж, тэдээр бууруулж чадна гэж хэлж чадахгүй байна. Яагаад ингэж хэлж байна вэ гэхээр энэ хууль батлагдсаны дараагаар бид нар журмаа батлуулна. Тэгээд яг ийм чиглэлийн өвчнийг эмчлэх, оношлох шинэ технологийг нэвтрүүлэх шаардлага хэрэгцээ байна гэдгээ би яам зарлах байх гэж бодож байгаа. Зарлах байх, зарлана. Тэгээд тэр технологи нэвтрүүлэх тэр үйл ажиллагаанд хэчнээн эмнэлэг яаж орж ирэх нь вэ, түүнээс болж шалтгаална гэж. Тийм учраас бас үүнийг би яг тэдээр бууруулна гэж бас тоо хэлэхэд арай эрт байна гэж бодож байна.

3 дахь асуудал нь иргэний эрүүл мэндийн боловсрол олгох асуудал дээр бид нар нэлээн анхаарал хандуулах ёстой. Ер нь энэ иргэн хүний эрүүл байх, урт наслах энэ чинь энэ иргэн хүний тэр өөрийнх нь амьдралын зөв хэв маяг, зөв дадал зуршлаас хамааралтай, 55 хувь нь иргэний тэр зөв амьдралын хэв маягаас хамааралтай гэсэн ийм судалгаанууд байгаад байна шүү дээ. Тийм учраас иргэндээ энэ эрүүл амьдралын зөв хэв маяг бас олгох асуудлыг нөлөөллийн ажлыг Боловсролын яам, БХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Спортын сайдтай хамтарч явуулна. Бид нар 5 сайд хамтраад Засгийн газраар тогтоол гаргасан. 5 сайд хамтраад иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх энэ төлөвлөгөө бас гаргах гэж байгаа. Ингээд энэ чиглэлээр холбогдох яамнуудтай нэлээн ажиллана. Энэ иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх гэдэг асуудал зөвхөн Эрүүл мэндийн яамны асуудал бус салбар хоорондын уялдаа холбоо зохицуулсан асуудал учраас

нэлээн яамнуудтайгаа бас ажлаа нэлээн уялдуулж ажиллах ийм шаардлагууд байгаа гэж үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Наянтан Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Эрүүл мэндийн дэмжих сангийн мөнгөний зарцуулалт дээр бид нар нэг юмыг маш сайн анхаарах хэрэгтэй байна. Манай эмч нар чадалтай нь чадалтай шүү, чадвартай, манай сувилагч нар чадвартай. Харамсалтай нь чадвартай, чадалтай боловсон хүчнээ бид нар алдаад, гадагшаа нэлээн том урсгал явуулчихлаа. Үүнийгээ татаж авах тал дээр энэ сангийнхаа мөнгийг бас зарцуулбал илүү үр дүнтэй болох байх гэж боддог юм.

Ер нь манай гэр бүлийн хувьд ер нь Монголдоо бүгд эмчлүүлдэг. Одоо байнгын эрт илрүүлэг тэр оношилгоонд ордог. Манай аав 90 хүрч байгаа. Ер нь 90 нас хүртлээ яг л Монголынхоо эмч нараар эмчлүүлж, Монгол эмч нарынхаа энэ хүчин чадвартай энэ хүмүүс эмч нарын хүчинд өнөөдөр 90 хүрч байгаа гэж би ойлгодог. Ер нь яах вэ, зүгээр бас тодорхой хэмжээнд гадаадад ганц нэгэн удаа очиж, өөрийнхөө эргэлзээг тайлах байдлаар үзүүлж байсан. Тэгэхдээ яг л манай эмч нарын тэр хэлдэг онош, тэр бүх юмнуудыг л хэлдэг. Тэгэхээр бид нарт нэг л ийм л боломжоо л улам сайн болгох ёстой л доо. Өнөөдөр байгаа боломжоо орчныг нь сайжруулмаар байна, тоног төхөөрөмжийг нь нэмэгдүүлмээр байна. Эмч нарынхаа, тэр боловсон хүчнийхээ тэр гадагшаа явж байгаа урсгалыг магадгүй бид нар гадаадаас эмч нар татаж оруулах тал дээрээ бас ажиллах хэрэгтэй. Ер нь зүгээр байгаа мөнгөө гадаад руу бусад улс орон руу явж байгаа эмчлүүлж байгаа хүмүүст өгөх юм бол манай төсөв битгий хэл бүх мөнгө ч дийлэхгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ маш болгоомжтой л анхаарч л ажиллах хэрэгтэй байх л даа.

Би зүгээр гэмтлийн эмнэлэг дээр сая тэр нөгөө Түлэнхийн төвийг сайжруулчихсан байна, зассан байна,

янзалчихсан байна. Маш сайхан үйлчилгээтэй болсон байна, болж байна шүү дээ, ингээд л боломжуудыг нь л хийгээд өг л дөө. Тэр залуучууд яасан их чадалтай болсон юм, маш их шуурхай, зөв үйлчилгээтэй болсон байна. Энэ хүмүүсээ л бид нар тэр орчныг нь нэмэгдүүлээд, хэрвээ хувийн эмнэлгүүд баригдсан бол тэнд боловсон хүчин дээр нь анхаараад, тэнд орчин нь байгаад байдаг, чадалтай эмч нар алга. Улсын эмнэлэгт чадалтай эмч нар байна, орчин муу байна. Энэ хоёрынхоо тэр ялгаа зөрөөг нь гаргаад энэ дээрээ энэ сангийнхаа мөнгийг зарцуулах хэрэгтэй байх л даа. Ингэж чадах юм бол бид нар өөрсдийнхөө хүчин чадал, боломжид анхаарч ажиллаж чадвал Монгол Улсад эрүүл мэндийн салбар илүү хөгжинө. Ер нь бас сая хүмүүс хэлээд байна. Тэр эрт илрүүлэг гэдэг тэр үйл ажиллагаагаа улам маш сайн тогтмолжуулмаар байна. Ер нь сумд байгаа ч тэр, баг дээр байгаа ч тэр, хөдөө малаа маллаж байгаа малчин хүртэл тэр эрт илрүүлгийн мөн чанарыг ойлгодог, жилдээ нэг заавал оношилгоонд орчихдог, өөрийгөө бас нэг үзүүлчихдэг, харуулчихдаг бол Монгол хүн эрүүл байх ийм боломж байгаа.

Ер нь өвчин дотроос бас нэг хэд хэдэн өвчин бас маш анхаарал татаж байгаа. Энэ цусны төрлийн өвчнүүд дээр Монгол Улс бас жоохон боловсон хүчин, хүчин чадал тэр технологийн хувьд бас хоцрогдсон байна. Энэ дээр нэлээн их ажиллах хэрэгтэй байна.

Тэр сахрын өвчин чимээгүй тахал боллоо. Энэ сахрын өвчний асуудал дээр ер нь Монгол Улс тодорхой том арга хэмжээ хийх зайлшгүй шаардлагатай байна. Японд сахрын өвчтэй хүмүүсийг бүр группэд оруулдаг тийм ээ, манайхны хэллэгээр. Ийм хүртэл асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр бас анхаараач ээ гэж хэлье. Тэгээд ер нь өөрсдөдөө итгэж, өөрсдийнхөө чадамж боломжийг нэмэгдүүлэх тал дээр сангийнхаа мөнгийг илүү түлхүү зарцуулах, тэгвэл илүү үр дүнд хүрнэ гэж хэлье.

Л.Мөнхбаатар: Ганибал гишүүн тодорхой саналууд хэлж байна. Асуулт байгаа юм уу? Чинзориг сайд хариулчихъя. Сахрын өвчин группэд оруулдаг ийм зохицуулалт байгаа юу гэж асууж байна.

С.Чинзориг: Ганибал гишүүний асуултад хариулъя. Тэгээд энэ үндсэндээ би Ганибал гишүүнтэй санал нэг байгаа юм. Энэ хууль батлагдсанаар бид нар аль болохоор энэ гадагшаа эмчилгээнд эмчлүүлэхээр явж байгаа иргэдийн урсгалыг л бууруулахын төлөө л байгаа юм. Хамгийн гол нь боловсон хүчнээ бэлтгэх, чадавхжуулах, тэр оношилгоо, эмчилгээнийх нь тоног төхөөрөмжийг, хүртээмжийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна. Бид нар ер нь оношилгоо дээр ч гэсэн, шинжилгээ дээр ч гэсэн бас шинэ технологи нэвтрүүлэх зайлшгүй шаардлага байгаа шүү дээ. Одоо бид нарт үндсэндээ зөвхөн энэ хавдрыг чинь дүрс оношилгоогоор л нөгөө ситигээр л оношилж байна шүү дээ. Цацраг, цацраг идэвх юу юугаар. Тэгээд цаашдаа оношилгоонд энэ бас шинэ технологи нэвтрүүлэх, заавал дүрс оношилгоогоор биш цусаар ч юм уу энэ хавдрыг эрт үед нь илрүүлдэг эд нар байх гээд. Ийм технологиудыг нэвтрүүлэх асуудал манайд үнэхээр их чухал байгаа.

Ер нь цаашдаа гишүүдэд хэлэхэд эрүүл мэндийн салбар дээр би сайдаар томилогдож очоод манай эрүүл мэндийн салбар дээр иргэдийн зүгээс маш их тийм шүүмжлэл байх юм. Юун дээр байна вэ гээд үзэхээр эмчилгээ тусламжтай холбоотой асуудал дээр заавар стандарт нэлээн сайн гарсан юм байна. Яг эмчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой асуудал дээр үг хэл гайгүй юм байна. Юун дээрээ алдаад байна вэ гэхээр эрүүл мэндийн салбар чинь өөрөө үйлчилгээний салбар, үйлчилгээний салбар байж бид нар эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөгдөх үйлчилгээний стандарт гэж байхгүй юм байна гэж байна. Тэгээд бид нар ер нь үйлчилгээний стандарттай больё гээд стандарт боловсруулаад хэмжил зүйн

хороогоороо батлуулсан. Одоо энэ үйлчилгээний стандартыг эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөгдөж эхлүүлэх юм бол иргэдэд бас аль болохоор хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй үйлчлэх ийм асуудлууд нэлээн жигдрэл болж.

2 дугаарт, эрүүл мэндийн салбарт энэ менежментийг сайжруулах асуудлаар бид нэлээн бас ажиллах шаардлагатай юм байна лээ. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн энэ менежерүүдийг бэлтгэх чадавхжуулах, ингэж байж энэ эрүүл мэндийн салбарын менежментийг сайжруулах тал дээр нэлээн анхаарал хандуулсан зайлшгүй шаардлагатай юм байна гэж бодож байгаа. Ийм чиглэлийн бас өөрчлөлтүүд хийхийг хичээж байгаа гэдгийг хэлье.

Таны аавд эрүүл энхийг хүсье, сайхан байна. 90 нас. Энэ бол ерөөсөө л явж явж, та бас аавыгаа бас судалж үзээрэй. Ерөөсөө л энэ иргэний өөрийнх нь амьдралын зөв хэв маягтай л холбоотой байгаа. Буруу дадал зуршлаас хол байж чадсан, зөв амьдралын хэв маягтай явж ирсний л бас үр дүн байх гэж бодож байна. Тийм учраас миний яриад байгаа энэ иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэдэд амьдралын зөв хэв маяг хэвшүүлэх, муу дадал зуршлаас хол байх эд нар гээд асар их асуудлууд байгаа юм байна лээ. Иргэдэд нөлөөллийн ажил хийх асар их ажлууд байна.

Л.Мөнхбаатар: 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын хурлаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил

амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ өнөөдөр бас чухал хууль орж ирж байна даа. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн талаар. Энэ 10 тэрбум гээд ярьж байна. Энэ арай бага байна. Бүхэл бүтэн Монгол Улсын эрүүл мэндийг дэмжих сан нь аравхан тэрбум. Гэтэл 1 сумын 1 аймгийн үерийн хамгаалалт ч юм уу, 1 соёлын төв Богдзонх 30 хэдэн тэрбум хуваарилчихдаг. Гэтэл Монгол Улсын эрүүл мэндийн салбарын дэмжих санд нь аравхан тэрбум. Тэгээд гадаад явахгүй яадаг юм. Энэ дээр анхаарах цаг нь болсон. Гишүүд энэ дээр анхаараарай.

Тэгээд энэ гол нь энэ хэд хэдэн заалт байна лээ. Зарцуулалт дээр нь. Би эрүүл мэндийн салбарын анхан, дунд шатад ажиллаж байсны хувьд эмнэлгийн дарга ч хийлээ, эрүүл мэндийн газрын дарга ч хийлээ, эмч ч хийлээ. Ер нь сурталчилгаа хангалттай явагдсан. Нийгмийн эрүүл мэндийн салбар ер нь анхан ба дунд шат дээр анхаарахгүй бол дээгүүр яаман дээр авчраад нэг хэдэн хүн хурал хийдэг, орон нутагт бас сурталчилгаа сайн явагдахгүй тийм асуудал байгаа. Тоног төхөөрөмжүүд үнэхээр дутагдалтай байгаа нь үнэн. Эмч нар чадвартай байна. Орон нутагт хагалгаа юм уу, зарим эмчилгээ хийе гэхэд вакумжсан өрөө байхгүй, тоног төхөөрөмжүүд дутагдалтай, эмч нарын ур чадвар хүрэхгүй, хотоос эмч дууддаг энэ бол нуухын аргагүй үнэн. Тийм учраас энэ салбарт анхаарах цаг нь ирсэн.

Энэ 19.3.1 дээр энэ нэг нэмэх санал байгаа юм байна. Тэрийг оруулсан уу? Жишээлбэл дунд сургууль дээр 8 дугаар ангиас ч юм уу, 6 дугаар ангиас эрүүл мэндийн урьдчилан сэргийлэхийн хичээл орох заалтыг бас оруулах шаардлагатай байгаа юм. Тэгэхгүйгээр зүгээр яриад л энэ зарим юм болохгүй юм.

Эмийн зохистой хэрэглээний талаар эм, эмнэлгийн агентлаг байж байна. Том агентлаг. Эд нар чинь сурталчилгаагаа хийх ёстой. Эмч нарыг сургах асуудал дээр жишээлбэл хэдэн жилийн өмнө чинь тэрбум 700 сая тавиад тэгээд 1 цөөхөн л эмч явсан шүү дээ. Сургалт дээр. Яг ажлын байрны сургалт дээр анхаарахгүй бол болохгүй цаг нь болсон. Үүнтэй холбоотой хэд хэдэн асуудал асууя гэж бодож байна.

Сая нөлөөлөх хүчин зүйлийг судална гэсэн байна, та. Гол нь энэ сангийн хөрөнгө зарцуулах журам, шалгуур үзүүлэлт тодорхой болсон уу, 1 дүгээрт.

Үндэсний аюулгүй байдалтай холбоотой өвчлөл ихсэж байна, хавдар залуужиж байна. Энэ хүнтэй холбоотой байна уу, эмийн хор чанартай холбоотой байна уу. Энэ талаар энэ юундаа оруулж байгаа юу, та.

Нөгөө талаар түрүүн Чинбүрэн гишүүний ярьсан асуудал дээр би дэмжиж байгаа юм. Би энэ Эрүүл мэндийн даатгалын сангуудын гадаад орнуудын Эрүүл мэндийн даатгалын сантай хоорондоо гэрээ хийх асуудал маш чухал байгаа. Та зүгээр энэ эмнэлгийн эмчлүүлсэн хүний төлбөрийг төлнө гэвэл таны ачаалал ч хүндрэнэ. Нөгөө талаар энд юу нь ч хүрэхгүй. Жишээлбэл 150 сая төлөөд л эмчилгээний зардал төлж байснаас нэг ЭМД хоорондоо гэрээ хийхэд даатгалын юуг нь нэг 1 хүнд 10 хэдэн сая юм уу, 20 сая даатгалын юуг нь төлчихвөл олон хүнд хүртээмжтэй болно. Тийм учраас үүнийг би 3 жил ярьж байна. Солонгос, Энэтхэг, Турк улсад ЭМД хоорондоо гэрээ хийх шаардлагатай байгаа юм. Тэгсэн тохиолдолд энэ бас хөнгөлөлттэй тусна, танд.

Гол нь энэ ажлын байрны сургалтыг орон нутаг, сум дээр олон тоног төхөөрөмж очсон, ажиллуулж чадахгүй, тийм тоног төхөөрөмжүүд байж байгаа. Энэ дээр анхаараад орон нутагтаа сургалт сурталчилгаа хийгээд, хагалгаагаа

заагаад, арга барилыг нь заачихвал бас энэ ажил ч ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулсны дараа тодруулж болно. Хариулт хангалтгүй гэж үзвэл тодруулах дэгтэй. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулъя.

С.Чинзориг: Бейсен гишүүний асуултад хариулъя. Одоо тэгээд нөгөө чамлахаар чанга атга гэж үг бий дээ, Бейсен гишүүн ээ. Энэ жилийн 2023 оны төсөв дээр Эрүүл мэндийг дэмжих санд 2 тэрбум төгрөг хуваарилсан. Тэгээд хэрдээ л хөөцөлдөж байгаад Сангийн яамтайгаа ойлгуулж явж байгаад тэгээд 5 дахин нэмэгдүүлээд л 10 тэрбум төгрөг болгочихлоо. Тэгээд би үүнийг чамлаад яах вэ л гэж бодож байна.

Хамгийн гол нь энэ 10 тэрбум төгрөгийг нь ямар нэгэн үг хэлгүйгээр, ямар нэгэн буруу зарцууллаа гээд нөгөө бусад нөгөө сан шиг муухай нэртэй сан болгочихгүй байх уу гэдэг л чамлахаасаа илүүтэйгээр миний толгойны өвчин болчихоод байна л гэж бодож байна. Тийм учраас энэ хуулиа баталсны дараагаар сая та журам нь бэлэн болсон уу л гээд байна. Журмыг нь Засгийн газар батлах юм. Тэгээд тэр гадаад эмчилгээтэй холбоотой асуудлуудыг нэлээн сайн нарийн журамлах хэрэгтэй. Нэлээн нарийн зохицуулж журамлахгүй бол асар их хүлээлт үүсгэхээд бас нэг бөөн үг хэл болчих вий гэж би их болгоомжилж байна.

Шинэ технологи нэвтрүүлнэ гэдгээ ямар технологийг хэлэх вэ гэдэг нэг асуудал. Зөвхөн Монголд шинээр нэвтрүүлэх гэж байгаа технологийг дэмжлэг үзүүлэх үү, төвдөө төрөлжсөн эмнэлгүүдээр бий болчихсон технологийг орон нутгийн эмнэлгүүддээ нэвтрүүлэх, чадавх бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах чиглэлээр хийх технологийг бас технологи нэвтрүүлсэн гэж үзэж дэмжлэг үзүүлэх үү энэ тэр гээд асар их олон бас зөв гарцыг нь олж, зөв шийдлийг нь олох асуудлууд байна. Тийм учраас тэр журмыг

нь Засгийн газраар оруулж батлуулахдаа би нэлээн анхаарна. Шаардлагатай бол Байнгын хорооныхоо гишүүдэд ч гэсэн танилцуулж, саналыг нь авна гэсэн ийм бодолтой байна.

Хавдрын шалтгаан, ер нь хавдартай тэмцэх асуудал зөвхөн Эрүүл мэндийн яамны ажил биш ээ. Энэ асар их тэр салбар хоорондын асуудал, нөлөөллийн асуудлууд маш их хийх хэрэгтэй байна. Уушгины хавдраар өвчилж байгаа иргэдийн чинь 40 хувь нь энэ агаар орчны бохирдлоос үүдэлтэй гэсэн ийм судалгаа байдаг юм байна лээ шүү дээ. Агаар орчны бохирдлоос үүдэлтэй. Тэгэхээр энэ ерөөсөө зөвхөн Эрүүл мэндийн яамны асуудал биш. Энэ шалтгаануудыг нь бас зөв оношилж, арилгах асуудал бол салбар хоорондын асар их том зохицуулалт шаардсан ийм ажлууд байгаа юм байна лээ.

Манай дээр асар их хэмжээний тоног төхөөрөмжүүд байна, ашиглалт их муу байна. Хамгийн нэг гол юм нь засвар үйлчилгээний асуудал. Үнэхээр бид нар өөрсдөө хийж чадахгүй байгаа юм байна лээ. Тийм учраас энэ орчин үеийн тоног төхөөрөмжүүдийг ашиглалтыг сайжруулах, тэр засвар үйлчилгээг нь бас сайжруулах асуудал анхаарна. Бусад гадаад улс орнуудтай гэрээ хийх боломж, үйлчилгээ авах боломжийг бид нар нэлээн судалж үзье ээ. Яг тийм гарц нь ямар байдаг. Зайлшгүй тэр орондоо Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгч л байж байж энэ асуудал зохицуулагдана шүү дээ. Тэгээд үүнийг ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулж асуух уу, юу, яах юм, ажлын хэсэг хариулах юм уу? Нэмээд хариулчихъя. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Баярболд дарга хариулъя.

Д.Баярболд: Бейсен гишүүний асуултад хариулъя. Ерөнхий боловсролын сургуулиудад эрүүл мэндийн боловсрол олгох хичээлд 4-12 дугаар ангиудад бүрэн орж явж байгаа. Эрүүл мэндийн салбарын хувьд хичээлийн агуулгад энэ саналыг

өгөөд хамтран боловсруулаад явж байгаа. 5 яамны хамтарсан иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох энэ сургалт арга хэмжээний төлөвлөгөөнд бас энэ эрүүл мэндийн хичээлийн орж байгаа багш нарыг чадавхжуулах, хяналт үнэлгээгээ тогтмол хийх, энэ дээр ямар нэгэн үл тохирол гарвал үүнийг тухай бүрд нь засаж явахаар энэ арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байгаа.

Мөн нөгөө энэ тусгай сангийн одоо мөрдөгдөж байгаа хууль дээр энэ халдварт болон халдварт бус өвчний үүсгэж байгаа хүчин зүйлсийг судалгаа хийх асуудал одоо мөрдөгдөж байгаа хууль дээр тус байгаа гэдгийг нэмж хэлэх байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаагийн удирдлагаар Ховд аймгийн Ховд сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь өндөр амжилт, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ хууль нь орж байгаа юм чинь журам, шалгуур үзүүлэлт нь тодорхой болсон уу гээд асуусан шүү дээ, болсон байх ёстой, 1 дүгээрт.

2 дугаарт, Чинзориг сайд аа, энэ гадаадад эмчлүүлж байгаа би өвчтэй хүүхэд олон жил эмчлүүлж байна. Туркт сурсны хувьд тэнд Эрүүл мэндийн даатгалын газартай ч уулзсан. Яам хоорондоо гэрээ хийгээч ээ. Даатгал хоорондоо. Тэгсэн тохиолдолд даатгалыг нь төлөөд л гэрээтэй гэдгээрээ компьютерт оруулчихдаг юм байна. Тэгээд зөвхөн даатгалын юугаа төлөөд л тэгээд болдог. Тэгээд эмчилгээний зарим хавдартай юман дээр 2 жил хүртэл байрны

хөлсгүй хоолтой нь эмчилдэг юмтай байдаг байхгүй юу. Тийм учраас үүнийг нэг судлах биш ээ, бид нар бас тусдаа энэ дээр газар дээр нь сургалт хийх тал дээр анхаараач ээ гээд хэлмээр байх юм.

Л.Мөнхбаатар: Чинзориг сайд тодруулгад хариулъя.

С.Чинзориг: Бейсен гишүүн ээ, журмын тухайд бид нар Сангийн яамтай эд нар хамтраад ажиллаж байгаа. Энэ хууль батлагдвал Засгийн газар энэ журмыг нь оруулж батлуулна. Тийм учраас миний хэлээд, яриад байгаа тэр ямар нэгэн иргэдэд чирэгдэл үүсгэхгүйгээр, буруу бас зориулалт бусаар ашиглахгүй байхаар л нэлээн сайн бодож байж энэ журмыг нь гаргана л гэсэн ийм бодолтой байгаа. Би хэлээд байгаа, шаардлагатай бол Байнгын хорооныхоо гишүүдэд бас танилцуулж саналыг нь ч гэсэн бас авна л гэсэн ийм бодолтой байгаа. Нэлээн чамбайн журам гаргаж байж хэрэгжүүлэхгүй бол асар их хүлээлт үүсгээд тэгээд бас буруу замаар будаа тээчих вий дээ гэдэг бас би надад маш их болгоомжлол байна. Тийм учраас нэлээн сайн зохицуулалт хийсэн ийм журам боловруулж Засгийн газар руу оруулж батлуулна гэсэн бодолтой байна.

Даатгалтай холбоотой асуудлуудыг бид нар судалж үзэхээс өөр арга байхгүй ээ, Бейсен гишүүн ээ. Тэр орон чинь тухайн оронд ажиллаж, амьдарч байгаа юм уу эсвэл даатгалын тухайн орныхоо Эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл төлсөн иргэндээ л тусламж үйлчилгээ үзүүлнэ шүү дээ. Тэгэхээр манай иргэнд Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай шууд гэрээ хийгээд шимтгэл төлөгч биш улс орнуудын иргэдэд төлбөр бага зардлаар эмчилгээ үзүүлнэ ээ гэдэг асуудал байх уу, үгүй юү гэдгийг. Тийм учраас би нэлээн судалж үзэж байж ийм бас чиглэлээр асуудал хангаад. Өмнө нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд ажиллаж явахад бид нар тийм гэрээ хийж байсан юм. Гадаад улс орнуудад ажиллаж байгаа иргэд тухайн орныхоо нийгмийн

даатгалын санд нь шимтгэл төлдөг учраас тэр орондоо ажилласан хугацаа, төлсөн шимтгэлд нь ноогдох тэтгэврийг нь тухайн орны нийгмийн даатгалын сангаас буцаан олгож байхаар гэрээ хийж байсан ийм туршлага бий. Гэхдээ ЭМД дээр шууд гэрээ байгуулаад шууд бас өртөг эмчилгээ үнэ төлбөргүй ч юм уу, бага зардлаар эмчилгээ хийнэ гэдэг асуудал нэлээн нарийн зохицуулж шаардах асуудлууд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Хассуурийн Ганхуяг гишүүнийг асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Өглөөний мэнд хүргэе. Яах вэ, энэ сэдэв дээр надад нэг 2 асуудал байгаа юм. Асуулт байгаа гэх юм уу.

1 дүгээр асуулт, Засгийн газар бол тусгай 25 сантай. Засгийн газрын нөөц сангаас бусад бүх сангууд зөрчилтэй. Том, жижгээсээ үл хамаарна. Нөгөө алдартай сангууд чинь зарим нэг нь 6, долоохон хувийн эргэн төлөлттэй. Би Чинзориг сайдыг дэмжиж байгаа. Тэгэхдээ яг энэ сангийн асуудлыг нь бас нэг дэмжмээргүй байгаа юм. Үүнийг зүгээр төсөв дээр нь мөнгийг нь тавиад явдаг баймаар байх юм. Тэгэх юм бол сайд өөрөө ч хяналтаа тавих боломжтой болно. Яг энэ сангууд дээр гарч байгаа асуудал юу вэ гэхээр ерөөсөө л дунд шатныхны найр. Зүгээр найрладаг. Тэгээд энэ чинь ингэж явж байгаад л өөрийнхөө таньдаг хүмүүстээ өгнө, авлига өгсөн хүмүүстээ энэ мөнгийг нь өгнө, ингээд л явчихна. Сайд тэр болгон шалгах чадваргүй, боломжгүй. Гоё, зөв л нэртэй, зөв л байгуулна. Тэгээд энэ чинь дандаа нэг ангийнхан нь ороод суучихна. Тэгээд энэ манай нийгмийн асуудлыг, эрүүл мэндийн асуудлыг ерөөсөө шийдэхгүй. Би үүнийг зүгээр баталгаатай хэлье. Наад чинь энэ сан байна шүү дээ, 5 жилийн дараа энэ энэ санг санаачилж байгаа тэр сангийн зөвлөлийн хүмүүс бүгдээрээ л тэр шоронд нь суух юм уу, эсвэл хэрэг үүсгээд л ингээд л явна. Ийм юм хиймээргүй байна.

2 дугаар асуулт. Солонгосын яг орчин үеийн эрүүл мэндийн тогтолцоог ерөөсөө бий болгосон хүмүүс нь 150 л эмч байдаг юм. Америкт очоод 10 жил ажиллаад гэрээтэй. Тэгээд буцаж ирээд энэ орчин үеийн Солонгосын эрүүл мэндийн тогтолцоог бий болгосон юм. Тэгээд бид нар өнөөдөр асуудал үүсэхээр яадаг юм бэ. Бид нар чинь бүгдээрээ л Солонгос явна, Солонгосын билет авна, виз авна, тэгээд л тэрийгээ хүн болгон гуйна. Над дээр ч гэсэн түм буман тийм хүсэлт байна, ядаж визийг нь гаргаад өгөөч гээд. Тэгээд бид нар нэг бол энэ 2 аргын нэгийг нь л хэрэглэмээр байгаа юм. Нэг өөл Солонгос энэ тоо та энэ нэгдсэн эмнэлгүүдээс нэгийг нь Солонгосын тэр эмнэлгүүдтэй юм уу эсвэл өөр А зэрэглэлийн эмнэлгүүдтэй урт хугацааны менежментийн гэрээгээр өгчихмөөр байна. Одоо бол эмнэлгүүд ашигтай ажиллаж байгаа. Тэрний ач холбогдол юу вэ гэхээр эрүүл мэндийнхээ даатгалаараа Монголын ЭМД-аар очоод тэр эмнэлэг дээр үйлчилгээ авах боломжтой болно. Тэр эмчлүүлж чадахгүй байгаа тэр өвчнөө тэр эмнэлэг дээрээ эмчлүүлэх боломжтой болно. Тэрийгээ дагалдаад ажиллаж байгаа Монгол эмч нар, сувилагч нар илүү туршлагатай болно.

Нэг бол эндээс зөрүүлээд гадагшаа том эмнэлгүүд дээр бид нар эмч, сувилагч явуулж дадлагажуулж авчрах хэрэгтэй. Ингэхгүй бол хамгийн сүүлийн мэргэжилтнүүдийн хэлж байгаагаар манайд ингээд Засгийн газар бол яг энэ ковидын үетэй холбогдуулаад асар их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Нэг асуудал юу байна гэхээр гоё эмнэлгийн байшин байна. Хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж байна. Эмч нар чинь ажиллуулж чадахгүй байна шүү дээ, үүнийг, ажиллуулж чадахгүй байна, оношилгоогоо сайн хийж чадахгүй байна. Мэдээж хэрэг би бүгдийг нь ярьж байгаа юм биш шүү. Манайд сайн явж байгаа юм гэвэл зүрх, судасны эмчилгээний юм бол маш сайн явж байна. Тэр гэмтлийн тэр нуруу, өвдөг тэр юуны эмчилгээнүүд маш сайн явж байж байна. Энэ бол ноу хаг авчирч чадаж байгаа байхгүй юу. Тэгээд

технологи гэдэг чинь бид нар тоног төхөөрөмж авчрахаар технологи нэвтэрнэ гэж ойлгоод байгаа юм. Технологи гэдэг чинь хүн шүү дээ. Нөгөө нэг ажлыг хийж сурах процессыг л технологи гэж хэлж байгаа байхгүй юу. Бид нар мөнгө байхад байшингаа ч барьчихна, тоног төхөөрөмжөө ч аваад өгчихнө. Хамгийн гол нь тэрэнд чинь дунд нь алдагдчихаад байгаа нь бид нар хүнээ яг тэр гаднын технологийг сурах процессыг нь л бид нар хийж өгөхгүй байгаад байгаа байхгүй юу. Гадаадад сургууль төгслөө гээд энд ирээд тэр өндөр зэрэглэлийн мэс засалчийн ажлыг хийж чадахгүй байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ тал дээрээ л анхаармаар байгаа юм.

Нэг бол одоо яг энэ том тэр сайд нарын 2 эд нар. Тэр сайд нарын 2-оо болиод тэнд яг тэр хамгийн сүүлийн үеийн сайн эмч нарыг нь авчир, зөвлөх эмч нарыг нь авчир, ажиллуул. Тэр дээр чинь очерлоод зогсоно, Монголчууд. Одоо ерөөсөө л бид нар ийм л юм нэн шаардлагатай байна. Би эрүүл мэндийн салбарыг буруутгаад байгаа юм биш. Энэ өвчний ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулья. Эрүүл мэндийн сайд Чинзориг.

С.Чинзориг: Яах вэ, Ганхуяг гишүүний болгоомжлолыг би ойлгож байгаа. Би ч гэсэн асар их тийм болгоомжлол байна. Үг хэл гаргах вий, эрсдэл гаргах вий гэдгийг сайн ойлгож байгаа. Гэхдээ асуудал байна, Ганхуяг гишүүн ээ. Бидэнд энэ технологи нэвтрүүлэх зардлыг шийдэж өгөхгүйгээс болж шалтгаалаад байна. Технологи нэвтрүүлэх асуудал удаашралтай байна. Нэг технологи нэвтрүүлэхэд 50 тохиолдол хийсэн бэ гэдэг юм байна лээ, одоогийн журмаараа. Тэгэхээр тэр энэ 50 тохиолдлынхоо зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллага эмнэлэг өөрөө хариуц гэхээр үүнийг чинь хийх тийм урам зориг байхгүй байна. Тийм учраас энэ зардлыг нь шийдэж өгөх. Тэгээд дараагаар нь энэ технологи нь нутагшлаа, чадавхтай болчихлоо гэж үзээд тэр салбар

зөвлөлийн дүгнэлт нь гарвал даатгалын сан руугаа яваад санхүүжилт авдаг байх. Ийм л асуудлыг би шийдье л гээд байгаа юм.

Төр өөрөө чадахгүй байна гэж тушаал гаргачаад тэгээд тэр 26 төрлийн өвчнөөрөө өвдөж, шаналж байгаа иргэдээ доромжилж байгаа юм шиг гадагшаа яваад хүрээд ирэхээр нь эмчилгээний зардлын чинь тавхан хувийг өгнө өө гээд суудаг ийм төр байх хэрэг байна уу, үгүй юү гэж би тэгж л бодож байгаа юм. Би өөрийнхөө арьсыг хамгаалах юм бол үг хэлгүй байхаа бодвол чимээгүй гөлийтөл сууж байгаад л яваад өгч болно л доо. Асуудлууд, ийм их асуудлууд байгаа учраас сайд хийж байгаа ухаантай бол ямар нэгэн гарц шийдэл олох ёстой гэж л бодож байгаа юм. Тэгээд энэ эрсдэл бас, тийм учраас тэр журмыг нь ямар нэгэн эрсдэл гарахгүйгээр, ямар нэгэн цоорхой, онгорхой нүхгүйгээр хийх юм сан гээд ингээд л үүнийгээ би бодит үнэнээ яриад сууж л байгаа юм л даа. Тийм учраас тэгээд гишүүд энэ хуулийг дэмжээд өгвөл зүгээр л байна. Асуудал байна гэвэл байна.

Өмнөх тусгай сангууд шиг болчих вий дээ гэдэг асуудлыг би өөрөө бас яриад л байгаа юм. Бас нэг ЖДҮ шиг юм болгоод хаячих вий дээ гээд би салбарынхандаа хэлээд л байгаа юм. Тийм болгохгүй байх л тэр журмыг нь маш сайн хийнэ шүү, зохицуулалтыг нь маш сайн хийнэ шүү, гадна талдаа асар их үлээлт үүсгэчихээд, тэгээд бас хэрэгжихгүй юм болгочих вий гэдэг ингээд ийм болгоомжлол асар байна, их байна. Сайд нарын 2 дугаар эмнэлэг гэсэн эмнэлэг байхгүй ээ, Ганхуяг гишүүн ээ. Тэгээд та ингээд сайд нарын 2 дугаар эмнэлэг гээд 2 дугаар, сайд нарын эмнэлэг байдаг юм шиг чуулган дээр ийм буруу ойлголт нийгэмд өгөөд байж болохгүй шүү дээ. Сайд нарын 2 дугаар эмнэлэг гэж социализмын үеийн нэр, чи залуу хүн байна мань мэтийг хууччуул гээд л их ад үздэг. Тэгээд тэр 2 дугаар эмнэлэг гэдэг яриагаа хүртэл өөрчлөх хэрэгтэй шүү дээ.

Ашигтай ажиллаж байгаа эмнэлэг гэж байхгүй ээ. Би нэг зүйлийг хэлээд байгаа юм. Гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар эмнэлгүүд санхүүжилт аваад яваад ирсэн үр дүнтэй байгаа гэж. Би бол үгүй шүү л гээд байгаа юм. 3 жил хэрэгжсэн энэ арга. Энэ 3 жил чинь ковидтой давхацсан, ковидын санхүүжилт гээд асар их хэмжээний санхүүжилт авч ирсэн. Одоо ковидын санхүүжилт байхгүй болчихсон. Яг 23 онд энэ гүйцэтгэлийн санхүүжилт болж байгаа юу, үгүй юу гэдэгтэй үнэнтэйгээ одоо яг ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу. Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Сайд нарын 2 гэж би буруу ярьсан байна, 2 дугаар эмнэлэг гээд. Тэгээд яах вэ, Засгийн газар 5Ш гээд хөтөлбөр хэрэгжүүлсэн. Та хэрвээ энэ сангийн асуудлаа явуулах гэж байгаа бол яг яаман дээрээ 5Ш хөтөлбөрөө хэрэгжүүл ээ, шүүрд. Авлигачдаа явуул. Бид нар витаминь хуулиа яриад мэдэж л байгаа шүү дээ, бүгдээрээ гишүүд бүгдээрээ мэдэж байгаа. Ард түмэн мэдэж байна.

Дахиад 2 дугаар жишээ. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай зөвшөөрлийг, эмийн сангийн зөвшөөрлийг хэн нэгэнд гуравдагч этгээдэд худалдан борлуулахыг хориглосон. Бид нар эрүүл мэндийн тогтолцоогоо хамгаалахын тулд мэргэжилтэй хүн байх ёстой гэж тэрийг нь оруулсан байхгүй юу. Хүнийг нь харж зөвшөөрлийг нь өгдөг. Тэгэхэд одоо шуурхай зар дээр тэр зөвшөөрлийг зарна гээд л байж байна, зарна гээд байж байна. Би энэ танай яамны тэр зөвшөөрөл олгодог хүмүүс чинь бүгдээрээ хутгалдсан, холбогдсон гэж бодож байна. Та тийм болохоор энэ тэр дундаж юун дээрээ шалгалтаа явуулаад 5Ш хөтөлбөр хэрэгжүүл ээ.

Л.Мөнхбаатар: Санал юм биш үү. Сая тодорхой үг л хэллээ шүү дээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Аубакир гишүүнээр тасаллаа. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуултаа асууя, үг хэлье.

Б.Энх-Амгалан: Хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Энэ гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд олгох дэмжлэгт 2017 оноос 23 оны хооронд жил бүр нэг 500 сая төгрөг батлагдаж нийтдээ нэг 520 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн юм байна. 22 онд ЭМЯ дээр 81 иргэн дэмжлэг хүссэн, түүний 18-д л олгосон юм байна. Тэгэхээр нөгөө авах ёстой 81 иргэн хүсэлт үзүүлээд байхаар 18-д нь олгоно гэдэг бол энэ азын сугалаагаар л тэр 18 авсан юм шиг л ойлгогдоно л доо. Азтай нь эмчлүүлж байна л гэсэн үг. Тэгээд энэ нэг 2 тэрбум байсан энэ зардал 10 тэрбум болж байгаа юм байна. Энэ иргэддээ чухал. Эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай 826 иргэн байгаа юм байна. Тийм учраас дотооддоо оношилж чадахгүй, эмчилж чадахгүй байгаа энэ 26 өвчинд гадагш нь явуулах нь маш чухал. Тэгээд гадагш нь явуулахдаа ганцхан Солонгос руу аваачаад 300 саяар нь, 400 саяар нь ингээд хөрөнгө оруулалт хийчихдэг байж болохгүй дээ.

Энэ эмчилгээ, оношилгоо сайтай, өндөр технологи хэрэглэдэг олон энэ эмнэлгүүд рүү гэрээ хийж явуулах нь их чухал. Сая бид нар Туркт айлчилж байхад Туркт худлаа оношилгоо эмчилгээ хийх юм бол том хариуцлагатай юм байна лээ. Тэнд бас зардлууд чирэгдэл нь ч их бага юм байна лээ. Үүнийг ЭМЯ гартаа авахгүй бол бас тэрийг зуучилдаг 1 тийм хазгай муруй хэлтэй хүмүүс байх шиг байгаа юм. Үүнийг бас 1 дүгээрт анхааралдаа авч, эхний ээлжид энэ гадагш нь эмчлүүлэхдээ онцгой анхаараарай гэдэг юм.

2 дугаарт нь, энэ оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж эх орондоо бүрэн оношлогддог, эмчлэгддэг ийм боломжийг бүрдүүлэхийн төлөө ажиллах, энэ

чиглэлийн хөрөнгө оруулалт, технологийн хөрөнгө оруулалт хийх дэвшилтэт технологи нэвтрүүлэх дээр онцгой анхаарах шаардлага хэрэгцээ байна. Энэ дээр төр онцгой анхаарах ёстой юм. Тэгээд технологи нь сайжирсны дараа эмч нараа бэлтгэх асуудал чухал байна. Тэгэхгүй сая Бейсен гишүүн ярьж байна, буруу онош тавьдаг, хагалгаа хийж чаддаггүй, эсвэл нөгөө, ингээд энэ Филиппин энэ тэрд үйлдвэрлэдэг зүгээр нөгөө тийм үйлчилдэггүй муу үйлчилгээтэй тэр эмийг эмийн жор бичээд сууж байдаг ийм эмч нараар дүүрч болохгүй учраас 1 дүгээрт технологи нутагшуулах, 2 дугаарт хүний нөөцийнхөө чадавхыг бэхжүүлэхэд онцгой анхаарах шаардлага байна.

Энэ гадаадын өндөр хөгжилтэй энэ орноос төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын багийг авчирч, өөрийн оронд эмчилгээ үйлчилгээ хийлгэж, туршлага судлах, туршлага солилцох, хамтран ажиллах ийм шаардлага хэрэгцээнүүд байгаа гэдгийг энд бас хэлэх хэрэгтэй. Ингэвэл энэ маань эмчилгээний чанар, үр нөлөө дээшлэхэд онцгой хувь нэмэр оруулна гэдгийг бас хэлье. Тэгээд хуулийн төслийг дэмжиж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Тлеуханы Аубакир үг хэлье.

Т.Аубакир: Баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Миний ойлгож байгаагаар энэ дотооддоо эмчлэх бололцоогүй болсон, гадагшаа яваад эмчлүүлэхээр тодорхой хэмжээний зардал чирэгдлийн асуудал гардаг, иргэд маань тэр бүр гадагшаа яваад эмчлүүлээд ирэх боломж байдаггүй энэ дээр л дэмжлэг үзүүлэх зорилготой ийм сан гэж ойлгож байгаа. Түүрүүн Ганхуяг гишүүн бас хэллээ. Бас л нөгөө нэг сангууд шиг болчих вий гээд Чинзориг сайд ч гэсэн өөрөө бас санаа зовоод явж байгаа. Үнэхээр яг нүдээ олсон хүмүүст үнэхээр хэрэгцээтэй байгаа хүмүүстээ өгөх юм бол, өгч чадвал энэ үнэхээр хэрэгцээтэй сан. Ялангуяа манай Баян-Өлгий аймгаас маш олон хүүхдүүд ийм гадагшаа явж

эмчлүүлэх, ахмадууд байж байдаг, зардал мөнгөний асуудал болдоггүй. Түрүүн Бейсен гишүүн бас хэллээ. Тийм учраас энэ санг дэмжиж байгаа юм. Тэгээд ганц 2 санал хэлэхэд түрүүн энэ ер нь эрүүл мэндийн салбар сонгон шалгаруулалтаар худалдаж авч байгаа эрүүл мэндийн зориулалттай, эмчилгээний зориулалттай тоног төхөөрөмжүүдийн сонгон шалгаруулалт явуулахдаа засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлтэй нь цуг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдэд нэг өгдөг болмоор байгаа юм. Одоо хөдөө орон нутгаар ч тэр, Улаанбаатар хотоор ч тэр үнэтэй авчихсан баахан аппарат төхөөрөмжүүд байгаад байдаг. Эргээд засвар үйлчилгээ манайхан өөрсдөө хийж чаддаггүй. Гурав, 400 сая төгрөгөөр авсан тоног төхөөрөмжид эргээд сэлбэг хэрэгсэл засвар үйлчилгээгээр нь үйлчилгээ үзүүлэхгүй орхиод явчихдаг. Одоо агуулахаар дүүрэн баахан ашигладаггүй үнэтэй тоног төхөөрөмжүүд байгаад байдаг.

Тийм учраас энэ жилийн Чинзориг сайд аа, эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийг худалдан авахдаа тэр сонгон шалгаруулалт энэ тэр янз бүрийн юман дээр нь засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн асуудлыг нь ер нь цуг аваад явахгүй бол ерөөсөө болохгүй байгаа. Хөдөө сумуудаар байж байгаа, янз бүрийн эхо аппаратууд байдаг, сэлбэг хэрэгсэл таарах юм байдаггүй, тухайн нийлүүлсэн компани нь нийлүүлчхээд л ингээд л шилээ харуулчихдаг. Тийм учраас үүнийг бас дараагийн юун дээр анхаарах шаардлагатай юмнууд байгаад байгаа юм.

Энэ ЭМД-д хамрагдалт дээр бас Чинзориг сайд аа, бас Эрүүл мэндийн даатгалын л газрын асуудал. Гэхдээ энэ Эрүүл мэндийн даатгалын хамрагдалт хөдөө орон нутгаар аягүй сул байна. Энэ ЭМД-д хамрагдах нь ямар ач холбогдолтой юм гэдгийг сурталчлах ажил зайлшгүй хэрэгтэй байгаа юм. Жилийн 66 мянган төгрөг байдаг. Малчин өрх нэг хонь зараад л эхнэр, нөхөр 2 хамрагдаад явчих бололцоотой. Гэтэл эргээд эрүүл мэндийнхээ даатгалаас бас л

9 сая хүртэлх төгрөгийн эмчилгээ хийлгэх боломж бүрдэж байгаа шүү дээ. Энэ эд нарыгаа аягүй сайн сурталчлаад явуулмаар байгаа юм. Энэ дээр ЭМД-д зайлшгүй шууд хамруулах ёстой 2 асуудал байгаа юм. Энэ ахмад настан өндөр настай хүмүүсийн нөхөн сэргээх, эмчилгээ асран хамгаалах энэ тэр шууд оруулчихдаг болмоор байгаа юм. 2 дугаарт, энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байж байна. ЭМД-д нь заавал үйлчилгээ үзүүлдэг энэ системийг бий болгохгүй бол бас энэ, жишээлбэл манай аймаг дээр энэ ахмадын нөхөн сэргээх эмнэлэг байсан. ЭМД-д ерөөсөө хамрагдуулдаггүй. Нэг ийм асуудал байгаа юм.

Түрүүн та хэлж байх шиг байна. Манай 2018 оноос хойш хэрэгжээд явж байгаа энэ эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцооноос ухарч болохгүй ээ, 10, 20 жил алдаж онож байж яг л нөгөө хувийн эмнэлгүүдтэй өрсөлдөхүйц хэмжээний эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг ийм л болох ёстой. Одоо ний нуугүй хэлэхэд хувийн эмнэлгүүд нь цэцэглэж хөгжөөд байдаг, улсын эмнэлгүүд маань нөгөө өглөөнөөс орой хүртэл утсаа маажгаад л ажлынхаа цагийг дуусгах. Нөгөө орж ирсэн өвчтөнд үйлчилгээ эмчилгээг нь чанартай үзүүлчих ийм л олон жил ингэж явлаа шүү дээ. Тийм учраас Чинзориг сайд аа, энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцооноос ухрах тухай бодол ерөөсөө байж болохгүй шүү. Бид нар 10, 20 жил алдаж онож байж, эмнэлгийн үйлчилгээ сайжирна.

Гадагшаа яагаад яваад үзүүлээд байгаа юм, иргэд. Яагаад гэвэл гадаадад очиход хэвтэн эмчлүүлж байгаа тэр орчин, эмчилгээ үзүүлж байгаа тэр харилцаанаас нь авхуулаад сайжирч байна шүү дээ. Тийм учраас энэ санхүүжилтийн тогтолцооноос ерөөсөө ухарч болохгүй шүү. Ийм саналууд байна. Дэмжиж байгаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа үг хэлье.

С.Одонтуяа: Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ 1 зүйл дээр би бас гайхаад байна л даа. 2022 онд гэхэд энэ санд ердөө хоёрхон тэрбум төгрөг төлөвлөсөн, байгаа байх, орсон байгаа байхгүй юу, гүйцэтгэлээр. Уг нь бид нар, үгүй ээ үгүй. Тэгэхдээ энэ чинь нөгөө архи, тамхи, эмийн орсон онцгой татвараас 1-2 хувь нь орж байгаа шүү дээ. Тэгэхээр хоёрхон тэрбум төгрөгийн сан гэдэг чинь их бага л даа. Тэгэхээр сая Бейсен гишүүн энэ сангаа нэмэгдүүл гэсэн. Тэгэхээр би тэр 1-2 хувь гэдгийг бид нар өөрчилж болохгүй юм уу гэдгийг бас авч үзье гэж байгаа юм. Яагаад гэхээр өнөөдөр Монгол Улсад энэ гол эрүүл мэндийг муутгаж байгаа шалтгаануудын нэг бол яах аргагүй архи, тамхи, эмийн буруу хэрэглээ, агаарын бохирдол энэ тэр байгаа шүү дээ. Тэгэхээр эд нараас бид нар энэ сангаа өргөтгөх ямар боломж байна вэ? Зүгээр байгаа нэг хоёрхон тэрбум дээр л зөндөө санал хэллээ. Тэгэхээр энэ дээр өргөтгөх боломжийг би судлаач ээ гэж хэлэх гэсэн юм.

2 дугаарт, энэ санг маш буруу хэрэглэлээ, барилаа, зарцууллаа гэдэг юм. Тэгэхээр өмнөх юу гэдэг юм нэг 5 жилийн ч гэдэг юм уу, 10 жилийн дүгнэлтийг гаргаад энэ сангийн зарцуулалт үнэхээр яг зөв зарцуулж уу, үгүй юу. Дараагийнхаа зарцуулалт дээр бид нар яг ямар зүйлд нь хэдэн хувийг нь өгөх юм гэдгээ нэг ийм гаргах ёстой байгаа.

3 дахь асуудал энэ Бейсен гишүүн бас их зөв санал хэрэгдээд байна л даа. Энэ ЕБС-д энэ эрүүл мэндийн чиглэлийн энэ хичээлийг оруулах чиглэлээр анхаарах хэрэгтэй гээд. Яагаад гэхээр бид нар энэ санг чинь энэ багахан мөнгөөр энэ их том сурталчилгааг хийж чадахгүй юм байгаа юм. Дээрээс нь энэ одоо зөвхөн архи, тамхи, эм биш. Энэ улс орнууд чихрийн шижинтэй яаж тэмцэж байна вэ гэхээр ерөөсөө энэ сахараа авч байгаа хүүхдүүдийн сахраа хэт их хэрэглэж байгаа зүйл дээр ингээд судалгаа хийгээд

үзэхээр 65 хувийг нь чихэрлэг ундаанаас авч байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чихэрлэг ундааны хэрэглээг яаж багасгах юм бэ гээд бид нар сүүлийн 1, 2 жил судалгаа хийлээ. Энэ судалгаагаар ерөөсөө л энэ чихрийн хэт өндөр янз бүрийн тэр дуураймал түмэн зүйлийн сахар ордог бүтээгдэхүүн дээр нь онцгой татвар тавьдаг л ганц арга байгаа. Тэрнээс биш хэчнээн сурталчлаад хүүхдүүдэд энэ нөлөөлдөггүй. Тэгэхээр энэ татвар бас хууль батлагдвал ийшээ бас нэмэгдэж болох юм.

Дээрээс нь 5 дахид нь агаарын бохирдлоос болж энэ ард иргэдийн чинь эрүүл маань маш их муудаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ агаарын бохирдлыг бууруулж байгаа энэ тэр сан өөр юу байна, эндээсээ энэ сан руугаа жоохон мөнгө оруулж болдоггүй юм уу гэдэг дээр л санал хэлэх гэсэн юм.

Тэгээд энэ гадаадад эмчлүүлж байгаа, гадаадад эмчилдэг эмчилгээнүүдийн Монголд эмчлэх асуудлыг нутагшуулах талаар ажиллана гэдэг чинь бүр маш зөв. Бид нар Монголдоо хэдэн 100 хүнийг эмчилнэ. Энэ мөнгөөр гадаадад ганцхан удаа эмчлэх нэг ийм асуудал байгаа юм. Ийм зүйл санал хэлэх гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураая. Санал хураалт.

63,3 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

12.10 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтад заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, эцсийн хувилбарын төслийг бэлтгэсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дүнд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэж танилцуулгын хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамьяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны хөгжлийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Туваан гишүүнээр тасаллаа.

Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Өнөөдөр 11 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын 24 оны төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийг дагасан хуулиуд бас эцэслэн батлагдах гэж байна. Тэгээд яг одоо төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байна л даа. Тэгэхээр энэ бол яг үнэндээ хууль зөрчсөн ийм хэлэлцүүлэг явж байгаа шүү. 24 оны төсвийг өргөн барихдаа хүчин төгөлдөр төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд төсвийг өргөн барих ёстой. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд. Өнөөдөр баталчихна гээд дагуулаад төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд өргөн барьчихсан. Хүчин төгөлдөр төсвийн хүрээний мэдэгдлээс өөр мэдэгдлийг дагуулаад зэрэгцүүлээд хэлэлцээд явж байгаа.

Улсын Их Хурал хууль зөрчиж хэлэлцэнэ гэдэг нь энэ өөрөө Үндсэн хуулийн асуудал, ҮХЦ дээр очих асуудал яг үүний цаана явж байгаа шүү, 1 дүгээрт нь.

2 дугаарт нь, өнөөдөр төсөв эцэслэн батлагдах гэж байгаа болохоор энэ дээр бас Ардчилсан намын бүлгийн зүгээс бас байр сууриа илэрхийлье.

24 оны төсөв ингээд эцэслэн батлагдах гэж байна. 24 оны төсвийг бид нар энэ ер нь хуульчлагдсан авлигыг баталгаажуулж байгаа ийм төсөв болж байна гэж үзэж байгаа юм. Яагаад? Монгол Улс авлигатай тэмцэнэ ээ гэдгийг эрх баригчид дээр, дооргүй парламент бүгдээрээ ярьж байгаа. Төрийн мөнгө, төсвийн мөнгө нь нэмэгдээд байхаар авлига буурах уу? Нөгөө иерийн өмчит компаниуд нь олон нийтийн оролцоотой болохгүй, улам хаалттай болоод байхаар авлига буурах уу? Зөвхөн энэ хуульчлагдсан авлига бүхий 24 оны төсөв дээр би гуравхан зүйлийг л хэлье.

1 дүгээрт нь, энэ 24 оны төсвийн үр дүнд үнийн өсөлт даамжирна. Бэлэн мөнгө тараах, цалин, тэтгэвэр нэмэх нэрээр, хөрөнгө оруулалт нэрээр, хөрөнгө оруулалтыг нь бараг тэрбум доллар нь

гадаадын шууд импортыг дэмжинэ. Шууд долларын, юанийн худалдан авалтыг хөхиүлэн дэмжинэ. Энэ бүгдээс л тэр баруун гараараа нэмж байгаа гэж сонгуульд зориулж байгаа тэр төсвийн нэмэгдэл чинь зүүн гараар нь үнийн өсөлтөөр булаагаад авчихна. Төр томорч байгаа учраас бизнесүүдэд орон зай гарахгүй ээ. Бизнесүүд шахагдана, 24 онд төсвийн үр дүнд. Ингээд энэ сонгуульд зориулсан ийм шууд худалдан авалтын ийм төсөв болж байна.

2 дугаарт нь, 24 оны төсвийн бас нэг онцлог уг нь энэ Монгол Улсад өрнөж байгаа нүүрсний хулгайн асуудлыг нууцад оруулах замаар хулгай хийдэг байсан бол одоо хуульчлах замаар хулгай хийх гэж байна. Энэ төсвийг дагаж орж ирсэн Биржийн тухай хууль гэж байгаа. Монгол Улс уул уурхайн бүхий л бараа бүтээгдэхүүнийг биржээр арилжъя, ил тод арилжъя, нээлттэй өрсөлдөөнд арилжъя гэсэн. Яг одоо төрийн өмчит компаниуд биржгүйгээр арилжиж болох хуулийг оруулж ирж байна, өнөөдөр. Яг төсөв дагаж орж ирж байна. Дахиад нөгөө талд нь, нөгөө талд нь тэр ТӨК-ийн захирал нь БЭТ буюу бүрэн эрхт төлөөлөгч, БНМАУ-ын хүчингүй болсон байх магадлалтай хуулиар БЭТ томилогдож байна. Ингээд энэ 2 угсрагдахаар юу болох вэ? Хууль үйлчилдэггүй шахуу бүрэн эрхт төлөөлөгч, нөгөө талд нь биржгүйгээр гэрээ хийж болох эрх. Тэгэхээр энэ өөрөө тэр нууцад оруулж хулгай хийдэг байсан өмнөх төрийн төсвийн худалдан авалтуудыг хуулийн хүрээнд 24 оны төсвийн хуулийн хүрээнд хуульчилсан хулгайг даамжруулж хуульчилж өгөх гэж байна. Хууль ёсны болгож өгөх гэж байна.

Ийм учраас Ардчилсан намын бүлгийн зүгээс өнөөдөр хэлэлцэгдэж байгаа энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр Ардчилсан намын бүлгийн зүгээс 1 хоногийн завсарлага авах шаардлагатай байна. Энэ шаардлагыг хангаж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулья. Би Дуламдоржийн

Тогтохсүрэн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Д.Тогтохсүрэн: Цогтгэрэл гишүүний юу бол асуулт гэхээсээ илүү бүлгийн байр сууриа л илэрхийлж байна л даа. Тэгэхээр яах вэ, ер нь бид нар юу шүү дээ, Цогтгэрэл дарга аа, энэ эхэлж хуулиа баталж байгаа, эхэлж хуулиа баталж байгаа. Одоо ингээд бид өнөөдөр төсөв батлахад эхэлж дагасан хуулиа батална. Тэр дагасан хуулиа баталчхаад дараа нь төсвөө баталж байгаа. Тэгээд төслийн хүрээнд энэ ер нь яах вэ, хууль зөрчинө гэвэл та тэгээд тэр холбогдох газраа хандана биз. Энэ сүүлийн 30 жил Монголд яваад л ирчихсэн жишиг практик энэ байна. Зөвхөн энэ удаагийн төсвийг өргөн барихдаа Засгийн газар ингээгүй. Бүх л Засгийн газар үеийн үед төсвөө өргөн барихдаа төсвийн хүрээний мэдэгдлээ дагуулаад л ингээд л засаад л яг төсөвтэйгөө тохируулаад л ингээд л явдаг ийм л жишиг Монголд сүүлийн үед тогтчихсон. Тийм. Үүгээрээ л Засгийн газар өргөн барьсан гэж бодож байгаа. Тогтсон жишиг хууль, эрх зүйн хүрээндээ.

Тийм ч учраас Улсын Их Хурал хуулиа батлахдаа эхэлж дагасан хуулийг нь баталдаг. Дараа нь төсвийн хүрээний мэдэгдлээ баталдаг. Тэгээд төсвөө баталдаг ийм л жишигтэй. Тэгэхээр бид батлагдсан хуулийн, Улсын Их Хурал бол хууль зөрчсөн юм байхгүй. Батлагдсан төсвийнхөө хүрээнд л, батлагдсан хуулийнхаа хүрээнд л төсвөө баталдаг нэг ийм л хүрээнд явж байгаа юм. Бусад асуудал нь бол би Ардчилсан намын бүлгийн юм уу, эсвэл Цогтгэрэл гишүүний юм уу, байр суурь байна л гэж ойлгож байна.

Л.Мөнхбаатар: Сая тодорхой хариулчихлаа шүү дээ, тийм ээ. Тэгэхээр авах шаардлага байгаа юм уу. Хэн Ганзоригийн Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга энэ дээр тайлбар хэл дээ. Та бүхэн энэ хуулиа уншчихаад заавал авах шаардлагагүй байх шүү дээ.

Ганзоригийн Тэмүүлэн.

Г.Тэмүүлэн: Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад Цогтгэрэл гишүүний асуусан асуултад бас хариулъя. Тэгэхээр яах вэ, төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг өөрөө 9 тоо байгаа. Тэгээд төсвийн хүрээнд мэдэгдэл нь бол Монгол Улсын энэ төсвийн дунд хугацааны бодлогын баримт бичиг, өөрөө. Тэгэхээр бид нар бас яах вэ, төсвийн сахилга бат болоод төсвийн засаглалыг сайжруулах үүднээс Улсын Их Хурал төсвийн шинэчлэлийн хуулиудыг сая энэ өнгөрсөн 07 сарын 07-нд баталсан. Энэ хуулийн өөрчлөлтийн дагуу цаашдаа буюу Та бид бүхний хамтарч санаачилж батлуулсан энэ хуулийн дагуу 25 оны 01 сарын 01-нээс төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах босго шалгуурыг бид нар бас хамтдаа өндөр болгосон.

Тэгэхээр 25 оны 01 сарын 01-нээс цаашид бид бүхний шинэчлэлийн энэ хуулийн төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх, хязгаарлалт тавигдах, өндөр босготой болох, заавал мөрдөгддөг баримт бичиг байх энэ зүйл бол бодлогын хувьд өөрчлөлт нь орсон гэдгийг бас танд хэлэх байна. Тэгэхээр яах вэ, өнгөрсөн энэ 10, 15 жилийн хугацаанд л явж ирсэн нийтлэг жишиг нь магадгүй таны хэлж байгаа шүүмжлэлтэй холбогдуулж, жил жилийн төсвийн хууль батлахтай зэрэгцүүлж төсөвтэй нийцүүлж, төсвийн хүрээ өөрчилдөг гэдэг жишиг байгаад байгаа юм. Тэгэхээр яах вэ, нэг талдаа энэ буруу жишиг. Үүнийг одоогийн хуулиар өөрчилж байгаа зүйл маань хуульд өөрчлөлт оруулаад хийж байгаа асуудлыг бид нар цаашид өөрчлөхгүй байх зохицуулалтыг хуулийн хүрээнд хийсэн. Энэ хууль цаашдаа үндсэн суурь зарчмаараа ингээд мөрдөгдөөд явагдах үндэс суурь, эрх зүйн үндэс бүрдсэн гэдгийг танд хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл дарга юу яах юм уу? Та тайлбар сонссон юм чинь авах шаардлага байгаа юм уу? УИХ дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл завсарлага авах санал гаргасан. Энэ хуулийн хугацаатай зүйл байгаа.

Тийм учраас 2 цагийн завсарлага өглөө, АН-ын бүлэгт. /12:21/

Дараагийнхаа асуудалд оръё.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийн нэгдсэн хуралдаанаар хийх үед төсвийн тооцоололтой холбоотойгоор шаардлагатай бол холбогдох хуульд тогтоолын төслийг боловсруулах санал дэмжигдсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн байнгын хорооноос “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

“Малчин, мал бүхий этгээдэд бэлтгэсэн, үндэсний боловсруулах үйлдвэрт тушааж, татварын цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдэж, баталгаажсан, хонины ноосны килограмм тутамд 1000 төгрөг, тэмээний ноосны килограмм тутамд 2000 төгрөг, сарлагийн хөөврийн килограмм тутамд 10000 төгрөгийн урамшуулал олгох” зохицуулалтыг нэмж тусгахаар “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс зарчмын зөрөөтэй санал гараагүй бөгөөд тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Батжаргал даргад баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Цэвэгдоржийн Туваан гишүүн, Сүхбаатарын Батболд гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ингээд нөгөө Үндсэн хуулиар мал төрийн хамгаалалтад байна гээд тэр заалт хэвээрээ л байгаа шүү дээ, тийм үү. Ингээд 8 жил явж явчхаад нэг сүүлийн нэг ганц жил нь нөгөө малчдаа харж үзэж байгаа юм шиг хайр зарлаад, тэгээд арай бага нэмээд байгаа юм биш үү, наад юм чинь, тийм. Тэгээд нэг 2-ын хооронд 1000 төгрөг энэ тэр ч гэнэ үү. Өнөөдөр мөнгөний ханш уначихсан үед энэ нөлөөлөх үү? 8 жил малчдадаа анхаарал тавиагүй, малчид төрийн бодлогоос гадуур байсан. Тэгээд 1 нэр зүүж, одоо нэг сонгууль болох гэж байгаа болохоор нэг ийм юм хийгээд байгаа юм уу, яагаад байгаа юм. Өмнө нь иймэрхүү арга хэмжээнүүд сонгуулийн өмнө л авдаг л байсан л даа. Ямаанд мөнгө өглөө гээд. Ер нь малчид дээрээ ер нь яаж анхаараад байгаа юм бэ? Одоо нэг саналыг нь авах болохоороо л нэг ингэдэг.

Монгол Улсын 24 оны төсөв ингээд ярьж байна. Үүнтэй холбогдуулаад энэ тогтоол шийдвэр янз бүрийн юмнууд гарч байна. Үүний хажуугаар бид нар ингээд дуугүй байгаад байна гэдэг чинь

бол та нарын энэ бузар булайтай эвлэрээд байна гэсэн үг биш юм байгаа шүү дээ уул нь. Төсвийг байнга алдагдалтай батална. Тэр ачааллыг ард иргэд нь үүрнэ. Үгүй ээ, сая тэр нэг тэр тэтгэвэр, тэтгэмж, цалинд 04 сарын 01-нээс 100 мянган төгрөг нэмээд байгаа юм уу? Үгүй ээ, энэ чинь яг хүн хуурдаг өдрөө л нэмэх юм, 04 сарын 01-нээс. 04 сарын 01-нээс одоо 2 сар цалинг нь 100 мянган төгрөгөөр тэтгэврээ нэмчхээд, өө, 04 сарын 01 гэх юм уу? Үгүй ээ, яагаад энэ юмнуудыг чинь 01 сарын 01-нээс, 02 сарын 01-нээс ингэж хийж болдоггүй юм бэ? Нөгөө иргэдээ басамжилсан, иргэдээ үгүйсгэсэн, эд нар дээр яаж л бол яаж доромжилж, тоглож ингэж болдог гэсэн, яагаа ч үгүй энэ янз бүрийн юм нэмнэ гээд ингээд зарлаад, дуулиан болгоод явчихдаг. Тэгээд нөгөөдөх нь 3, 4 сарын дараа. Тэр нөгөө 4 сарын 01-нээр инээдмийнхээ өдрөөр, хуурдаг өдрөөрөө. Яг тэр өдөр хүртэл юмны үнэ ханш өшөө өсөөд, өшөө үр дүнгүй л болчих нь байна шүү дээ. Ер нь энэ МАН-ынханд тэнэглэл, шунал 2 чинь үнэхээр хязгаар алга. Нөгөө хүн төрөлхтөнд 2 юм хязгаар байдаггүй юм гэсэн. Хязгаартай ч хүмүүс бий л дээ. Өөрийнхөө хэр хэмжээг мэддэг, хөнжлийнхөө хэрээр хөлөө жийдэг, адууныхаа хэмжээгээр исгэрдэг. Ерөөсөө тийм юм байхгүй шүү. Энэ өвлийн хүйтэнд автобус байхгүй. Өчнөөн мөнгө төгрөг тавиад л өгсөн, идчихсэн, луйвардчихсан. Тэгээд тэр ял шийтгэл өгч байгаа энэ олон гавьяатууд, энэ олон баатрууд, тэд нар нь дандаа нэг торгууль л авч байна шүү дээ. 40 тэрбумыг идчихээд 4 сая, 40 саяын торгууль авч байна. Үгүй ээ, ийм төр засаг, ийм шүүх гэж юу байдаг юм бэ?

Үгүй ээ, та нар чинь авлигатай тэмцэнэ гэж амаараа л яриад байх юм. Ерөөсөө амьдрал дээр байхгүй. Ард түмэн цөхөрч байна шүү дээ. 2024 оны сонгуульд МАН гэсэн урд талдаа нэртэй ямар ч хүн яваад нэмэр байхгүй шүү. Аягүй л бол та нар нэг эвсэл гээд нэрээ солиод явах юм байгаа биз. Дандаа л хүн хуурч байдаг улсууд, ард түмнийг хуураад сурчихсан. Энэ юман дээрээ цэг тавимаар

байна. Бид нар дуугүй байсан. Дуугүй байна гэдэг чинь та нар улам сайн ажиллах л ёстой шүү дээ. Бүр сайн ажиллах ёстой байтал ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн ч үг хэлэх шиг боллоо. Сонины тойм маягийн юм л ярьчихлаа даа. Хэлэлцэж байгаа а асуудалтай холбогдуулж асуусан асуулт байна уу? Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулья.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний хэлсэн байр суурьтай холбогдуулаад бас тодорхой тайлбар мэдээллүүдийг өгье. Тэгэхээр энэ орж ирж байгаа тогтоолын асуудал маань нэг талдаа энэ үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, нөгөө талдаа ажлын байр нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйнхаа салбарын бас мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс оруулж ирж байгаа юм. Тэгэхээр 2011 онд гарчихсан байсан ноос, ноолуурын тогтоолтой холбогдуулаад хуучин зөвхөн зүгээр 1000-2000 гэсэн ангилалтайгаар төгрөгөөр хонь болоод тэмээний ноосон дээр байсныг нь бид нар салгаж зааж гаргаж ирж байгаа.

Дээрээс нь юу гэдэг юм бас Улсын Их Хурлын тогтоол гарсан байсан. Сарлагийн хөөвөр дээр бид нар нэмэлт урамшууллыг өгөх гэдэг энэ асуудал байсныг нэмж оруулж ирж байгаа ийм зүйл заалтын асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр ерөөсөө яагаад бид нар энэ өөрөө байх ёстой юм бэ гэхээр өнөөгийн тогтолцоон дээр бид нар манай энэ жишээ, би зүгээр жишээ болгож хэлж байгаа нь сарлагийн хөөврийн чиглэлээр үйлдвэрт хөөвөр нийлүүлж байгаа үйлдвэрүүд маань нийтдээ 360 тонн хөөвөр бэлтгэх үйлдвэрлэлийн хүчин чадалтай байгаад байдаг. Гэтэл өнөөдрийн нийлүүлж байгаа нийт хөөврийнх нь хэмжээ нь нэг дөнгөж 20-30 орчим хувьтай байгаад байгаа юм. Тэгэхээр нийт суурилагдсан хүчин чадлаасаа 60, 70 хувийг нь ашиглаж чадахгүй байгаад байгаа учраас төрөөс зохицуулалт хийж, бодлогын дэмжлэг

үзүүлж, энэ хөөврийн нийлүүлэлтийг хийх, цаашдаа энэ үндэсний үйлдвэрлэлийг нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдээ дэмжих бодлогын хүрээнд орж ирсэн. Засгийн газар үүнийг төсвийн төсөл дээр төсөвт суулгаж оруулж ирсэн асуудал дээр харин хууль тогтоомжийн жоохон зөрчил байсан. Дагасан хуулиуд дээр өмнөх батлагдсан хууль дээр өөрчлөлт оруулах байсан асуудлыг шийдвэрлэх ёстой байсан.

Тэгээд энэ дээр Байнгын хорооны зүгээс саяын тэр 11 онд батлагдсан тогтоол дээр нэмэлт, өөрчлөлт оруулах энэ тогтоолын төслийг та бүхэнд бас оруулж ирж зохицуулалтыг хийж байгаа гэдгийг танд хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Тодруулж асууя. Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Энэ чинь нүглийн нүдийг л гурилаар хуурч байна л гэж үзэж болохоор л байна л даа. Тэгээд нөгөө энэ малчдыг маань 8 жил хаяж хаячхаад, одоо нэг ганц 2 мянган төгрөг өгөөд тэгээд нөгөө боссон үйлдвэр ч алга. Нөгөө хог дээр хамаг бүх түүхий эд чинь ингээд хэвтэж байгаа шүү дээ. Уул нь ямар байдаг байлаа. Яагаад та нар уламжлалт зах зээл болох ОХУ-тай тэр тарифыг нь буулгаж болдоггүй юм бэ? Нэг их Оросуудтай нэг л сайн сайхан байна гээд л яриад байдаггүй билүү, та нар чинь. Бараг Их Хурал нь хамтарсан комисс байгуулаад хуралдаад байна гэсэн. Үгүй ээ, нэг иймэрхүү ажлуудаа хийгээч ээ.

Нэг татвар төлөгчөөс нь мөнгө аваад нөгөөд нь ингээд 2-ын хооронд юунд ч хүрэхгүй, аманд ч үгүй, хамарт ч үгүй юм ингээд өгөх ямар хэрэгтэй юм. Өгвөл өгсөн шиг юм өг л дөө, ингэж болохгүй юу, ямар байдаг юм.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хэн хариулах уу? Сангийн яам хариулах юм уу? Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулъя.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултаас нэмж хариулъя. Тэгэхээр би саяын тэр жишээ болгоод байгаа саяын хөөврийн жишээ гээд аваад үзэхэд хөөвөр ерөөсөө Монгол Улсад цэвэр бүх бүтээгдэхүүнийхээ түүхий эдийнхээ Монгол Улсад эцсийн бүтээгдэхүүн болгож байгаа байгаад байгаа юм. 10, 20 орчим үйлдвэрүүд байгаад байна. Гэтэл нийт түүхий эдийнхээ 20-30-хан хувийг л нийлүүлж малчдаас авч чадаад байдаг, үйлдвэрийнх нь суурилагдсан хүчин чадлын 20-30-хан хувийг л ашиглаад байгаа юм. Тэгэхээр одоо бид нар яг ийм нэмүү өртөг шингээж байгаа, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдээ дэмжих бодлого үүгээрээ орж ирж байгаа юм.

Харин ноос, ноолуур тусдаа асуудал. Бид нар энэ дээр бас ер нь Засгийн газар тусгайлж үзэж, тодорхой бодлого гаргахгүй бол малчдаас нийлүүлж байгаа түүхий эдийн 80-90 хувийг нь Монгол Улсад бид нар нэмүү өртөг шингээж чадахгүйгээр түүхийгээр нь гаргаж байгаа асуудал байна. Тэгэхээр үе шаттайгаар бодлогын хүрээнд бид нар малын гаралтай түүхий эдийн үнийг нэмэгдүүлэх, эцсийн дүндээ Монгол Улсад нэмүү өртөг шингээсэн үйлдвэрүүдээ дэмжих бодлогыг хийх ёстой. Үүний илрэл нь энэ тогтоол орж ирж байгаа гэж.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ тогтоолын өөрчлөлт оруулах тухай энэ анхны хэлэлцүүлгийг нь дэмжиж байгаа юм. Тэгэхээр энэ юу вэ гэхээр манайхан бас нэг ойлгож байгаа байх. Юуг хөдөө аж ахуйн салбарын түүхий эд бүтээгдэхүүнд төрөөс төсвөөр дамжуулж олгож байгаа урамшууллын асуудал байгаа юм. Энэ урамшуулал чинь ер нь яах гэж байдаг юм. Урамшуулал бол бүтээгдэхүүний чанар, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрүүдийг түүхий эдээр баталгаатай хангах л зориулалттай. Манайд өнөөдөр хөдөө аж ахуйн салбарт урамшуулал өгч байгаа хонь, тэмээний ноос, тэгээд хүнснээс хүнсний ногоо, төмснөөс бусад хүнсний ногоо, үйлдвэр цехэд тушааж байгаа сүү, улаан буудай гээд ийм урамшууллауд байгаа. Тэгэхээр энэ ганцхан Монголд ч өгөөд байгаа зүйл биш ээ. Зарим хүмүүс энд шүүмжлэлтэй ханддаг. Энэ Америкт ч тэр, Австралид ч тэр, Англид ч тэр, ер нь хөдөө аж ахуйн салбар татаасаар л явдаг юм.

Тэгэхээр энэ дээр энэ сарлагийн хөөвөр дээр 10 мянган төгрөгийн урамшууллыг оруулж ирж байна. Ер нь энэ дээр бас нэг зүйлийг хэлэхэд энэ урамшууллаудын Төсвийн байнгын хорооноос асуумаар байна. Ямар мэдээлэлтэй байгаа юм. Энэ урамшуулал, ноосны урамшуулал нэг тийм сайн дурын маягтай. Нэг олгоё гэсэн үедээ юм уу, эс үгүй бол нэг 5 цаастай болсон үедээ олгодог, олгохгүй бол он дамнуулаад явчихдаг нэг ийм урамшуулал болсон. Арьс, ширний урамшуулал мөн адил. Тэгэхээр энэ тогтоол орж ирж байгаатай, өөрчлөлт орж байгаатай холбогдуулаад энэ журмыг нэлээн сайн хөдөө аж ахуйн яам, Засгийн газар энэ тэр ярьж байж тодорхой болгомоор байгаа юм. Яг ямар малчдад өгөх юм, яг ямар бичиг баримт бүрдүүлээд хэнд өгөх юм, хэзээ өгөх юм гэдгийг нь яг тодорхой болгохгүй бол нэг тийм тооцоолж болохгүй маягийн хүссэн үедээ өгдөг маягийн ийм урамшуулал болчихоод байгаа юм.

2 дугаарт нь, би бас нэг хуулийн төсөл санаачилсан. Тэр нь санаачлаад батлагдсан. 10 сарын 01-нээс хэрэгжиж байгаа юм. Хөдөө орон нутгаар яваад сумын нийгмийн даатгалын байцаагчаасаа асуухаар энэ талаараа мэдээлэлгүй байгаа юм. Тэгээд би энэ Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, Хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яамныханд бас энэ төсөв батлагдсаны дараа энэ рүүгээ орёе гээд байгаа юм. Юу гэхээр энэ хуулиа сурталчилж, өнөөдрийн энэ нэмэгдэж байгаа сарлагийн хөөврийн урамшуулал ч гэсэн бас л олгож байгаа урамшуулал. Тэгэхээр эндээс юу, эндээс тэр Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь суутган төлдөг. Мөнгө үлдвэл НДШ-ийг нь суутган төлдөг энэ маш чухал харилцаа байгаа шүү. Үүнийг энэ сонсож байгаа яамнууд энэ тэр байвал бас 1 дүгээрт, олгох журмаа нэлээн тийм юутай болгомоор байна, тодорхой болгомоор байна.

2 дугаарт, хуулийг сайн сурталчилж өгмөөр байгаа юм. Одоо бид нар өнөөдөр энэ зарим газраар намрын сар дуусаагүй, өвлийн сар эхлээгүй байхад цас зудын нөхцөл байдалд орчихлоо. Нөгөө муу хэлээд байдаг малчид чинь тэнд яг байгалийн гамшигт үзэгдэлтэй улаан нүүрээрээ, гар нүүр тулж байна. Тэгэхээр энэ хүмүүст үзүүлэх энэ дэмжлэг дээр шүүмжлэлтэй хандаад байдаг улсууд бас ялангуяа энэ яамнууд энэ тэр сайн бодмоор байгаа юм.

Тэр эрсдэлээс эрүүл мэндийн эрсдэлээс нь урьдчилан хамгаалдаг Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, өндөр насанд хүрээд ямар нэгэн байдлаар нийгмийн анхаарал шаардлагатай болсон үед нь эрт тэтгэврээ авах энэ үе дээр нь энэ НДШ төлөлтийн хувь энэ тэр дээр нь нэлээн анхаарч өгөх ийм шаардлага зүй ёсоор байгаа юм. Тэгэхээр асуулт нь бол энэ оруулж байгаа тэгээд үүний журмууд чинь шинэчлэгдсэн үү? Одоо хэрэгжиж байгаа хуультай холбоотой журам одоо болтол би гар дээрээ аваагүй байна, албажаагүй байна л гээд байгаа. Тэгэхээр

энэ журмаа Байнгын хороо яг яаж харж үзэж ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад хариулья. Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулья.

Г.Тэмүүлэн: Туваан гишүүний асуултад хариулья. Тэгэхээр саяын тэр нөгөө Туваан гишүүний асуусан ноос, арьс ширтэй холбоотой асуудлууд нэг талдаа бас малчдын хувьд шүүмжлэлтэй байдаг асуудал. Он дамнаад, жил дамнаад гэдэг юм уу, тухайн юу гэдэг юм заагдсан хугацаандаа олгогддоггүй. Ингээд бараг жил өнжиж байж гэдэг юм уу нэг алдаг оног өгдөг гэдэг шүүмжлэлүүдийг ярьдаг. Тэгэхээр энэ дээр бас бид нар тодорхой журмынх нь хүрээнд Засгийн газар анхаараад, тодорхой зохицуулалтуудыг цаг хугацаанд нь олгодог байх талаас нь анхаараад явах ёстой. Энэ дээр бас яамны удирдлагууд тодорхой мэдээлэл нэмж тодруулаад өгөөрэй гэж хэлэх байна.

Туваан гишүүн болоод бид нарын зүгээс бас хамтраад өргөн бариад батлуулсан. Энэ онд батлуулаад энэ оны намраас хэрэгжиж эхэлж байгаа энэ хууль бол төрөөс олгох урамшууллаас малчид нийгмийн даатгал болоод Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тооцуулах хууль батлагдсан. Ингээд энэ 10 сарын 01-нээс хэрэгжиж эхэлж байгаа. Тэгэхээр энэ зайлшгүй бас нэг шаардлагатай асуудал байгаад байгаа юм. Бид нар нэг талдаа малчин хүмүүс өөрөө өөрсдийнхөө гар дээрээсээ одоо юу гэдэг юм тодорхой санхүүжилт гаргахгүйгээр, өөр өөрсдийнхөө төрөөс авах гэж байсан, дараа жилийнх нь магадгүй түүхий эдийнхээ урамшууллаас авах гэж байсан зүйлээрээ өөр өөрсдийнхөө эрүүл мэнд болоод нийгмийн баталгааг хангах тогтолцоог бүрдүүлж өгсөн. Өнөөдөр үндсэндээ нийгмийн даатгал дээр аваад үзэхээр нийт малчдын дүн гэж нэг 20-30-хан хувь л хамрагдалтай байдаг. 70, 80 хувь нь хамрагддаггүй. ЭМД дээр аваад үзэхээр мөн бас энэ ингээд нэг 50-60 хувь нь хамрагддаггүй. Тухайн улирлын шинж

чанартай орлоготой учраас тухайн сар болгоны шимтгэлийг хураан төлөх, төлөөд яваад байх санхүүгийн боломж бололцоо бүрдэхгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ гаргаж өгсөн зохицуулалт маань нэг талдаа бас энэ улирлынх нь орлогоос нь эрүүл мэнд, нийгмийн даатгалынх нь баталгааг нь хангах эрх зүйн орчин бүрдсэн. Харин цаашдаа бид нар үндэсний үйлдвэрлэлээ давхар дэмжих бодлогын хүрээнд түүхий эдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд энэ бас урамшуулал болоод энэ түүхий эдийн бодлогыг бас илүү оновчтой болгох зайлшгүй шаардлагатай байгаа.

Байнгын хорооны хувьд бид нар төсөвт суусан байсан энэ зохицуулалтыг нь илүү тодорхой болгож, хууль зүйн талаасаа жоохон хийдэл гарсан байсан тодорхой тогтоол дээр өөрчлөлт оруулах байсныг нь орхигдуулсан байсныг нэмж оруулж, өмнө нь батлагдсан байсан тогтоол дээр өөрчлөлт оруулж орж ирсэн байгаа.

Болорчулуун дарга болоод яамныхан сая нэмээд Засгийн газрын тэр журмуудтай холбоотой асуудлууд дээр бас тодорхой нэмэлт мэдээллүүдийг өгөөрэй гэж хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу? Журамтай холбоотой асуудал дээр ажлын хэсгийн 87 дугаар микрофоныг өгье.

ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолыг үндэслээд Засгийн газрын журам баталж, энэ журмын хүрээнд ноос, арьс ширний урамшууллыг олгоод явж байгаа. 21 онд энэ сайдын багцад тавигдсан төсвийн энэ урамшуулал, татаасны зардалтай холбоотойгоор арьс ширний урамшуулал 1 жилээр хойшилж олгогдсон тал байгаа. Бусдаар ноосны урамшуулал цаг тухайдаа ингээд олгогдоод явж байгаа.

Одоо энэ тогтоол батлагдсанаар бид нар бас энэ тогтоолыг үндэслээд журамдаа өөрчлөлт оруулаад явах ийм бүрэн бололцоотой. Энэ журмынхаа дагуу олгоод явна гэж үзэж байгаа. Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам дээр таны түрүүчийн хэлсэн энэ төсвийн урамшууллаас нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалыг суутган тооцох журам батлагдсан байгаа, Засгийн газраар. Одоо ингээд бид Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, манай яам хоорондоо энэ цахим холболтуудыг хийх тал дээр ажлаа эхлүүлж байгаа. Тэгээд энэ цахим холболтуудаа хийчихвэл ингээд урамшууллынхаа суутгалыг тооцоод явах ийм бололцоотой байна болно гэж үзэж байна.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Энэ жилийн, ирэх жилийн төсөв дээр нэг Сангийн яамныхан дээр бас нэг талархах зүйл байгаа. Тэр нь юу гэхээр энэ хөдөө аж ахуйн салбарын урамшууллын хэмжээг 78 тэрбум төгрөг болгоод бас нэмэгдүүлж оруулж байсан байна. Энэ бас хөдөө аж ахуйн салбар луу бодитой дэмжлэг болоод орчихно гэж ингэж бодож байгаа. Хөдөө аж ахуйн яамныхан бас байгаа учраас нэмэлтээр хариулж болж байгаа учраас энэ эрх зүй дутаж байгаа юм одоо байна уу? Энэ урамшууллуудын чинь журам дээр. 5 урамшуулал нэг бүрээр нь тодорхой микрофонд хэлж өгнө үү?

2 дугаарт, Хууль сурталчлах зардал дээр танайх ямар төсөв байна? Ямар ажиллагаа зохион байгуулж байна? Би үүнийг чинь мэдээд зун та хэд рүү бичиг явуулсан. Манайхны нөгөө нэг арга шүү дээ, судалж байгаа, бэлдэж байгаа, асуудалгүй ээ л гээд байсан. Хууль чинь хэрэгжээд 1 сар өнгөрчхөөд байхад одоо юу яриад суугаад байгаа юм бэ. Холболтоо хийхээр төлөвлөж байна гээд. Аль хэдийн хийгээд наадах чинь ажиллачихсан байх ёстой шүү дээ. Хууль

хэрэгждэггүй байдал чинь яг энэ дээр ингээд харагдаж байгаа байхгүй юу.

Л.Мөнхбаатар: Сүхбаатарын Батболд гишүүн асуултаа асууя. Яах юм, тодруулгад хариулт өгөх юм уу? Батболд гишүүн түр байж байгаарай. Тодруулгад нэмж хариулт өгье. Ажлын хэсгийн 87 дугаар микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн салбарт олгогдож байгаа 5 төрлийн урамшуулал байгаа. Улаан буудай, хүнсний ногоо, сүүний урамшуулал бол Засгийн газрын тогтоолтой. Энэ тогтоолынхоо дагуу тус бүрдээ урамшуулалтай. Дээрээс нь яам дээр үүнийг цахим бүртгэлийн системтэй холбочихсон. Тэгээд энэ хүрээндээ үндэсний үйлдвэрт тушаасан сүү болон хүнсний ногоо, улаан буудайн урамшууллууд ингээд олгогдоод явж байгаа. Энэ дээр ямар нэгэн асуудлууд байхгүй байгаа.

Ноос, арьс ширний урамшуулал бас Их Хурлын тогтоолтой. Энэ Их Хурлын тогтоолыг үндэслээд Засгийн газраас гаргасан журмын дагуу бас олгогдоод явж байгаа. Одоохондоо энэ дээр гарч байгаа бэрхшээл гэвэл байхгүй байна гэж хэлье.

Хууль сурталчлах тал дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай бид энэ журмыг нь батлах тал дээр бас хамтарч ажилласан. Саналуудаа тусгаад явсан. Журам батлагдаад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: 1 минутад багтаагаад гүйцээж хариулъя. Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Хууль сурталчлах ажил дээр тодорхой төсөв мөнгө бас яг хараахан төлөвлөгдөөгүй байгаа. Тийм учраас бид нар өөрсдийнхөө салбарын хэмжээнд дотоод мэдээллийн сувгаараа дамжуулж байж сурталчлах тал дээр ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Сүхбаатарын Батболд гишүүн асуултаа асууя.

С.Батболд: Ингээд хонины ноос, сарлагийн хөөвөр, тэмээний ноос ингээд дэмжиж урамшуулал хийж байгааг дэмжиж байна. Хийх ёстой юм байна лээ. Хийх ёстой юмыг ажлыг ингээд хуультай ажлыг цаг хугацаанд нь хийж байх нь зөв өө. Харин сая гишүүдээс гарч байгаа энэ ажил маань яг байнга цаг хугацаандаа явж байна уу? Бэрхшээл мэдээж хэрэг эдийн засгийн хүндрэлээс болоод хойшилж байгаа зүйлүүд гарч л байгаа байх. Зүгээр энэ бодлого маань анх 2011 онд 8-12 оны Засгийн газарт гарсан Их Хурлын 11 оны 30 дугаар тогтоолын өөрчлөлт ярьж байна. Тэгээд энэ хүрээнд явагдаж байгаа зүйлүүдээс жишээлбэл сая яригдаж байгаа нь зарим арга хэмжээ эдийн засгийнхаа боломжоос хамаараад цаг цагаараа явж байна гэж. Орон нутагт явж байхад арьс, ширтэй холбоотой асуудал тэгээд магадгүй сая яамны тайлбараас харахад бэрхшээл байхгүй шийдэгдэж байгаа гэж байна. Энэ арьс ширтэй холбоотой. Гэтэл жишээлбэл Дундговь дээр ингээд яахаар малчид ерөөсөө цэвэр арьс ширтэй холбоотой асуудлыг хавтгайдаад л ярьж байна л даа. Тэгэхээр энэ арьс ширний урамшуулал маань ер нь яаж хийгдэж байгаа юм бэ, хийгдсэн байгаа юм уу гэж. Нэг ийм тодруулга бас гаргая.

2-т нь, ер нь энэ жишээлбэл сая сарлагийн хөөврийг нэг онцлог байна, бүрэн боловсруулах хүчин чадал үндэсний үйлдвэрүүдэд байна гэж. Тэгэхээр бусад түүхий эд дээр боловсруулах үйлдвэрийг байгуулах, дэмжих төрөөс энэ бодлого маань ер нь мэдээж хэрэг төр, хувийн хэвшлийн түншлэлийн юм уу хэлбэрүүд явж байгаа байх. Нэг хэлбэр нь төсөл хөтөлбөр явж байгаа. Жишээлбэл Азийн хөгжийн банкны малчдын амьжиргааг дэмжих төсөл гээд ингээд баруун 5 аймаг, зарим аймаг нэмэгдээд явж байгаа төслүүд байх шиг байгаа юм. Тэгэхээр энэ дээр яг тэр бүсччилсэн гэсэн байдлаар тухайлбал, говийн аймгууд орж, яг энэ тухайн аймгуудад тэр үйлдвэрийг нь байгуулах

тэр бодлого маань яг энэ төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд орж байна уу гэдэг ийм зүйлийг бас нэг тодруулж өгөөч. Ялангуяа Азийн хөгжлийн банкны тэр малчдын амьжиргааг дэмжих төслийн 2 дугаар үе шат, 24, 5 онуудад хэрэгжээд явна гэж байгаа юм. Тэр дотор ингээд ноос, ноолуур арьс ширтэй холбоотой үүнийг бүс нутгаар тэр дотроо говийн бүс нутагт мах, сүү, ноос ноолуур боловсруулах чиглэлээр ингэж оруулсан зүйлүүд байна уу? Үүнийг нэг тодруулж өгөхгүй юү?

Тэгээд энэ дээрээ үндэслээд жишээлбэл сая энэ сарлагийн хөөвөр шиг энэ урамшуулал, түүхий эдээ хаяж байгаа, хаях биш харин үүнийгээ үндэсний үйлдвэртээ хэрэглэх энэ урамшуулал үүнтэйгээ уялдуулж авч байгаа бол энэ зөв зүйтэй зүйл болно. Тэгэхээр эдгээр зүйлүүдийг эхлээд нэг тодруулж өгөхгүй юү?

Л.Мөнхбаатар: Батболд гишүүний асуултад хариулья. Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулья. Нэмээд ажлын хэсэг хариулж болно.

Г.Тэмүүлэн: Би сая нөгөө ноос, ноолуурын боловсруулалтын түвшинтэй холбогдуулаад Батболд даргын асуултад бас хариулья. Тэгэхээр яг үндсэндээ сарлагийн хөөвөр жишээ нь ингээд яг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100 хувь эх оронч бүтээгдэхүүн Монгол Улсад бүгдээрээ нэмүү өртөг шингээгээд эцсийн сарлагийн хөөвөртэй холбоотой бүтээгдэхүүн гарч байгаа болгон дандаа эцсийн бүтээгдэхүүн болж гарч ирж байгаа юм. Экспортын бүтээгдэхүүн.

Харин бид нар ноос, ноолуур дээр зайлшгүй анхаарах шаардлагатай болчихсон. Улсын Их Хурал сая 2022 онд ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг нэг үе шаттайгаар нэмэгдүүлэх Улсын Их Хурлын тогтоолыг гаргасан. Улсын Их Хурал дээрээс Засгийн газарт үүрэг даалгавар өгсөн. Одоо Засгийн газар үүнийг шуурхай хэрэгжүүлэх

шаардлагатай байгаад байгаа юм. Уг нь 23 оны 01 сарын 01-нээс хэрэгжих байсан боловч тодорхой журам дээр өөрчлөлт оруулаад, гаалийнхаа бүрдүүлэлт юун дээр техникийн зохицуулалтуудыг хийх ёстой байсан нь хийгдээгүй хойшилчихсон байгаад байгаа юм. Тэгэхээр үүнийг бид нар харин бас Засгийн газраас шаардаж хийх ёстой. Үүний дагуу хэрэв ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг одоогийн юу гэдэг юм, боловсруулж байгаа түвшнээс нэг шат ахиулаад хялгас ялгахаас дээш боловсруулалт хийх юм бол эцсийн дүндээ Монгол Улсад дахиад нэг юу гэдэг юм нэмүү өртөг шингээх нэг боломж бүрдэж байна гэсэн үг. Ингээд нэг шат боловсруулах шат хийснийхээ дараа бид нар дахиад 5 жилийн дараа утас ээрэх болоод тухайн юу гэдэг юм, даавуу ч гэдэг юм уу ингээд дараагийн 2 дахь шат руугаа орох хэрэгтэй болчхож байгаа юм. Ингээд тэрний дараагийнх нь эцсийн юу бол ноос, ноолуур дээр бид нар 30 оноос эцсийн бүтээгдэхүүн гараад Монгол Улс өөрөө өөрсдөө цаашид энэ түүхий эдийнхээ үнийг тогтоодог болох боломж бололцоо бүрдэнэ ээ гээд энэ суурь тогтоолыг Улсын Их Хурлаас гаргаад өгсөн байгаад байгаа. Одоо бол хэрэгжилт нь зөвхөн Засгийн газар дээр үүнийг бид нар хийж чадах юм бол, хэрэгжүүлж чадах юм бол Монгол Улс энэ ноос, ноолуурынхаа салбар дээр бүрэн 100 хувь нэмүү өртөг шингээж үндсэндээ юу гэдэг юм, түүхий эдийн үнэ тогтворгүй байдаг, ноос, ноолуур нь юу гэдэг юм, ноолуур дээр жишээ нь 100-150 мянга байх уу, ноос нь юу гэдэг юм хэдэн мянга байх уу ч гэдэг юм уу. Энэ асуудлуудыг үндэсний үйлдвэрүүд өөрсдөө тогтоож, байнгын юу гэдэг юм. Магадгүй 150-200 мянган төгрөгийн хооронд тогтвортой байх, үүнээс илүү үнэлэмжтэй болох боломж бололцоог бид нар бүрдүүлнэ ээ гэж харж байгаа.

Саяын тэр журам болоод, зохицуулалт болоод тэр гаднын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа бодлоготой холбоотой асуудлуудаар бас

яамныхан маань нэмээд тодруулга мэдээлэл өгөөрэй гэж хэлэх байна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмэх үү? Ажлын хэсгийн 87 дугаар микрофоныг өгье. Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан хариулъя.

Ц.Болорчулуун: Батболд гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр арьс ширний урамшууллауд бас яг үндэсний үйлдвэрүүдэд тушаасан арьс ширэнд урамшуулал нь өгөх ийм зохицуулалттай, журамтай. Тухайлах юм бол богийн арьсанд 3000 төгрөг, бодын арьсанд 15000 төгрөгийн урамшуулал өгдөг. Энэ бол үндэсний үйлдвэрүүдэд тушаагаад цахим бүртгэлдээ орсон тохиолдолд энд бүх малчид хамрагдаад явах ийм бололцоотой.

Дээрээс нь таны асуусан боловсруулах бусад үйлдвэрийн тухайд гэх юм бол бид нар төвийн бүсдээ Дарханы Арьс ширний үйлдвэр технологийн паркийг байгуулж, тэндээ арьс ширээ боловсруулах хүчин чадалтай үйлдвэрүүдийг бий болгоход төрийн зүгээс дэд бүтцийн дэмжлэгийг нь үзүүлж өгөхөөр ингээд бас тодорхой төсөв мөнгийг төсөвлөөд төсөл хөтөлбөрүүдээс гаргаад ингээд явж байгаа.

Баруун талдаа бол Ховдын үйлдвэр технологийн парк гэж явж байгаа. Зүүн аймагт Дорнодын үйлдвэр технологийн парк гэж төлөвлөж байгаа. Энэ жилийн тухайд бас Дорнодынх дээр харамсалтай бас төсөв хасагдсан байгаа. Төсөл хөтөлбөрүүдээс Азийн хөгжлийн банкны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нийт 57 сая долларын төсөл сая батлагдсан. Энэ хэрэгжээд явна. Энэ хүрээнд бүх аймгийн хэмжээнд энэ боловсруулах үйлдвэрийн энэ мал аж ахуйн салбарт энэ зээлүүдийг олгоод явах ийм бүрэн бололцоотой. Энд бүх аймгууд хамрагдах нь нээлттэйгээр ингэж батлагдсан төсөл одоо ингээд хэрэгжихээр Сангийн яамтай хамтраад ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Сүхбаатарын Батболд гишүүн тодруулж асууя.

С.Батболд: Тийм. Тэгэхээр жишээлбэл арьс шир, ноос ер нь үйлдвэрүүдэд тушаасан хэмжээгээр гэж байгаа юм. Тэгэхээр нөгөө арьс ширийг боловсруулах мэдээж үндэсний үйлдвэр маань хүчин чадал нь тийм өндөр биш байгаа байх л даа. Хаягдал ихтэй. Тэгэхээр тэрийг дэмжих бодлого явах нь зүйтэй. Зүгээр говийн бүс нутагт байгаа малчид маань тэгээд тэр дотроо Дундговь гээд ингээд дандаа арьс, ширээ хаяж байна шүү дээ, үндсэндээ. Тэгэхээр энд яамнаас яг энэ бүс нутагтаа ямар бодлого цаашид барих юм бэ? Энэ үндэсний үйлдвэрийг дэмжих хүрээнд бүс нутгийн хүрээнд, баруун бүс нутаг, зүүн бүс нутгийн хүрээнд ингээд юу гарч байна. Энэ говийн бүс нутаг тэр дотроо энэ яг энэ төвлөрч байгаа энэ Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, энэ хэсэгт маань уул уурхайгаас нэлээн ангид. Тэгээд гол төлөв мал аж ахуй дээр суурилсан ийм бүс нутаг байгаад байдаг. Тэгэхээр энэ маань нэг тийм аль ч салбар ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулах уу? Ажлын хэсгийн 87 дугаар микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Энэ Эмээлтэд бас Эмээлтийн үйлдвэр технологийн паркийн төслийг бас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ингээд бас ажлууд эхлээд судалгааны ажлууд хийгдээд явж байгаа. Дээр нь бас говийн бүсэд гэх юм бол Говьсүмбэр аймагт энэ хувийн хэвшлийн нэг үйлдвэр технологийн парк байгуулья гэдэг ийм гаднын бас хөрөнгө оруулалттай ийм томоохон хөрөнгө оруулалтыг бий болгоё гэдэг ийм санал ирсэн. Энэ санал дээр яам бас бодлогоор дэмжээд явж байгаа. Тэгэхээр энэ чиглэл рүү бас ингээд говийн бүсийнхээ энэ арьс, шир боловсруулах үйлдвэрүүд, түүхий эдийг бас боловсруулах талд нь энэ чиглэл рүүгээ бас яваад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ингээд хамтраад энэ чиглэлд

хамтраад ажиллах бололцоотой л гэж харж байгаа.

Л.Мөнхбаатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Батболд гишүүн, намайг сонсож бай. Малчид хөдөөгүүр явж байхад надаас малын түүхий эдийн үнийг өсгөх талаар ажиллаж өгөөч ээ гэж асуудаг. Би хариулдаг. 2009 он хүртэл малын түүхий эд, ялангуяа үхрийн шир, адууны шир 45 мянган төгрөг байсныг, хонины нэхий 12 мянган төгрөг байсан. Гэтэл өнөөдөр яагаад үнэ уначхав аа, та нар шалтгааныг нь мэдэж байгаа юу гэж би асуудаг. Тэгэнгүүт малчид мэддэггүй. Тэгэхээр нь би хариулдаг. Энэ бол төрийн буруу шийдвэрээс болсон юм гэж хариулдаг. Яагаад гэвэл 2009 онд үйлдвэрлэлийн хүчин чадал нь хангалттай биш байж байхад малын түүхий эдийг боловсруулж гаргана гэж Засгийн газрын тогтоол гарснаас болоод энэ салбар дээр ажиллаж байсан хятадууд нь 1, 2-оор гарч явсаар байгаад тэгээд энэ бизнесийг хийдэг хүнгүй болоод сүүлдээ энэ Эмээлтээр дүүрэн өмхийрсөн арьс шир гарч байсныг та нар бүгдээрээ санаж байгаа. Тэгээд ийм нөхцөл байдалд ороод энэ жил жилээс унасаар байгаад адуу, үхрийн шир 5 мянган төгрөг, хонины нэхий 500 төгрөг болсон байгаа.

Тэгээд энэ нөхцөл байдлыг өнөөдрийн Засгийн газар бас тодорхой хэмжээгээр харж үзээд энэ боловсруулах хүчин чадал хангалттай биш байна. Дарханы аж үйлдвэрийн парк болон бусад паркууд, Эмээлтийн аж үйлдвэрийн парк ашиглалтад орох хүртэл хугацаанд Засгийн газар 02 сарын 01-нээр энэ 2009 оны түүхий эдийг боловсруулж гаргах энэ тогтоолоо хүчингүй болгосон юм. Тэгээд энэ хүчингүй болгосны үр дүнд ямар зүйл гарч ирэх вэ гэх ээр жирийн нэг Ховд аймгийн Дарви сумын нэг бизнесмен нутгийнхаа тэр арьс ширийг бүгдийг нь худалдаж аваад, баруун хил Ташкан дээрээ портертой авч очоод тэндээсээ түүхий эдээ борлуулаад, гурилаа солиод ирэх ийм боломжийг бүрдүүлэх байсан

байхгүй юу даа. Гэтэл харамсалтай нь Засгийн газар энэ талаараа ерөөсөө ажил хийгээгүй. Өөрөөр хэлбэл Эдийн засгийн хөгжлийн яам энэ тогтоолын талаар олон нийтэд дээрээс нь гадаад зах зээл дээр сайн сурталчлаагүй ийм нөхцөл байдалд байгаа. Дээрээс нь Хүнс, хөдөө аж ахуйн яам ерөөсөө ажлаа хийхгүй байна. Боомтын сайд энэ хилээр тэр түүхий эдийг гаргах талаар ерөөсөө ажиллахгүй байгаа. Гадаад хэргийн сайд тэр 2 орны харилцаа ялангуяа Бүгд найрамдах Хятад ард улс руу гаргах тэр асуудлыг бодлогын хэмжээнд шийдэхгүй байна. Сангийн сайд нь тэр гааль болон бусад байгууллагууддаа түүгээрээ тэр түүхий эдийг гаргах тэр боломжийн талаар ерөөсөө хийх ажил хийхгүй байгаа байхгүй юу даа. Яг энэ асуудлыг маш хурдтай шийдвэрлээд явах юм бол одоо ингээд яг их нядалгаа эхлэх гэж байна. Хурдтай сайн ажиллах юм бол тэр ялангуяа тэр Хятадын түүхий эд дээр ажилладаг тэр хүмүүс нь орж ирээд, агуулах саваа бэлтгээд, тэр ажиллах хүчнээ бэлтгээд, дээрээс нь тэр мөнгө төгрөгөө бэлтгээд, маш хурдтайгаар энэ ажилд оролцох юм бол энэ түүхий эдийн үнэ өсөх боломжтой байхгүй юу даа. Тэгээд энэ 1 дүгээрт.

2 дугаарт нь, энэ хүмүүсийг хамгийн гол нь тэр бизнесийг эрхэлж байгаа хүмүүсийг яаж дэмжих вэ гэхээр урамшуулал өгөхийн оронд яг энэ түүхий эдийг хилээр экспортолж байгаа тэр хүмүүсийн банкнаас авсан зээлийг нь хүүг нь төлөх замаар ингээд шийдвэрлэх юм бол энэ бизнесийг хийх маш их олон хүн гарч ирнэ. Өрсөлдөөний үр дүнд энэ түүхий эдийн чинь үнэ өсөх байхгүй юу даа. Ийм ажлуудаа тэр Эдийн засгийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Боомтын сайд, Гадаад хэргийн сайд, Сангийн сайд нар ажлаа хийгээч ээ. Ерөөсөө ингээд л гүн рүү орж доогуур тэр иргэдийн тэр халаасанд хэрэгтэй тэр чухал орлогыг оруулах талаараа ерөөсөө ажил хийхгүй байна шүү дээ.

Бүгдээрээ нийтээрээ ингээд иргэд, малчид дээр очоод миний ярьдгийг яриад

явах юм бол бүгд энэ тал руугаа бүгдээрээ хөдөлнө шүү дээ. Энэ асуудал дээрээ бас санаачилгатай ажиллаарай гэж энэ сайд нарт хэлье.

Л.Мөнхбаатар: Асуулт тавьсан юм уу? Асуусан асуултдаа өөрөө хариулчих шиг боллоо шүү дээ.

Болорчулуун гишүүн,
Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Арьс шир, түүхий эдийн үнэ ганцхан Монголд унаад байгаа юм биш ээ. Дэлхий нийтийн ялангуяа хөрш Хятад улсад ч гэсэн уналттай байгаа. Энэ Өвөр Монголын арьс шир, арьсыг та нар үнийг нь мэдэж байгаа байх. Ер нь яагаад арьс ширний үнэ Монголд бас 2 дахь унах шалтгаан болсон гэвэл 2013 онд Ардчилсан нам засаглаж байхад арьс шир гадагшаа гарахыг, нэхий гадагшаа гарахыг хориглосон тогтоол гаргасан Засгийн газрын. Тэрийг энэ жил цуцаллаа. Энэ намраас эхлээд тодорхой хэмжээний тодорхой хэмжээний гэж арьс шир, нэхийний үнэ тодорхой хэмжээгээр өснө гэж бодож байна. Арьс ширийг чөлөөтэй гаргахаар болсон. Үндэсний аж үйлдвэр бүрэн хэмжээгээр сэргэж байгуулагдтал гэсэн хугацаагаар энэ хуучин хориглосон байсан тогтоолыг цуцалсан гэдгийг бас хэлье.

Ер нь тэгээд урьд нь хэлж байхгүй, ажиллаж байхгүй, тэгээд л сонгууль болохоор л шүүмжилсэн өнгө аястай юм их ярьцгаах юм.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Тодруулж асууя. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би хэлээд байна шүү дээ. Энэ буруу шийдвэрийг зөв болгосон, энэ Засгийн газар зөв болгосон гэж хэлээд байгаа. Сайн байна гэж хэлж байгаа. Тэгэхдээ хамгийн гол нь чи ингээд танай тэр Хавирга боомт байна шүү дээ. Танай Сэргэлэн сумынхан чинь арьс ширээ аваад Хавирга боомтоор очоод тэр боловсруулаагүй түүхий эдээ гаргая гэх дээр гаргахгүй байна шүү дээ. Түүн дээр

очоод тэр хил болгон дээр очоод тэр боомтыг нь нээж өгөх талаар ажилла л гэж хэлж байгаа болохоос биш өөр юм яриагүй шүү дээ. Би таны тэр Засгийн газрын тогтоолыг зөв болгосныг чинь би энэ зунжингаа 70-аад уулзалт би малчидтай хийхдээ бүгдэд нь хэлсэн. Энэ намар түүхий эдийн үнэ өсөх ёстой. Хамгийн гол нь хилийг нь нээж өг, хөөе, ажлаа хий. Түүн дээр л би хэлээд байна.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хороо “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Үг байхгүй. Дэгээрээ зөвхөн асуулттай.

Анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын саналаар санал хураая. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

13.02 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Горимын санал гаргах юм уу? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүнд горимын санал гаргая.

Д.Тогтохсүрэн: Төсөв батлагдаж байгаатай холбогдуулаад төсвийг дагуулж, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр авах арга хэмжээний талаар тогтоолын төслийг ажлын хэсгээс санаачилж, Байнгын хороо дэмжээд орж ирсэн юм. Тэгтэл бас боловсролын салбараас нэмэлт шаардлагатай тусгах асуудлууд гараад ирчихсэн учраас би гаргах гэж байгаа горимын санал бол энэ тогтоолыг Байнгын хороо дахиж анхны хэлэлцүүлэг хийе гэдэг байдал, хийх нь зүйтэй байна. Тиймээс дахиж анхны хэлэлцүүлэг хийлгэхээр Байнгын хороонд шилжүүлж өгөөч ээ гэдэг ийм горимын санал гаргаж байгаа юм. Гишүүдийг дэмжихийг хүсье.

Л.Мөнхбаатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн горимын санал гаргаж байгаа юм байна. Горимын саналаар санал хураагдана.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 41.8-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дахин хэлэлцэх шаардлагатай гэж үзэх юм бол анхны хэлэлцүүлэгт буцаагддаг дэгтэй. Тийм учраас Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

57,1 хувиар санал дэмжигдлээ.

13.04 цаг

Хуулийн төслийг Байнгын хороо анхны хэлэлцүүлэг явуулахаар шийдвэрлэлээ.

Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн үг хэлъе.

Г.Тэмүүлэн: Мөнхбаатар дарга аа, би энэ горимын санал гаргах гэсэн юм. Тэгэхээр энэ юу гэхээр сая Төсвийн байнгын хорооны зүгээс Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гээд оруулж ирж байгаа.

Тэгээд энэ юу гэхээр нийтийн өргөдөлтэй холбоотой Улсын Их Хурлаас гаргаж байгаа тогтоол байгаа. Тогтоолын төсөл байгаад байгаа юм.

Тэгэхээр Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын төслийг бас энэ Улсын Их Хурлын өнөөдрийн хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж өгөөч ээ л гэсэн саналыг горимын саналыг гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Энэ сая бол Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс шийдвэр гаргасан байна лээ. Өнөөдрийн хэлэлцэх асуудалд оролцуулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэр гарсан. Ийм учраас тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг хэн танилцуулах вэ? Даргын зөвлөлөөр шийдчихсэн учраас үүнийг заавал санал хураах шаардлагагүй байна. Тийм учраас хэлэлцээд явна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39/1 4 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.5 дахь хэсгийг үндэслээд Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журмын дагуу ирүүлсэн нийтийн

өргөдлийн үр дүнд үндэслэж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын нэмэгдсэн өртгийн албан татвар болоод татварын орчинд үнэлэлт, дүн шинжилгээ хийж, тодорхой татварын орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах чиглэлээр бас энэ тогтоолын төслийг бэлтгэж оруулж тусгасан байгаа.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн олон нийтийг талцуулсан нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудлыг сайтар судалж нягтлах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн. Ингээд Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн байгаа. Ингээд Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Баагаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуултаа асууя.

С.Чинзориг: Тэгэхээр энэ тогтоолын төсөл орж ирж байгаа юм байна. Тэгэхээр Байнгын хорооноос 1 асуулт асуумаар байна. Бид чинь бас нэг хаврын чуулганаар нь хууль баталчихсан шүү дээ. Иргэдийн саналаар бас энэ асуудал бас шийдэж байхаар гээд. Тэгээд ер нь цаашдаа бид нар энэ хууль тогтоомж, энэ Байнгын хорооноос баталсан журам эд нараа энэ боловсронгуй болгох талаар цаашдаа юу хийх юм бэ? Тэмүүлэн гишүүн ингэж юу гэж ойлгож байгаа юм. Үндсэн хуулиар чинь бол хууль санаачлах эрх Засгийн

газар, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдэд байгаа юм. Бид нар Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад бас энэ засгийн төрийн бодлого тогтвортой байх хэрэгтэй. Ялангуяа энэ татварын бодлого тогтвортой байх хэрэгтэй. Эд нар гэж ярьсаар байж байгаад тодорхой Үндсэн хуулиар хууль санаачлах эрхтэй субъектүүдийн хууль санаачлах хүрээ хязгаарыг нэлээн бас багасгасан шүү дээ. Ялангуяа Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхийг, хүрээ хязгаарыг нь нэлээн бас хязгаарласан. Үндсэн хуулиар хууль санаачлах эрхтэй субъектүүдийн хууль санаачлах эрхийг энэ хүрээ хязгаарыг ингээд нэлээн хумьчихсан. Гэсэн атлаа иргэдээсээ тодорхой сэдвийн хүрээнд санал асуулга аваад, тэгээд энэ нь 30 мянга болбол ажлын хэсэг байгуулна ч билүү, 100 мянга болбол Их Хурал авч хэлэлцэж шийдвэр гаргаж эд нар байхаар ингээд бид нар энэ асуудал хуульчилчихсан шүү дээ.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа асуух гээд байгаа зүйл бол Үндсэн хуулиараа хууль санаачлах эрхтэй субъектүүдийнхээ хууль санаачлах энэ хүрээ хязгаарлалтыг нь хязгаарлалчихсан атлаа, иргэд бүхий л асуудлаар нээлттэй санал асуулга явуулж байр сууриа илэрхийлэх, тэгээд тэр нь 100 мянгын босго давбал Их Хурал дээр асуудлыг авч хэлэлцдэг байхаар энэ хууль журмаа эргэж харж, ямар асуудлаар иргэдээс энэ санал асуулга явуулж байх вэ, ямар сэдвээр авч байх вэ гэдгээ ч гэсэн бид эргэж бас харах хэрэгтэй юм биш үү? Ялангуяа энэ татварын асуудлаар, Эрүүгийн хуультай холбоотой асуудлаар эд нар гээд. Үүнийг бас Байнгын хороо юу гэж үзэж байгаа юм бэ. Цаашдаа үүнийг нь хүрээ сэдвийнх нь хүрээг бас жаахан эргэж харах шаардлагатай юм биш үү? Ялангуяа татварын асуудлаар, Эрүүгийн хуультай холбоотой асуудлаар ингээд ингээд нээлттэй санал асуулга аваад байдаг асуудлыг нь яах юм бэ? Бид нар би түрүүн хэлээд байна шүү дээ. Тэр Үндсэн хуулиар хууль санаачлах эрхтэй субъектүүдийнхээ эрхийг бид нар бас тодорхой хэмжээгээр бас хүрээ хязгаар нь

хязгаарлалчихсан юм шүү дээ. Үүнтэйгээ бас нийцүүлж энэ иргэдийн санал асуулгаар шийддэг байх энэ сэдвийнх нь хүрээ хязгаарыг ч гэсэн бас эргэж харах шаардлагатай юм шүү дээ. Юм болгоноор ингээд татвараар иргэдийн санал асуудлаар ингээд өөрчлөх асуудлууд яриад байвал энэ Монгол төрийн бодлого чинь ер нь хаашаа явах юм бэ гэсэн ийм асуудал байгаа юм. Тэгээд энэ дээр Байнгын хороо ямар байр суурьтай байгаа юм, юу гэж үзэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулъя.

Г.Тэмүүлэн: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр иргэд санал гаргах, санал оролцох иргэдийн оролцоог бүрдүүлэх энэ асуудал бас Үндсэн хуулийн өөрөө суурь зарчмынх нь нэг асуудал байгаа. Таны хэлсэнчлэн яг Үндсэн хуулийн 26 дугаар зүйл дээр зааснаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. Тэгээд Үндсэн хуульд зааснаараа энэхүү эрхийнх нь хүрээ хязгаарыг хуулиараа тогтооно гэж зааж өгсөн байдаг. Харин иргэдтэй холбоотой асуудал дээр энэ иргэд зөвхөн оролцож санал гаргаж байгаа. Иргэд зөвхөн юу гэдэг юм хууль санаачлах процесст оролцож, өөрсдийнхөө санал бодлыг, өөрсдийнхөө өргөдлийг дэвшүүлж байгаа энэ хэлбэр байгаад байгаа юм. Тэгэхээр би нэг талдаа бид нар 2020 онд Улсын Их Хурлын тухай хууль дээр иргэдийн оролцоог хангах, иргэд оролцож саналаа дэвшүүлдэг байх энэ өөрчлөлтийг хийсэн нь бас зарчмын хувьд би том дэвшил гэж харж байгаа.

Тэгэхдээ энэ ямар нэг байдлаар иргэд өөрсдөө хууль санаачилж байна гэсэн үг биш. Иргэд харин өргөдөл гаргаж, тухайн хуулийн төслийн талаар тухайн сэдвээр саналаа хууль санаачлагчид уламжилж байгаа хэлбэр байгаад байгаа юм. Уламжилж байгаа хэлбэр. Үндсэн хууль дээр ч ингэж заасан байгаад байгаа

юм. 26 дугаар зүйлийн 2 дээр иргэд бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна гэж Үндсэн хууль дээр зааж өгсөн байгаад байна. Тэгэхээр бид нар ерөөсөө Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Улсын Их Хурлын тухай хуульд заасан иргэдийн оролцоог хангах энэ зохицуулалтын хүрээнд иргэд маань энэ өргөдөл гаргаж, саналаа ирүүлж байна. Иргэдийн гаргаж байгаа энэ саналыг, өргөдлийг судлах тэгээд тодорхой дүн шинжилгээ хийгээд, нухацтай хандаад, мэргэжлийн байгууллагууд нь хууль санаачлах эсэх шаардлагатай, өөрчлөлт оруулах эсэх шаардлагатай асуудал бол тухайн тэр хууль санаачлагчийн эрхийн асуудал. Тэгэхээр одоогийн байдлаар Улсын Их Хурал дээр 2 нийтийн өргөдөл ирсэн. 1 дүгээрх нь, 10 сарын 23-нд санал авах ажиллагааны үр дүнд нийтдээ 100 мянган хүний саналыг авч, НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгох нэмэгдүүлэх энэ саналаар нийтдээ 100 мянга гаруй иргэд өргөдөл гаргаад ирүүлсэн байгаад байгаа юм.

2 дугаарх нь, 11 сарын 07-нд мөн хууль тогтоомжийн шаардлагыг хангаад НДШ болоод Хувь хүний орлогын албан татварын шимтгэлийг НДШ, ХХОАТ-ыг бас бууруулах. Энэ сэдвээр бас 100 мянган иргэд саналаа ирүүлсэн. Тэгэхээр одоо хууль санаачлагчийн хувиар Улсын Их Хурал энэ асуудал дээр иргэдийн өргөдлийг авч судлах, энэ дээр мэргэжлийн талаас нь тооцож, тооцоо судалгаа талаас нь дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, тодорхой бодлогын шийдвэрийг гаргах бол энэ Улсын Их Хурлын нэг талдаа бүрэн эрхийн асуудал.

Ер нь иргэд энэ санал гаргаж байгаа нь нэг талдаа би энэ зарчмын хувьд тодорхой өнөөгийн энэ ковид цар тахлын дараах сөрөг нөлөөлөл бас тодорхой хэмжээнд байна гэж харж байгаа. Энэ үндсэн дээр иргэд тодорхой татварын асуудлууд дээр, тодорхой энэ өөрсдөд нь орлогод нь сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа асуудлууд дээр, төр засгийн зүгээс анхаарал хандуулж, энэ дээр дүн

шинжилгээ хийгээч ээ, үүнийг бууруулах ачааллыг бууруулалт дээр нь анхаарч үзээч ээ гэсэн энэ саналыг гаргаж байна.

Төсвийн байнгын хорооны зүгээс бид нар ажлын хэсэг гаргаад энэ асуудал дээр зөвхөн одоо юу гэдэг юм, иргэдийн гаргаж байгаа НӨАТ-тай холбоотой асуудал дээр биш, мөн дээрээс нь юу гэдэг юм Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудлууд дээр ч биш, ер нь томоор нь суурь бүх энэ татварынхаа ачааллыг салбар болгоноор нь гаргаж иргэд, болоод аж ахуйн нэгж байгууллагууд дээр учирч байгаа асуудлуудыг нь хүндрэл бэрхшээлүүдийг нь томоор нь судалж үзье ээ. Шаардлагатай бол бид нар энэ намрын чуулганы хүрээнд тодорхой татварын эрх зүйн орчинтой холбоотой бодлогын баримт бичгийг боловсруулаад та бүхэнд санал, дүгнэлтээ танилцуулъя л гэсэн үндсэн дээр оруулж ирж байгаа ийм тогтоолын төсөл байгаа.

Л.Мөнхбаатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байна. Энэ дээр нэмэгдсэн өртгийн албан татвар болон татварын орчинд дүн шинжилгээ хийх гэсэн татварын орчныг боловсронгуй болгох гэсэн ийм санаатай л ийм тогтоол орж ирж байна л даа. Тэгэхээр урьд нь 2023 оны 02 сарын 17-нд Тэмүүлэн даргаар ахлуулсан татварын орчинд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа эргэлзээтэй асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол татварын суурь шинэчлэл хийх, шийдвэрийн төсөл боловсруулах танилцуулга үүрэг бүхий ажлын хэсгийг нь байгуулаад Тэмүүлэн даргаар ахлуулаад тэгээд 4 хүн, миний бие бас орсон байна. Ингээд ийм ажлын хэсэг Их Хурлын даргын захирамж гарсан байна л даа. Тэгээд энэ шинэ тогтоол, энэ тогтоол 2 чинь үндсэндээ бараг л давхар явж байна шүү дээ, энэ чинь. Татварын орчинд дүн шинжилгээ хийх, санал

боловсруулах гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ шинэ тогтоол гарахаар хуучин нь хүчингүй болох уу? 1 дүгээрт ийм асуулт байгаа.

Дараагийн асуудал юу гэхээр 2019 онд бид нар бүгдээрээ энэ аж ахуйн юу татварын багц хуулийн шинэчлэл хийсэн. Ялангуяа гол гол татваруудаар хийсэн шинэчлэл их үр дүнтэй байгаа. Тухайлбал энд ААНОАТ, Монголын нийт татвар төлөгчдийн 93 хувь нь 1 хувийн татвар төлөгч байгаа. Тэгээд 1 хувийн татвар төлөгч болсон 93 хувь нь 1 хувийн татвар төлөгч болсон мөртөө татварын бааз суурь нэмэгдчихсэн, хэмжээ нь нэмэгдчихсэн. Энэ татварын багц хууль дээр нэг шийдэх ёстой асуудал юу вэ гэхээр мэдээж энэ яригдаад байгаа НӨАТ-ын асуудлыг бид судалж шийдэх ёстой.

2 дахь нь, ХХОАТ-тай холбоотой асуудлууд байгаа. Энэ энийгээ үзэх ёстой байх. Тэгээд энэ ажлын хэсэг ч дэд ажлын хэсгүүд нь байгуулагдсан уу? Би Тэмүүлэн даргаас асууж байгаа юм. Би бол дэд ажлын хэсэг байгуулагдаад л судалгаанууд хийгдээд л яваад байгаа л гэж бодоод байгаа шүү дээ. Тийм ээ. Тэгээд ажлын хэсэг хуралдаагүй, үзээгүй, яриагүй байгаа. Тэгээд энд хариулт өгөөч. Энэ 2 тогтоол маань тийм ээ яах вэ, тогтоол, захирамж 2 маань хэр зэрэг холбогдож цаашаа явах юм бэ гэсэн ийм асуултад хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулъя.

Г.Тэмүүлэн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр иргэдээс яг одоогийн байдлаар 2 өргөдөл ирсэн. 2 татвар болоод Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой энэ 3 асуудлыг хөндөж гаргаж ирсэн байгаад байгаа. Тэгэхээр би энэ бол нэг талдаа бид нар энэ аж ахуйн нэгж байгууллагууд болоод иргэдэд хүндрэл учруулж байгаа, санхүүгийн дарамт учруулж байгаа энэ асуудлуудыг Улсын Их Хурлын бодлогын

түвшинд анхаарч судалж үзэх ёстой гэж харж байгаа.

Ер нь бид таны хэлж байгаа сая хавар Улсын Их Хурлын даргын захирамжаар бас Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсан. Тэр бол цэвэр энэ татварын орчин дээр ер нь үнэлэлт дүгнэлт өгч, хууль, татварын багц хуулиудтай холбоотой хэрэгжилт дээр нь дүн шинжилгээ хий гэсэн чиглэлээр бас ажлын хэсэг гарсан байгаад байгаа. Ингээд бид нар тэр ажлын хэсгийн хүрээнд дэд ажлын хэсгүүд байгуулаад, дэд ажлын хэсгүүд болоод тодорхой мэргэжлийн судалгааны байгууллага, эрдэмтэн судлаач дээр судалгаа хийлгэх ажлууд сая өнгөрсөн сүүлийн хэдэн сарын хугацаанд хийгдээд ингээд явж байгаа. Тун удахгүй судалгааны дүнгүүд энэ 12 сарын эхээр бэлэн болно.

Мөн ер нь зөвхөн бид нар энэ татварын асуудал дээр Улсын Их Хурал ч яаж байгаа биш бид нар цаашид Засгийн газартай ч хамтарч энэ бодлогын судалгаануудыг хийж байж мэргэжлийн үндсэн дээр мэргэжлийн дүн шинжилгээ хийж гарах зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа. Одоогийн байдлаар таны хэлж байгаагаар яг үндсэндээ аж ахуйн нэгжүүдэд ер нь яг ямар асуудлууд хамгийн их хүндрэл бэрхшээл учруулж байна вэ гэхээр 1 дүгээрт, мэдээж энэ зээлийн хүүтэй холбоотой асуудлууд байна. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал байна. Ер нь татварын оновчтой бодлого гэдэг асуудлыг гаргаж ирж тавьж байгаа. Тэр дундаа өнөөдөр нэг талдаа нэг Худалдаа аж үйлдвэрийн танхимаас ирүүлсэн судалгаагаар нэг 67 орчим хувь нь аж ахуйн нэгж байгууллагуудынх. Татварынхаа бодлого дээр та бүхэн нэг дүн шинжилгээ хийгээд, оновчтой бодлого гаргах талаас нь анхаарч үзээч ээ гэсэн энэ саналыг хүргүүлээд байгаа юм. Тэгэхээр бид нар сүүлийн хугацаанд энэ манай Худалдаа аж үйлдвэрийн танхим болоод мэргэжлийн холбоод, ажил олгогч эздийн холбоод болоод ингээд 20, 30 гаран аж ахуйн нэгжүүд байгууллагуудаас тодорхой

саналууд ирсэн. Эдгээр байгууллагуудтай сегментэлж уулзаж тухайн салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг, тухайн тэр салбарынх нь санхүүгийн хүндрэл бэрхшээл болоод татварын ачааллыг нь бүх цогцоор нь судалъя. Ер нь Улсын Их Хурал энэ өөрийнхөө баталсан татварынхаа багц хуулиуд дээр хэрэгжилт дээр нь анхаарал хандуулж, дүн шинжилгээ хийж, мэргэжлийн талаас нь дүгнэлт гаргаад, цаашид Монгол Улс татварынхаа бодлого дээр ер нь ямар өөрчлөлтийг хийх шаардлагатай юм бэ? Шаардлагатай болбол. Эсвэл тодорхой алдаа оноо байгаа тэрийг хэрхэн залгаж зас залруулах ёстой юм бэ? Хэрхэн юу гэдэг юм, бизнес эдийн засгийн орчныг дэмжих ёстой юм бэ, аж ахуйн нэгжүүд иргэдээ хэрхэн дэмжих ёстой юм бэ гэдэг тал дээр том бодлогын шийдлийг, бодлогын баримт бичгийг гарга аа гэдэг саналтай байгаад байгаа юм.

Бид нар яг энэ үндсэн дээр сая нийтийн өргөдөлтэй холбогдуулаад Төсвийн байнгын хорооноос энэ 2 өргөдлөө холбогдуулаад энэ 2 өргөдлийг судлах, тухайн татварын орчинтой холбоотой асуудлыг судлах, ажлын хэсгийг гаргасан. Миний бие өөрөө ахлаад явж байгаа. Улсын Их Хурлын даргын захирамжаар өнгөрсөн хавар байгуулагдсан ажлын хэсэгтэй бид нар хамтраад ажиллаад явна. Энэ цэвэр нийтийн өргөдлийг судлах, нөгөө Их Хурлын даргын захирамжаар байгуулсан бол мөн энэ Татварын багц хууль болоод татварын эрх зүйн орчин тал дээр нь дүн шинжилгээ хийх ажлын хэсэг байгаа. Тэгэхээр 2 талдаа энэ 2 ажлын хэсэг санал, дүгнэлт, бүх зүйлээ нэгтгээд эргээд энэ Улсын Их Хурлын намрын чуулганы хугацаанд амжиж Улсын Их Хуралд буцаж санал, дүгнэлт болоод бодлогынхоо шийдлүүдийг та бүхэнд танилцуулах болно гэдгээ хэлэх байгаад байгаа юм.

Тэгээд ер нь цаашдаа бид нар эргээд ер нь энэ татварын бодлого юм бол, энэ татварын системийн тогтолцоо юм бол энэ мэдээж бодлоготой байх ёстой.

Энэ тал дээр бид нар эргээд нэг иргэд, эдийн засгаа дэмжсэн, эргээд одоо юу гэдэг юм, тухайн аж ахуйн нэгж болгонд хүртээмжтэй, ээлтэй тийм бодлогыг гаргах талаас нь, татварынхаа орчныг илүү боловсронгуй болгох талаас нь анхаарч бас төвлөрч ажиллана.

Тэгээд 2 ажлын хэсэг хамтдаа энэ дээр тодорхой бодлогын шийдлүүдээ хамтарч хийгээд явна гэж би бас харж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Санал хураалт явна. Их Хурлын гишүүд байраа эзлээрэй. Гишүүд сууж сууцгаа. Санал хураалт явагдана шүү.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

13.25 цаг

13 цаг болсон байна. Одоо өдрийн завсарлага.

Тэгээд 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаантай.

ЗАВСАРЛАГА.

Л.Мөнхбаатар: Үдээс хойших хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Дараалалд заасан ёсоор хойшлуулах асуулгын хариу ирсэн. Үүнийг хойшлуулах асуудлыг танилцуулъя. Адьшаа гишүүнээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвэгийн Амарбаясгаланд хандан асуулга тавьсан байсан. Үүнтэй холбогдуулаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвэгийн Амарбаясгалангаас 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр асуулгын тухай Хэрэг эрхлэх газрын 24 83 тоот албан бичгийг

ирүүлсэн байна. Түүнийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Асуулгын тухай. Албан ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Ховд аймгийн Мянгад сумын нутаг дэвсгэрт байрлах Халзан Бүргэдэйн ордтой холбоотой асуудлаар тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн асуулгын хариуг сонсох товыг хойшлуулж өгнө үү. Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан гэсэн байна.

Ингээд асуулгын хариуг хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Төсвийн хүрээний мэдэгдэл үргэлжлээд явагдана.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл 2 цагийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна.

Хэлэлцүүлгийг үргэлжлүүлье. Та үг авах уу, авахгүй юу? Цогтгэрэл дарга үг хэлье. Завсарлагатай холбогдуулж үг хэлнэ.

О.Цогтгэрэл: 2024 оны төсөв Монгол Улсын түүхэн дэх ингээд түүхэн хамгийн том төсөв батлагдах гэж байна л даа. Төсвийн гоё, гоё нэртэй хөрөнгө оруулалтууд дараа жилийн валютын ханшийг өдөөдөг. Тэр нь түүний дараа жилийнхээ урсгал зардал болдог. Цалин, тэтгэвэр, тэтгэмжүүд нь бас энэ зардлуудаа нэмдэг. Эдгээр нь бүгд нийлэхээрээ үнийн өсөлтийг авчирдаг гэдгийг бид нар бас бүгдээрээ гадарлахтайгаа болсон. Тэр тусмаа эх

үүсвэрээ өндрөөр тавьчихсан, орлогоо өндрөөр тавьчихсан, дэлхийн зах зээлийнхээ урсгал чиглэлийнхээ эсрэг шахуу явж байгаа ийм эх үүсвэр султай үед. Тэгэхээр энэ бүгд ингээд нийлэхээрээ ер нь бас нэг үлгэр домогт ч гардаг. Нэг мангас гээд нэг амьтан байдаг. Өөртөө хэчнээн их эрх мэдэл цуглуулахаараа түүндээ ханаж цаддаггүй. Хэчнээн их эд баялаг цугласан ч түүндээ ханаж цаддаггүй амьтныг бас бид нар дүрсэлдэг. Яг төр өөрөө тийм шинжтэй байх. Өнөөгийн Монголын төр, өнөөгийн Монголын төсөв яг ийм л шинжтэй болчихлоо. Улам томордог, улам ихийг цуглуулдаг, дараа жил улам их эрх мэдлийг л нэхдэг. Ийм л болчихлоо. Тэгээд энэ бүгд дээр бид нар бас удаа дараа л байр сууриудаа бас илэрхийлээд л явж байна.

Ер нь энэ мөнгөтэй холбоотой шийдвэр гаргахад нэг тийм 4 өөр төрөл байдаг юм гэнэ лээ. Өөрийнхөө мөнгийг өөрөө зарцуулдаг, өөрийнхөө мөнгийг хүний төлөө зарцуулдаг, хүний мөнгийг өөрийн төлөө зарцуулдаг, хамгийн муу нь хүний мөнгийг хүний төлөө зарцуулах шийдвэр гаргаж байгаа этгээд хамгийн үр ашиггүй шийдвэр гаргадаг гэж л үздэг. Тэр нь үндсэндээ төсвийн шийдвэр гаргаж байгаа улс төрчид, төрийнхөн. Татвар төлөгчдийн мөнгийг нийгмийн төлөө зарцуулж байна гэдэг энэ шийдвэрийг гаргадаг. Тэгэхээр энд энэ тохиолдолд үр ашиг, үр нөлөө олон зүйлийг харгалзахгүйгээр бид нар яг өнөөгийн энэ Монгол Улсын төсөв шиг л ийм үрэн таран болгож байгаа ийм л шийдвэрүүд гаргадаг.

Ийм учраас л төрөө жижиг байлгамаар байна. Тэр өөрийнхөө төлөө шийдвэр гаргадаг хүмүүст илүү боломжийг нь олгомоор байна гэдэг л байр суурийг бас ингээд удаа дараа илэрхийлдэг.

Тэгээд эцэст нь том төсөв ажлын байр бий болгодоггүй ээ гэдгийг бид нар бас мэднэ. Том төсвөөр халамж буурдаггүй юм байна гэдгийг мэднэ.

Харин том төсвийг дагаад авлига, хулгай нь гаардаг юм байна гэдгийг бид бүгд бас гадарлахтайгаа болсон. Тэгээд өнөөдөр ингээд Монгол Улсын 24 оны төсөв эцэслэн батлагдана. Тэгээд 24 оны Монгол Улсын төсөвт амжилт хүсье.

Л.Мөнхбаатар: Завсарлагын хугацаа дууссан тул хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл 25, 26 оны төсвийн төсөөллийн асуудал ингээд хэлэлцэгдэхээр орж ирж байна. Энэ дээр нэг 2 зүйлийг тодруулж асууя.

Эхнийх нь бол энэ бид нар энэ жил би бас хэлээд байсан. Энэ Монгол Улс ирээдүй хүүхэд, багачуудаасаа бид нар төсөв харамласан. Энэ юу вэ гэхээр энэ хүүхдийн ялангуяа энэ одоо цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхдийн мөнгө 2475 төгрөг. Үүнийг бид нар яагаад энэ жил нэмсэнгүй вэ? Би бас хэлээд байгаа юм. 2475 төгрөгөөр нэг хуушуур аваад дээр нь нэг аяга сүүтэй цай авахад 25 төгрөг дутах ийм мөнгө. Нэг хүүхэд яаж өдөржин үүгээр хоол идэх вэ?

Дээрээс нь үдийн хоолны мөнгө. Үдийн хоол гэж байгаа шүү. Цай биш. 1500 төгрөг. Одоо өнөөдөр гадаа хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнэ ямар болчихсон байгаа. Бүх сургуулиуд, цэцэрлэгүүдийн одоо тогооч нараас асуухаар 9-ийн тосыг бүгдээрээ бид нар 5500-аар авч байх үед ийм мөнгө байсан, одоо 11 мянга болсон гээд бүгд хэлж байгаа юм. Тэгээд нөгөө мөнгө нь нэмэгдэхгүй яваад байгаа юм.

Бүх дотуур байранд амьдарч байгаа, түүн дотор 12 дугаар ангийн хүүхдүүд орж байгаа. Өдрийн 4000 төгрөгийн хоолны төсөвтэй. Үүгээр нас биед бараг хүрсэн тэр залуучууд яаж цадаж хооллох вэ. Тэгэхээр стандартын шаардлага хангаагүй, бага хэмжээтэй, амь аргацаасан, нэг өл дарах төдий одоо

зүйлүүд байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр одоо энэ жилийн төсөв дээр харамсалтай нь орсонгүй. Ирэх жилийн төсвийн төсөөлөл, төсөв дээрээ үүнийгээ заавал тусгаж оруулж ирээрэй, ирэх үү гэдэг асуулт асууж байгаа юм.

2 дугаарт нь, өчигдөр Төв аймгийн Эрдэнэсант, Лүн сум дээр газар дээр нь очиж ажиллаад ирлээ. Нөхцөл байдал маш хүнд байна. Байгалийн гамшгийн өмнө бид нар байтугай одоо хүчирхэг гүрэн, юу ч байсан дийлэхгүй. Тэгэхдээ энэ байгалийн гамшгийн ар дээр бид нар тэр гарсан хор хохирлыг арилгах тал дээр бол ажилламаар байгаа юм. Тэгээд л нэг дайнаа ирэхээр дариа нухлаа гэдэг шиг цас, зуд болоод үер, гамшиг болсны дараа л бүгдээрээ л Онцгой байдал руугаа тэгээч, ингээч гэж байдаг. Одоо энэ онцгой байдлынхнаас бол төсвийг харамламааргүй байна. Бид нар 90 оны Монгол Улс биш, өнөөдөр 2024 оны төсөв 27 их наядаар батлах гэж байгаа Монгол улс. Урдаа тэр түрээд явдаг тэр кино дээр гардаг тийм хүчин чадал сайтай техникийг бас шийдчихмээр байна. Тэгэхгүй бол нэг жил 131-ний араас нэг талпуу гээд нэг төмөр чирээд нэг зам гаргахаас өөр бид нар арга алга. Тэгэхээр энэ дээр ирэх жилийн энэ төсвийн төсөөлөл энэ тэр дээр манай Сангийн яамныхан ямар бодлоготой орох гэж байна.

Тэгээд л бензин, шатахууны асуудал үнэхээр алга байна. Тэгээд тэр юунууд техникийн асуудал. Дээрээс нь одоо энэ орсон цасны араас дахиад нэг удаа жоохон цас нэмэхэд л шууд зуд. Тэгээд л нөгөө нэг отор нүүдэл, өвс тоос гээд энэ асуудлууд ингээд гараад ирнэ. Тэгэхээр онцгой байдлынхаа асуудал дээр энэ зүйлээ тодорхой бас ирэх жилийн энэ төсвийн төсөөллүүдээ оруулаад, төсвийн хүрээнийхээ мэдэгдэлд оруулаад ингээд шийдээд явмаар байна шүү гэдгийг хэлье.

Дараагийн нэг асуудал энэ одоо хүний амь нас эрсэдсэн маш харамсалтай үйл явдал болсон. Эрдэнэсант сум, Лүн сумаас бусад өшөө, Өндөрширээт, Бүрэн

гээд сумууд байна, адилхан цас орчихсон. Тэгээд тэнд үнэхээр удирдлагууд, Засаг даргууд нь ярьж байна. Бид нар дээр бас адилхан ордог цас орсон, цаг хүнд байна, золоор хүний амь нас эргэж эрсдээгүй байгаа учраас энэ дээр нэлээн хүндрэлтэй байна шүү, бид нар луу бас анхаарал хандуулж өгөөч ээ гэдэг ийм зүйлийг ярьсан. Би өглөө Шадар сайдтай бас уулзаж энэ асуудлыг биеэр танилцуулж хэлсэн. Одоо хуралдаад бас шийдвэр гаргана гэсэн. Тэгэхээр ер нь ... /минут дуусаа/

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Баянхонгор аймгийн Богд сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Асуултад хэн хариулах вэ? Үгүй ээ, үгүй биш тэр хэлэлцэх асуудалтай холбоотой. Хариултыг Туваан гишүүнд бас холбогдох ажлын хэсэгт наад асуудлаа судлаад эргээд хариулт өгье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

15.24 цаг

Даргын зөвлөлөөс шийдсэний дагуу үдээс хойших хуралдаанаар хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Гишүүд байраа эзлээрэй.

Мөн үдээс хойших хуралдаанаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл 4 дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Мөн нийтдээ дагасан хуулийн төсөл 28 төсөл байгаа. Эдгээрийг шийднэ.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2024 оны төсвийн тухай болон Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон тогтоолуудыг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д 7 хоногийн Баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэн, гишүүдэд тарааж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна. Одоо төслийг эцэслэн батлах санал хураалтуудыг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-г нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн

бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Санал хураалт явуулах уу.

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

81,8 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

15.28 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 4 дэх хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсэг өмнөх ажлын хэсэг хэвээрээ байж байгаа.

Байнгын хороо төсвийн төслүүдийг 4 дэх хэлэлцүүлэгт бэлтгэн гишүүдэд тараасан байгаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж тус бүрээр нь одоо санал хураалт явуулна.

Хуулийн төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл. Монгол Улсын 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Монгол Улсын 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хоёрдугаар бүлэг Монгол Улсын 2024 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага

3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Их Хурлын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0 100.0
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0 510.0
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,737.7 2,737.7
5	Монгол Улсын Ерөнхий сайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар үүнээс: Ирээдүйн өв санд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	648,431.7 644,002.5 520,083.2 4,429.2
6	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	15,941.5 15,941.5
7	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	132.6 132.6
8	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175.0 175.0
9	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,485.5 1,485.5
10	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд	6,000.0 6,000.0
11	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд үүнээс: Ирээдүйн өв санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	18,181,474.2 10,675,146.9 513,710.9 833,224.2 6,727,915.6 211,194.0 558,000.0 9,217.6
12	Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	83,749.0 45,000.0 2,700.0 1,552.9 34,496.1
13	Батлан хамгаалахын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	38,185.4 38,185.4
14	Боловсрол, шинжлэх ухааны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,857.9 5,857.9

15	Зам, тээврийн хөгжлийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн хөгжлийн яам Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175,300.0 150,000.0 300.0 25,000.0
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Үндэсний геологийн алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	426,173.4 421,903.3 110.0 4,160.2
17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54,588.5 54,588.5
18	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	38,454.4 850.0 2,535.1 35,069.3
19	Эрүүл мэндийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,555.4 5,555.4
20	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,665.5 8,665.5

Түрүүн 6 дээр Монгол Улсын Шадар сайд дээр багцыг 15,941.5 сая гэдгийг бас давтаад хэлчихье. Саналын томьёоллыг уншиж танилцууллаа. Санал хураалт.

69,8 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалтыг явуулъя.

4 дүгээр зүйл. Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 18,359,777.4 сая төгрөг байна. Санал хураалт.

79,2 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд Үүнээс: УБТЗ ХНН-ийн “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дүрмийн санд	437,311.2 83,673.5
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,600.7
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	30,000.0
4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	22,758.8
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	10,286.9

Санал хураалт.

77,4 хувиар санал дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

6.1. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал	29,711.3 29,711.3
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	132,712.7 110,623.1 22,089.6
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал	4,253.4 4,253.4
4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал Хөрөнгийн зардал	29,070.1 17,541.3 11,528.8
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	165,500.3 145,675.3 19,825.0
6	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Урсгал зардал	5,117.2 5,117.2
7	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал	110,621.1 99,272.8 11,348.3
8	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	18,849.9 18,849.9
9	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал Хөрөнгийн зардал	41,435.6 40,554.5 881.1
10	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	48,006.0 45,347.9 2,658.2
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	14,727.6 13,835.1 892.5
12	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	6,108.1 6,108.1
13	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал	21,217.7 21,217.7
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	63,976.8 63,976.8
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Урсгал зардал	8,314.6 8,314.6

16	Монгол Улсын Ерөнхий сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	340,128.1 300,519.0 39,609.0
17	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	291,364.5 246,797.1 44,567.4
18	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	87,294.6 18,294.6 69,000.0
19	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	117,216.7 65,825.3 51,391.4
20	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	256,548.7 219,611.4 36,937.3
21	Гадаад харилцааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	191,067.2 177,367.2 13,700.0
22	Сангийн сайд Урсгал зардал үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	4,506,557.2 2,498,781.0 1,173,620.2 224,776.2 1,783,000.0
23	Хууль зүй, дотоод хэргийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,394,322.8 1,267,135.0 127,187.7
24	Зам, тээврийн хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	692,173.9 23,694.3 668,479.6
25	Батлан хамгаалахын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	562,839.1 542,823.8 20,015.3
26	Боловсрол, шинжлэх ухааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	4,227,177.2 3,482,306.4 744,870.7
27	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	59,929.9 19,929.9 40,000.0
28	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	549,076.2 425,487.9 123,588.3
29	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	3,945,272.0 3,896,513.9 48,758.1
30	Эрүүл мэндийн сайд	1,634,404.0

	Урсгал зардал	1,353,325.0
	Хөрөнгийн зардал	281,079.0
31	Эрчим хүчний сайд	335,356.1
	Урсгал зардал	111,070.1
	Хөрөнгийн зардал	224,286.0
32	Барилга, хот байгуулалтын сайд	415,704.8
	Урсгал зардал	10,411.8
	Хөрөнгийн зардал	405,293.0
33	Соёлын сайд	397,751.1
	Урсгал зардал	242,870.1
	Хөрөнгийн зардал	154,881.0
34	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	86,295.6
	Урсгал зардал	69,872.6
	Хөрөнгийн зардал	16,423.0
35	Шүүхийн сахилгын хорооны дарга	4,183.2
	Урсгал зардал	4,183.2
36	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга	144,591.8
	Урсгал зардал	72,238.4
	Хөрөнгийн зардал	72,353.4
37	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	11,176.3
	Урсгал зардал	5,713.2
	Хөрөнгийн зардал	5,463.1
38	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга	56,229.2
	Хөрөнгийн зардал	56,229.2

6.2. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	182,210.5
	Үүнээс: Хөдөөгийн сэргэлт- Амьдралын чанар	98,537.0
2	Барилга, хот байгуулалтын сайд	5,000.0
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	31,036.3
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	50,285.5

6 дугаар зүйл дээр 22 дугаар зүйл дээр давтаж уншъя.

Урсгал зардал үүнээс зээлийн хүүгийн төлбөрт 1,173,620.2 сая. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт, гишүүд ээ.

66 хувиар санал дэмжигдлээ.

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 20,753,857.3 сая төгрөг байна. Санал хураалт.

69,8 хувиар санал дэмжигдлээ.

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 3,359,350.2 сая төгрөгөөр санхүүжүүлнэ. Санал хураалт.

73,6 хувиар санал дэмжигдлээ.

9 дүгээр зүйл. “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд 25,000.0 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ. Санал хураалт.

75,5 хувиар санал дэмжигдлээ.

10 дугаар зүйл. 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 1,231,447.7 сая төгрөг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2024 оны төсвийн жилд 513,710.9 сая төгрөг хуримтлуулна. Санал хураалт.

79,2 хувиар санал дэмжигдлээ.

11 дүгээр зүйл. 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,788,332.7 сая төгрөг байна. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2024 оны төсвийн жилд 1,353,307.4 сая төгрөг хуримтлуулна. Санал хураалт.

79,2 хувиар санал дэмжигдлээ.

12 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

12.1. Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.6 болон 28¹.1-д заасан зориулалтаар хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээг 3,414,050.7 сая төгрөг хүртэл;

12.2. Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1,225,000.0 сая төгрөг хүртэл. Санал хураалт.

79,2 хувиар санал дэмжигдлээ.

13 дугаар зүйл. Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2024 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 3,286,546.7 сая төгрөг байна. Санал хураалт.

75,5 хувиар санал дэмжигдлээ.

14 дүгээр зүйл. Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2024 оны төсвийн жилд 3,550,000.0 сая төгрөг байна. Санал хураалт.

73,6 хувиар санал дэмжигдлээ.

15 дугаар зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2 болон 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ. Санал хураалт.

79,2 хувиар санал дэмжигдлээ.

Гуравдугаар бүлэг

Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг

16 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	36,320.0
2	Баян-Өлгий	25,670.8
3	Баянхонгор	38,421.5
4	Булган	11,070.4
5	Говь-Алтай	33,672.2
6	Дундговь	27,041.0
7	Завхан	37,893.3
8	Өвөрхангай	33,070.5
9	Сүхбаатар	11,815.3
10	Төв	19,741.7
11	Увс	34,144.2
12	Ховд	15,014.7
13	Хөвсгөл	43,617.0
14	Хэнтий	39,282.5
15	Говьсүмбэр	6,788.5
Нийт дун		413,563.4

Санал хураалт.

67,9 хувиар санал дэмжигдлээ.

17 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	9,331.2
2	Дорнод	2,976.5
3	Өмнөговь	719,881.4
4	Сэлэнгэ	1,363.3
5	Дархан-Уул	658.2
6	Улаанбаатар	230,261.5

7	Орхон	179,620.9
Нийт дүн		1,144,093.1

Санал хураалт.

69,8 хувиар санал дэмжигдлээ.

18 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	12,118.9
2	Баян-Өлгий	11,406.6
3	Баянхонгор	20,660.6
4	Булган	13,601.6
5	Говь-Алтай	16,592.9
6	Дорноговь	41,298.3
7	Дорнод	24,783.3
8	Дундговь	15,244.6
9	Завхан	14,040.3
10	Өвөрхангай	13,854.9
11	Өмнөговь	45,585.0
12	Сүхбаатар	17,474.9
13	Сэлэнгэ	26,529.0
14	Төв	27,155.9
15	Увс	12,477.3
16	Ховд	28,053.0
17	Хөвсгөл	15,990.5
18	Хэнтий	17,789.1
19	Дархан-Уул	19,834.2
20	Улаанбаатар	47,781.3
21	Орхон	33,099.6
22	Говьсүмбэр	6,704.8
Нийт дүн		482,076.7

Санал хураалт.

77,4 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөвдүгээр бүлэг

19 дүгээр зүйл. “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай. Санал хураалт.

73,6 хувиар санал дэмжигдлээ.

20 дугаар зүйл. “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай. Санал хураалт.

73,6 хувиар санал дэмжигдлээ.

20 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталсугай. Санал хураалт.

71,7 хувиар санал дэмжигдлээ.

21 дүгээр зүйл. “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай. Санал хураалт.

73,6 хувиар санал дэмжигдлээ.

22 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

Одоо Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Одоо Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг санал хураан авалт явуулна.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

4 дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

67,9 хувиар санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт.

58,5 хувиар санал дэмжигдлээ.

Хоёрдугаар бүлэг

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн орлого, зарлага

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	5,893,277.1
	1.1 Ажил олгогчийн төлөх шимтгэл	2,563,916.6
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	1,833,539.5
	1.3 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	21,034.5
	1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	237.9
	1.5 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	258,491.7
	1.6 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	4,954.0
	1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,809.1
	1.8 Бусад орлого	33,319.8
	1.9 Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	1,174,974.0
	Нийт орлого	5,893,277.1

Санал хураалт.

78,8 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	67,232.2

Санал хураалт.

73,1 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
-----	----------------	------------------------

1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	5,188,403.3
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	4,741,061.0
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	262,434.5
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	61,900.1
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	123,007.7
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	0.0
	1.6 Даатгуулагчид буцаан олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	0.0
Нийт зарлага		5,188,403.3

Санал хураалт.

76,9 хувиар санал дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай. Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт. Санал хураалт, гишүүд ээ.

82,7 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Эцэслэн батлах санал хураалт шүү. Гишүүд ээ, анхааралтай байгаарай.

78,8 хувь буюу 41 гишүүн санал өгч, дэмжигдсэн байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай
Нэгдүгээр бүлэг
Нийтлэг үндэслэл**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Санал хураалт.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн дэмжиж санал өгсөн байна.

75,4 хувиар санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай

хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт.

79,2 хувиар санал дэмжигдлээ.

Хоёрдугаар бүлэг

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн орлого, зарлага

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,964,757.3
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	859,154.8
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	324,113.0
	1.3 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	746,804.8
	1.4 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	34,684.8
	Нийт орлого	1,964,757.3

Санал хураалт.

75,5 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	-85,000.0

Санал хураалт.

76,9 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл. 2024 он төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,933,171.6
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	887,716.8
	1.2 Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	837,652.6
		137,322.8
	1.3 Эмийн санд олгох	
	1.4 Үйл ажиллагааны урсгал зардал	16,916.7
	1.5 Эрсдэлийн сан	53,562.6
	Нийт зарлага	1,933,171.6

1.2-ыг би бас дахиад уншъя. 1.2. Төрөөс хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт 837,652.6 сая. Санал хураалт.

80,8 хувиар санал дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

78,8 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг явуулъя. Санал хураалт, гишүүд ээ. Эцэслэн батлах санал хураалт шүү.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслүүд батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

16.29 цаг

Дараагийнхаа асуудалд орёе.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Санал хураалтууд явуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан:

1. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

79,2 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

44 гишүүн буюу 83 хувь нь дэмжсэн байна.

2. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд суудалдаа суугаарай.

42 гишүүн дэмжиж, санал дэмжигдэж, хууль эцэслэн батлагдлаа.

3. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

71,7 хувь дэмжсэн байна. Хэн санал гаргах юм?

Хэн? Даваасүрэн гишүүн горимын санал хэлье.

Ц.Даваасүрэн: Би дэмжиж байсан юм. Тэгээд энэ нөгөө бас техникийн саатал гарчих шиг боллоо. Дахиад хурааж өгнө үү?

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнгийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя.

79,2 хувиар санал дэмжигдэж, хүчингүйд тооцлоо. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Үндсэн санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

7. Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Тийм, бүгд одоо эцэслэн баталж байгаа учраас 39-өөс дээш гишүүн дэмжиж байж батлагдана.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

9. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт гишүүд ээ.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хурааа. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хэн гаргах юм. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн горимын санал гаргая.

Ш.Адьшаа: Би үүнийг дэмжсэн санал өгсөн юм. Тэгээд энэ төхөөрөмж гацчихлаа. Дахиж санал хураалт явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

83 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүйд тооцлоо. Үндсэн санал хураалтын саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

13. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

14. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

15. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

16. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

17. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

18. Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт, гишүүд ээ. Сангийн сайд суудалдаа суугаарай.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

20. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

21. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

22. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Тогтоол эцэслэн батлагдлаа.

16.48 цаг

23. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, тогтоол эцэслэн батлагдлаа.

24. “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, тогтоол эцэслэн батлагдлаа.

25. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, тогтоол эцэслэн батлагдлаа.

26. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, тогтоол эцэслэн батлагдлаа.

27. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, тогтоол эцэслэн батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Одоо Төсвийн байнгын хороо хуралдаж, 2 тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлгийг хийгээд оруулж ирнэ. 10 минут завсарлаж байна.

ЗАВСАРЛАГА.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулъя. Гишүүд байраа эзлээрэй.

2 тогтоолын төслийг батална. Гишүүд байраа эзлээрэй.

Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг Танд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Оюунчимэг гишүүн Шажингийн Мөнхөө, Жадамбын Цээпил нарын 6 дахь хүүхэд болон мэндэлсэн байна. Ингээд Мөнхөөгийн Оюунчимэг гишүүндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гишүүд байраа эзлээрэй.

“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.4} дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.5 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар боловсруулсан “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах үед Төсвийн байнгын хороонд оролцсон гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Нийтийн өргөдлийн талаарх арга хэмжээний тухай” тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн даргад баярлалаа. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна.

“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт, гишүүд ээ.

64,2 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл эцэслэн батлагдлаа.

17.13 цаг

Дараагийнхаа асуудалд орно.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт заасны дагуу анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцогчдын олонх үзсэн тул Байнгын хороо “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөлд холбогдох өөрчлөлт хийж, санал, дүгнэлт гарган та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах, боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжийг нь нэмэгдүүлэх, боловсролын цахим шилжилтийн үйл ажиллагааг дэмжих, нийслэл, орон

нутгийн боловсролын хүртээмжийг дээшлүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамралтыг нэмэгдүүлэх, тэдний цогц хөгжлийг дэмжих, салбар дундын зохицуулалтыг сайжруулах мөн сургуулийн үдийн хоолны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, ажилчдад зарцуулагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар тус тогтоолын төсөлд тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд Хавдар судлалын үндэсний төвийн 2 дугаар барилгын нэмэлт хөрөнгө оруулалтыг 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусган хэрэгжүүлэх, мөн Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих бүх шатны эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний барилга байгууламжийн жишиг зургийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хүртээмжтэйгээр стандартад нийцүүлэн шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Л.Энх-Амгалан, Хүрэлбаатар нар төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах ажлыг” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр” гэж өөрчлөх зэрэг зарчмын зөрөөтэй санал гаргасныг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцогчдын олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн

байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тогтохсүрэн даргад баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураая. 3 санал байна.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байна. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1. Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

7. Хавдар судлалын үндэсний төвийн 2 дугаар барилгын нэмэлт хөрөнгө оруулалтыг 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусган хэрэгжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд.

Саналаа тайлбарлаж үг хэлж болно. Шатарбалын Раднаасэд гишүүн үг хэлье.

Ш.Раднаасэд: Надад асуулт юу алга. Би зүгээр “баярлалаа” гэж хэлэх гэсэн юм. Ялангуяа ажлын хэсэгт, Эдийн засгийн хөгжлийн сайд, энэ Барилгын сайд нарт. Энэ цаашдаа энэ зураг төсөв иж бүрэн болж, ямар ч байсан хавдрын эмнэлгийг эхлүүлэх төсвийг 6 блок, нийтдээ 600 гаруй хүн, 600 ортой эмнэлгийг эхлүүлэх төсвийг бол Улсын Их Хурал эхлүүлэх хэмжээний төсвийг нь төсөв дээр тавьж өглөө. Ирэх жилийн. Энэ цааш цаашдаа хуваагдаж ямар ч байсан ойрын 2 жилийн дотор энэ эмнэлэг баригдаж дуусах ёстой гэж харж байгаа. Тэгээд энэ дээр энэ ажлын хэсэг бас Тогтохсүрэн даргадаа, Засгийн газрын

гишүүддээ бас “баярлалаа” гэдгээ л хэлэх гэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Раднаасэд гишүүн дэмжиж, үг хэллээ.

Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

67,9 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

8. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих бүх шатны эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний барилга байгууламжийн жишиг зургийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хүртээмжтэйгээр стандартад нийцүүлэн шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа. Санал хураалт.

64,8 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах ажлыг” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Чимэдийн Хүрэлбаатар. Санал хураалт.

63 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

Ажлын хэсэг, гишүүдэд баярлалаа.

17.20 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ